

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2015 ОНЫ ДОЛООДУГААР САР

Лиахона

An oil painting of a fisherman standing on the deck of a fishing boat. The fisherman is wearing a tan hat, a light-colored jacket, and brown boots. He is holding onto a rope with his right hand and looking out at the sea. The background shows the complex rigging of the boat and the churning water.

**Анхдагчдын өв: Сэтгэлийн
зангууны найдвар, 14-р хуудас**

**Бүгд алдагдаагүй: Бошиглогч Иосефийн
амьдралын сургамжууд, 20-р хуудас**

Ёс бус дэлхийд зөв шударга амьдрах нь, 26-р хуудас

Ариун сүмд бэлтгэх нь, 56, 76, 78, 79-р хуудсууд



*“Тиймийн тул, эдгээр үгсийг минь сонсоод, үүний дагуу үйлдэгч али-
ваа хүн хадан дээр байшингаа барьсан мэргэн хүнтэй би зүйрлэгдэнэ:
“Бороо орж, үер буун, салхи салхилж, байшинг нүдсэн боловч тэр нь
нурсангүй. Учир нь байшин хадан дээр суурилагдсан байв.”*

Матай 7:24-25



ЗАХИАСУУД

- 4 Тэргүүн Зөвлөлийн захиас
бичиг: Бүгд нам гүм тайван
байна
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
- 7 Айлчлагч багшийн захиас
бичиг: Есүс Христийн
тэнгэрлэг зан чанарууд—
Өршөөнгүй ба нигүүлсэнгүй

ХАВТСАН ДЭЭР

Зураг чимэглэлийг Дан Бөрр, Нүүрний
дотор талын гэрэл зургийг Робби Жорж/
National Geographic Creative, Арын
хавтасны дотор талын гэрэл зургийг
Ричард М.Ромни.

ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 14 Анхдагчид: Өнөөдрийн
зангуу
Ахлагч Маркус Б.Наш
*Анхдагчдын сүнс өнөөдөр
бидэнд хэрхэн зангуу
болдог талаар суралц.*
- 20 Мормоны Ном ирсэн нь
Мэттью С.Холланд
*Та нар Иосеф Смит шиг
Бурханы мутар дахь хү-
чирхэг зэмсэг байхын тулд
төгс амьдралаар амьдрах
шаардлагагүй.*
- 26 Зөв шударгын шагналуудыг
хураан авах нь
Ахлагч Квинтин Л.Күк
*Бид гэр бүлдээ зөв шударгын
шагналуудыг хэрхэн хурааж
чадах вэ?*
- 34 Шашин ба засгийн газар
Ахлагч Вилфорд В.Андэрсэн
*Хожмын үеийн гэгээнтнүүд
хаана амьдарч байгаагаасаа
үл хамааран сайн иргэд байх
үүрэгтэй.*

АЛБАД

- 8 2015 оны 4-р сарын чуулганы
тэмдэглэлээс
- 10 Бид юунд итгэдэг вэ: Сүмийн
зохион байгуулалт бол
тэнгэрлэг юм
- 12 Сүмийн мэдээ
- 38 Хожмын үеийн
гэгээнтнүүдийн дуу хоолой
- 80 Биднийг дахин уулзалт:
Хоньчид ба хурганууд
Ерөнхийлөгч Жэймс Э.Фауст

46



42 Амьдрал ба эрч хүчээр дүүргэгдэв

Рандал А.Райт

Энэ хэвшлийг амьдралдаа хэрэгжүүлж, илүү сайн эрүүл мэнд, эрч хүч, сүнслэг удирдамжийг хүлээн ав.

46 Унгар дахь хүч чадлын баганууд

Маккэллэ Жорж

Есүс Христийн сайн мэдээ Унгарын залуучуудад итгэл, найдвар, хүч чадал авчирдаг.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санамж: Энэ мөрийг дуусга: “Би ариун сүм харах дуртай. . .”



48

48 Есүс Христ—Энх Амгалангийн Ханхүү

Ахлагч Рассэлл М.Нэлсон

Үнэн ба мөнхийн амар амгалангийн эх сурвалж нь Есүс Христ юм.

51 Нүдээ олсон хариулт

52 Мелкизедек санваар хүлээн авахад бэлэн үү?

Санваарын тангараг ба гэрээний талаар илүү их сурамцаарай.

56 Их Эзэний өргөөнд ороход бэлтгэх нь

Ахлагч Кент Ф.Ричардс

Та нар сүнслэг байдлын хувьд бие даах чадвараа дээшлүүлснээр ариун сүмд ороход бэлтгэхийг хүсэх болно.

60 Уучлах арга замаа олох нь

Бонни Браун

Сэтгэлийн шаналлаасаа ангижрах боломжгүй үед хэрхэн уучлах вэ?


62 Зурагт хуудас: Нарны гэрлийг түгээ

63 Дуу хөгжим миний амьдралд

Сабрина дэ Соуса Тэйкшэра

Би авъяас чадвараа хуваалцахын тулд айдсаа даван туулсан.

66



64 Би найзтайгаа ярьж байгаа юм шиг л Бурхантай ярьдаг байв

Ахлагч Хуан А.Юседа

Тэнгэрлэг Эцэг чиний хамгийн сайн найз байж чадна. Түүнд хандан залбир, Тэр сонсох болно.

66 Аннагийн аялал

Жэссика Ларсэн

Аннаг Америкт ирэхэд тэр хэнийг ч танихгүй, бас хэн ч түүний ярьдаг хэлээр ярихгүй байв. Тэгээд тэр ээжийнхээ залбирах хэрэгтэй гэсэн зөвлөгөөг санав.

70 Тэнгэрлэг Эцэг миний залбирлуудыг сонсож, хариулдаг

Жорж Р.

Би мацаг барьж, залбирснаар үеэлдээ тусалж чадна гэдгээ мэдэж байв.

71 Дуу: Ирээд, Намайг дага

Жон Николсон, Самуэл Макбэрни

72 Судрын цаг: Талантын тухай сургаалт зүйрлэл

Жийн Бинхам

74 Бидний хуудас

75 Ариун сүмийн карт

76 Бид ариун сүмд юу хийдэг вэ?

Кэролин Колтон

78 Би хэзээ нэгэн өдөр тэнд очно

Мэри Н.

Би ариун сүмд ороход бэлэн болсон байв

79 Онцгой гэрч: Намайг ариун сүм дотор ороход ямар байх бол?

Ахлагч Нийл Л.Андэрсэн

2015 ОНЫ ДОЛООДУГААР САРЫН ДУГААР, 16, №4 ЛИАХОНА 12567 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,
Дийтр Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн чуулга: Боид К.Пакэр,
Л.Том Пэрри, Рассэлл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,
М.Рассэлл Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хэйлс,
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күк,
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

Эрхлэгч: Крэйг А.Кардон

Зөвлөхүүд: Мэрвин Б.Арнолд, Кристоффэл Гоулдэн,
Ларри Р.Лоурэнс, Жэймс Б.Мартини, Иосеф В.Ситати

Удирдах захирал: Дэвид Т.Варнэр

Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:
Винсент А.Ваун

Сүмийн сэтгүүлийн захирал: Алан Р.Лоиборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карр

Хэвлэлийн туслах: Лиза Кэролин Лопэз

Редакцийн баг: Бриттани Бийти, Дэвид Диксон,
Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Лори Фүллэр,
Гаррэт Х.Гарфф, Ларин Портэр Гаунт, Минди Аннэ
Лийвигт, Майкл Р.Моррис, Салли Жонсон Одэкөрк,
Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу, Ричард М.Ромни,
Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер:

Ж.Скотт Кнудсэн

Зураглал чимэглэлийн удирдагч: Тадд Р.Петрсон
Уран бүтээлийн ажилтнууд: Жанэтт Эндрюс, Фэй
П.Андрус, Мэндэл М.Бэнгли, С.Кимбалл Ботт, Том Чайлд,
Нэйт Гайнс, Коллийн Хинкли, Эрик П.Жонсн, Сюзан
Лодгрэн, Скотт М.Моой, Марк В.Робисон, Брэд Тизери,
П.Никол Вокэнорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэт Нэбэкэр Аун

Хэвлэлийн захирал: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Конни Вауторп Бриж, Жоли Бардэтт, Кэти
Данкан, Брайн В.Гайги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,
Гэйл Тэйт Раффэрти

Хэвлэлийн захирал: Крэйг К.Сэдвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсэн, Нэгдсэн
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга болон үнийн
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт
liahona.lds.org py; шуудангаар *Liahona*, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар
ирүүлнэ үү.

Лиахона нь (Мормоны Номон дахь утгаараа бол “луужин”
буюу “залагч”) албани, англи, армен, бислам, болгар,
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,
свахили, самоа, себуано, солонгос, тагало, тай, тахити,
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр
байна.)

© 2015 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Лиахона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж
болдохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:

July 2015 Vol. 16 No. 4. LIAHONA (USPS 311-480) Mongolian
(ISSN 1525-7584) is published six times a year (January, April,
June, July, October, and December) by The Church of Jesus
Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City,
UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada,
\$6.00 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake
City, Utah. Sixty days' notice required for change of address.
Include address label from a recent issue; old and new address
must be included. Send USA and Canadian subscriptions to Salt
Lake Distribution Center at address below. Subscription help
line: 1-800-537-5971. Credit card orders (Visa, MasterCard,
American Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes
to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368, USA.

Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлэл, үйл ажиллагаануудыг
оруулсан. Доор хоёр жишээ өгөгдсөн болно.



“Мормоны Ном ирсэн нь,” 20-р
хуудас: Иосеф Смит сул дорой зан
чанаруудтай байсан ч тэрээр Аврагчийг
дагахаар хичээх үедээ Их Эзэний мутарт
хүчирхэг зэмсэг болсон юм. Бид ч гэсэн
өсөж хөгжин, Есүс Христэй илүү адил
болохоор хичээх үедээ Их Эзэний мутар
дахь зэмсэг болж чадна. Хувиараа болон
гэр бүлээрээ зарим зорилго тавих талаар
залбирч, бодож үзээрэй. Та нар гэр бү-
лийнхээ гишүүн бүрийн давуу тал, авьяас
чадваруудыг хэлэлцэж, зорилго бүрдээ
хүрэхэд нь бие биенийхээ давуу талыг
хэрхэн ашиглаж болох талаар ярилцаж
болно. Та нар Иосеф Смитийн нэгэн

адил Их Эзэний ажлыг урагшлуулахдаа
өөрсдийнхөө давуу талуудыг хэрхэн
ашиглаж болох талаар бодож үзээрэй.

“Аннагийн аялал,” 66-р хуудас: Гэр
бүлийнхээ түүхээс түүхүүдийг хэрхэн олж,
мөн хадгалахыг гэр бүлийнхэндээ заах
тухай бод. Чи өвөөтэйгөө ярилцаж, гэр
бүлийнхээ тэмдэглэл, бусад баримт бич-
гийг унших юм уу FamilySearch.org вэб-
сайт руу орж үзэж болно. Дараагийн гэр
бүлийн үдшээрээ өвөг дээдэс тань хэрхэн
баатрууд байсан талаар хуваалцаж мөн
ярилц. Түүхүүдээ FamilySearch.org вэб-
сайт дээрх “Дурсамжууд” хэсэгт нэмж
оруулах талаар бодож үзээрэй.

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиахона болон Сүмийн бусад материалыг олон хэлээр languages.lds.org хаягаар
орж үзэж болно.

ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заана.

Авьяас, 63, 72

Ажил хөдөлмөр, 4

Аз жаргал, 26

Айлчлагч багшлалт, 80

Амар амгалан, 26, 40,
48

Анхдагчид, 4, 14, 66

Ариун сүм, 56, 75, 76,
78, 79

Гэр бүл, 26, 64, 66

Гэрийн багшлалт, 51, 80

Есүс Христ, 48

Залбирал, 64, 66, 70

Засгийн газар, 34

Зөв шударга байдал, 26

Илчлэлт, 42

Иосеф Смит, 20

Итгэл, 14, 20, 38, 40, 41,
63, 66, 70

Мацаг барих нь, 70

Мормоны Ном, 20

Найдвар, 14, 46

Нигүүлсэл, 7, 20

Нэгдмэл байдал, 14

Өршөөл, 7, 51, 60

Өөдрөг үзэл, 4

Санваар, 52

Сорилтууд, 20, 40, 66, 70

Судрууд, 20, 40

**Сүмийн зохион
байгуулалт,** 10

Үнэнч шударга

байдал, 38

Хөгжил цэцэглэлт, 26

Хөрвөлт, 39

Шашин, 34

Эрүүл мэнд, 42



Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх
ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф

БҮГД НАМ ГҮМ ТАЙВАН БАЙНА

Анхдагчдын өвийн талаар бодох үед сэтгэлийг минь хөдөлгөдөг нэг зүйл бол “Ирцгээ, ирцгээ, гэгээнтнүүд ээ” (Дууны ном, 2-р х.) дуулал билээ. Тэд Солт Лэйкийн хөндий рүү хийсэн урт удаан аяллынхаа үеэр энэ дууллыг олонтоо дуулдаг байсан юм.

Эдгээр гэгээнтний бүх зүйл сайн биш байсан гэдэгт би итгэлтэй байна. Тэд өвчин тусаж, халуурч, ядарч, ханиад хүрэн мөн айж, өлсөж, өвдөж шаналж, эргэлзэж, тэр бүү хэл үхэл хагацал үзэж байв.

Тэд “Бүгд нам гүм тайван байна” хэмээн дуулж байхдаа бидний хүндлэн бишрэхээс ч аргагүй тэр хандлагыг хөгжүүлж байсан юм. Тэд зовлон бэрхшээлүүдийнхээ цаана байгаа мөнхийн адислалуудыг харж байв. Тэд нөхцөл байдлуудаа талархаж байв. Тэдэнд хэцүү бэрх зүйлүүд тохиолдож байсан ч тэд бодгалийнхаа бүхий л эрч хүчээр “Бүгд нам гүм тайван байна” гэж дуулж байсан юм.

Хэрэв анхдагчдыг магтах бидний магтаал бидний дотор тусгалаа олохгүй л бол хоосон зүйл байх болно. Тэдний золиослол ба амлалтыг тунгаан бодох үед намайг зоригжуулдаг тэдний зан чанаруудын заримаас дурдъя.

Өрөвч сэтгэл

Анхдагчид нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдлаас үл хамааран бие биенээ анхаарч, халамжилдаг байв. Энэ чанар нь тэдний өсөлтийг удаашруулж, таагүй байдал үүсгэн, хувийн золиослолд болон зовлон зүдгүүрт хүргэж байсан ч тэд бие биедээ тусалж байсан юм.

Бидний амьдарч буй шалгуур ихтэй, ялгаварлан гадуурхагч энэ дэлхий дээр хувь хүний эсвэл нам эвслийн зорилгууд нь бие биенээ асран халамжлах, Бурханы хаант улсыг хүчирхэгжүүлэхээс ч илүү үнэ цэнэтэйд тооцогдож байна. Өнөөгийн нийгэмд тодорхой үзэл суртлын зорилгуудад хүрэх нь бидний үнэ цэнийг хэмжих хэмжүүр шиг харагдаж болох юм.

Зорилго тавьж мөн үүндээ хүрэх нь гайхалтай зүйл байж чадна. Харин зорилгодоо хүрсэн амжилт нь бусдыг үл тоомсорлож, үл ойшоож, эсвэл шархлуулж байж ирсэн бол ийм амжилтын өртөг нь дэндүү хайран байх болно.

Анхдагчид бүлгийнхээ хүмүүсийг харж хандаж байсан ч, араас галт тэргээр ирж байгаа хүмүүст зориулан бас газар тариалан эрхэлж, санаа тавьдаг байлаа.

Тэд гэр бүл, найз нөхдийнхөө давуу талыг мэдэж байв. Тэд бие биенээсээ хамаарч байсан учраас хүчтэй болсон байлаа. Найз нөхөд нэг гэр бүлийнхэн болсон юм.

Бид яагаад уруу таталтыг өөрсдөөсөө холдуулж, оронд нь бие биедээ тусалж мөн бие биенээ хайрлаж, нигүүлсэнгүй байх ёстойг анхдагчид бидэнд маш сайн сануулдаг.

Ажил хөдөлмөр

“Учрах бүхнээс эс халшран ирцгээгээч.”

Энэхүү хэллэг нь ядарч туйлдсан аялагчдын сүлд дуу болсон байлаа. Эдгээр агуу бодгаль хэрхэн шаргуу ажиллаж байсныг төсөөлөхөд ч бэрх юм. Алхах нь тэдний хийдэг байсан хамгийн амархан зүйл байв. Тэд хоолоо олох, тэрэгнүүдээ засах, малаа хариулах, өвчтэй болон сул дорой хүмүүстээ үйлчлэх, ус хайж олох мөн



цаг агаарын гэнэтийн аюул болон хээр талын олон аюулаас өөрсдийгөө хамгаалахын тулд бүгд хамтдаа нэгдэх ёстой байсан.

Тэд өглөө бүр Бурхандаа болон бусдадаа үйлчлэх мөн Солт Лэйкийн хөндийд хүрэх гэсэн дор бүрнээ ойлгосон тодорхой зорилготой сэрдэг байв. Тэдэнд өдөр бүр эдгээр зорилго, зорилт нь ойлгомжтой байдаг байсан бөгөөд тэд юу хийх хэрэгтэйгээ мөн өдөр бүрийн өсөлт нь чухал гэдгийг мэдэж байв.

Өнөө үед бидний хийхийг хүсдэг ихэнх зүйл бидний амархан хийж чаддаг зүйлс болох үед мөн бидний өмнөх зам бага зэрэг бартаатай болсон юм шиг санагдах үед эсвэл налуу газар өгсүүр болох хандлагатай үед замаасаа төөрөх юм уу бууж өгөх уруу таталт тулгардаг. Эдгээр цаг мөчид өвчин эмгэг, саад бэрхшээл, зовлон шаналал тэр бүү хэл үхэл хүртэл тэднийг сонгосон замаас нь зогсоож чадаагүй тэр эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдүүдийг бодох нь бидэнд урам зориг өгч болох юм.

Анхдагчид хүнд хэцүү зүйлсийг хийснээр бие махбод, оюун санаа, сүнс нь хүчтэй болж, хүчирхэгжиж; тэнгэрлэг мөн чанарын тухай ойлголт нь өсөн нэмэгдэж; бусдыг гэсэн өрөвч сэтгэл нь хүчтэй болж байгааг олж мэджээ. Энэ дадал нь тэдний сүнсийг бэхжүүлж,

хээр тал, уулсыг гаталсан тэдний урт удаан аялал дууссаны дараа тэдэнд адислал болсон билээ.

Өөдрөг үзэл

Анхдагчид дуулж байхдаа “Урамтай аялцгаая” гэх гурав дахь сургамжийн үгсийг дуулж байсан юм.

Бид маш их зүйлээр адислагдсан ч заримдаа сэтгэл дундуур байдаг нь бидний өнөө үеийн агуу егөөдлүүдийн нэг юм. Хөгжил цэцэглэлт болон технологийн гайхамшгууд нь биднийг аюулгүй байдал, үзвэр үйлчилгээ, агшин зуурын сэтгэл ханамж, ая тухтай байдлаар хангаж байдаг. Гэтэл бид эргэн тойронд маань маш олон аз жаргалгүй болгох зүйлс байгааг олж хардаг.

Маш ихийг золиосолсон анхдагчид амь зуухад шаардлагатай хамгийн наад захын зүйлс байхгүйгээс өлсөж цангаж байсан. Тэд аз жаргал нь азаар, эсвэл тохиолдлоор ирдэггүй гэдгийг ойлгосон байв. Энэ нь мэдээж бидний бүх хүсэл биелснээр ирдэггүй юм. Аз жаргал бол гадны нөхцөл байдлаас ирдэггүй. Энэ нь бидний эргэн тойронд юу болж байгаагаас үл хамааран дотроос маань ирдэг.

Анхдагчид үүнийг мэддэг байсан бөгөөд тэд ийм ойлголтоор бүхий л нөхцөл байдалд болон зовлон бэрхшээлтэй байх үедээ ч, бүр тэдний бодгаль гүн гүнзгий шаналгасан зовлон бэрхшээл дунд байхад хүртэл аз жаргалыг олж чаддаг байв.

Сорилт бэрхшээлүүд

Бид заримдаа анхдагчдын үзэж туулсан тэдгээр зүйлийг эргэн хараад “Ямар азаар би тэр үед амьдраагүй юм” хэмээн хэлдэг. Гэхдээ, хэрэв эдгээр зоригтой

ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ

Та айлчилж очдог хүмүүстэйгээ хамт “Ирцгээ, ирцгээ, гэгээнтнүүд ээ” (Дууны ном, 2) дууллыг дуулснаар айлчлалаа эхлүүлж болно. Та өөрөө эсвэл таны таньдаг хэн нэгэн хайр энэрэл, ажил хөдөлмөрийн эсвэл өөдрөг үзлийн зарчмуудыг хэрэгжүүлсэн үеийн туршлагаасаа хуваалцаж болно. Хэрэв сүнслэгээр өдөөгдөж байгаа бол та эдгээр зарчмын дагуу амьдарснаар ирэх тэрхүү адислалуудыг гэрчилж, мөн тэд бас үүнтэй адил адислалуудыг хүлээн авч чадна гэдгийг айлчилж очдог хүмүүстээ амлаж болно.

анхдагч өнөөдөр биднийг харах боломжтой байсан бол бид ингэж бодохгүй байх байсан болов уу гэж би боддог.

Цаг үе, нөхцөл байдал өөрчлөгдсөн ч сорилт бэрхшээлүүдтэй тулгарах, Бурханы удирдлаган дор хүнлэг, чинээлэг нийгмээрээ хамтдаа амжилттай амьдрах зарчмууд өөрчлөгдөөгүй юм.

Бид анхдагчдаас Бурханд итгэхийг болон итгэлтэй байхыг сурч чадна. Бид бие биедээ энэрэнгүй байхыг сурч чадна. Бид ажил хөдөлмөр болон аж ахуй эрхлэх нь биднийг зөвхөн материаллаг байдлаар адислаад зогсохгүй бас сүнслэг байдлаар адисалдаг гэдгийг сурч чадна. Бид нөхцөл байдлаасаа үл шалтгаалан

аз жаргалтай байх боломжтой гэдгийг сурч чадна.

Бидний анхдагчдаа хүндэтгэж, тэдэнд талархаж буйгаа харуулж чадах хамгийн шилдэг арга зам бол Бурханы зарлигуудын дагуу итгэлтэй амьдарч, найз нөхдөдөө энэрэл, хайраа харуулах, мөн аж ахуй эрхлэн, анхдагчид өөрсдийнхөө амьдралд хамгийн сайнаар үлгэрлэн харуулсан баяр баясгаланг амьдралдаа тусгах явдал юм.

Бид үүнийг хийснээр олон арван жилийн тэртээд очиж, нэр төртэй анхдагчдын гараас барин, “Бүгд нам гүм тайван байна” хэмээн дуулах тэдний дуу хоолойтой өөрсдийн хоолойг нийлүүлж, хамтдаа дуулах болно. Бүгд нам гүм тайван байна!” ■

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Өдрийн тэмдэглэл хөтлөх

Ерөнхийлөгч Угдорф бидний өнөө үеийг анхдагчдын цаг үетэй харьцуулав. Та нар хээр талыг гатлаагүй байж болох ч та нар бодож байгаагаасаа ч илүү анхдагчидтай адилхан юм. Та нар нигүүлсэл, шаргуу хөдөлмөр, өөдрөг үзлийг харуулж чадна. Бид анхдагчид эдгээр зан чанарыг харуулсан талаар тэдний хөтөлсөн тэмдэглэлүүдээс мэддэг шиг та нарын үр удам ч гэсэн та нарын тэмдэглэлээр дамжуулан та нарыг мэдэх боломжтой болох юм.

Өөрийнхөө талаар бага ч болов зүйл тэмдэглэл дээрээ бичихэд хэдэн минут зарцуул. Та нар хэрхэн гэрчлэлтэй болсон эсвэл Тэнгэрлэг Эцэгийн тусламжаар дамжуулан хэрхэн сорилт бэрхшээлүүдийг даван туулсан гэх мэт сүнслэг зүйлсийн талаар бичиж болно. Та нар бас таны өдөр тутмын амьдрал ямар байсан талаар мэдэхэд нь (та нарын тэмдэглэлийг хэзээ нэгэн өдөр уншиж чадах) ач зээ нартаа тусалж чадна. Та нар сургууль дээрээ ямар төсөл дээр ажиллаж байгаа вэ? Та нарын өрөө ямар харагдаж байна вэ? Танай гэр бүлийн хамгийн дуртай дурсамж юу байдаг вэ?

Та нар өдөр бүр бага багаар бичиж эхлэхдээ Тэнгэрлэг Эцэг анхдагчдыг удирдсан шиг та нарын өдөр тутмын амьдралд мөн хэрхэн тусалдгийг илүү тодорхой хараад зогсохгүй, та өөрийн ирээдүйн үр удамд өв үлдээж байгаа хэрэг юм.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Анхдагчдын үлгэр жишээг дагах нь

Анхдагчдын Тэнгэрлэг Эцэгтээ хайраа үзүүлсэн цөөн хэдэн арга замыг ерөнхийлөгч Угдорф хуваалцав. Чи тэдний үлгэр жишээг дагаж чадна. Чамайг эхлэхэд туслах хэдэн санааг энд бичлээ:

НИГҮҮЛСЭЛ

- ☐ Гунигтай байгаа хэн нэгэнд зурвас бич, эсвэл амттан хийж өг.
- ☐ Дүү нартаа гэрийн даалгавраа хийхэд нь тусалж бай.

АЖИЛ ХӨДӨЛМӨР

- ☐ Зорилго тавь. Энэ сард зорилгодоо хүрэхэд чинь туслах ямар нэгэн зүйлийг өдөр бүр хий.
- ☐ Эцэг эхдээ хоол хийхэд нь тусал.

ӨӨДРӨГ ҮЗЭЛ

- ☐ Амьдралынхаа 10 аз жаргалтай зүйлийг жагсаан бич.
- ☐ Харсан хүн бүр рүүгээ инээмсэглэ.

Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ олж мэдэхээр эрэлхийл. Аврагчийн амьдрал ба үүргийг ойлгох нь хэрхэн Түүнд итгэх итгэлийг тань нэмэгдүүлж, айлчлагч багшийн ажлаар дамжуулан харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг адислах вэ? Нэмэлт мэдээлэл авах бол reliefsociety.lds.org хаягаар орж үзнэ үү.

Есүс Христийн тэнгэрлэг зан чанарууд: Өршөөнгүй ба нигүүлсэнгүй

Энэ бол Аврагчийн тэнгэрлэг зан чанаруудын талаарх Айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

Есүс Христ бидэнд өршөөнгүй бас нигүүлсэнгүй хандсаар ирсэн гэдгийг ойлгох нь бусдыг өршөөж, бусдад нигүүлсэнгүй хандахад бидэнд тусалж чадна. “Есүс Христ бидний төгс үлгэр жишээ юм” хэмээн ерөнхийлөгч Томас С.Монсон хэлсэн. “Түүний амьдрал хайрын өв байлаа. Тэр өвчтөнүүдийг эдгээж, дарлагдсдыг өргөн дэмжиж, нүгэлтнүүдийг аварсан юм. Эцэст нь уурлаж хилэгнэсэн хүмүүс Түүний амийг хөнөөсөн ч ‘Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна’ гэсэн мөнх бус амьдрал дахь хамгийн дээд өрөвч сэтгэлийн мөн хамгийн дээд хайрын жишээ болсон үгс Голгота гүвээн дээрээс цуурайсан юм.”¹

Хэрэв бид хүмүүнийг алдаануудынх нь учир уучлах аваас Тэнгэрлэг Эцэг биднийг түүнчлэн өршөөх болно; Есүс биднээс “та нарын Эцэг өршөөнгүй шиг өршөөнгүй байгтун” хэмээн хүсдэг (Лук 6:36). “Бидний



нүглийн ангижрал тодорхой нөхцөлүүдийг биелүүлснээр ирдэг” хэмээн Тэргүүн Зөвлөлийн ерөнхийлөгч, хоёрдугаар зөвлөх Дийтр Ф.Угдорф хэлсэн юм. “Бид . . . наманчлах ёстой. . . Бид бүгд хэзээ нэгэн цагт өршөөлийн суудалд хүрч, нигүүлслийг хүлээн авахыг гуйж байгаагүй гэж үү? Бид гаргасан алдаа, хийсэн нүглүүдээсээ уучлагдахын тулд сүнснийхээ бүх хүчээр нигүүлслийг эрээгүй гэж үү? . . . Христийн Цагаатгалыг зүрх сэтгэлийг чинь өөрчилж, эмчлэхийг зөвшөөр. Нэг нэгнээ хайрла. Бие биеэ уучил.”²

Нэмэлт судрууд

Матай 6:14-15; Лук 6:36-37;
Алма 34:14-16

ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Хайр бол сайн мэдээний үндсэн зарчим,” 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 109.
2. Дийтр Ф.Угдорф, “Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна,” 2012 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 78, 79, 81; эх хувь дээр тодотгол нэмэгдсэн.
3. Жэффри Р.Холланд, “The Peaceable Things of the Kingdom,” *Ensign*, 1996 оны 11-р сар, 83.



Итгэл, гэр бүл, халамж

Судруудаас

“Бид өршөөгдсөн шигээ бас өршөөх ёстой”³ хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холланд хэлжээ. Үрэлгэн хүүгийн түүх нь өршөөлийн хоёр талын аль алиныг харуулдаг: нэг хүү өршөөгдөж, нөгөө хүү өршөөхөөр хичээдэг.

Бага хүү нь өөрийн өв хөрөнгийг авч, үүнийгээ хурдан үрэн таран хийгээд, өлсгөлөн тохиох үед гахай хариулжээ. Судрууд “тэр өөрөө ойлгож,” гэртээ эргэн ирж, өөрийгөө түүний хүү байх зохисгүй гэдгээ аавдаа хэлсэн тухай өгүүлдэг. Гэвч эцэг нь түүнийг өршөөсөн бөгөөд найр хийж, тарган тугал гаргав. Том хүү нь талбай дээрх ажлаасаа ирээд, уурлажээ. Тэр олон жил зарагдаж, тушаалуудыг нь зөрчиж байгаагүй гэдгээ, мөн “анд нөхөдтэйгөө баярлах үед минь та ганц ишиг ч өгч байгаагүй” хэмээн аавдаа сануулав. Аав нь хариуд нь “Миний хүү, чи үргэлж надтай хамт байсан, Минийх гэсэн бүхэн чинийх шүү дээ. Харин чиний энэ дүү үхсэн байсан. Гэтэл амьдарчээ. Алдагдсан боловч олдлоо. Иймээс бид баярлан цэнгэх ёстой гэв” (Лук 15:11–32-ыг үзнэ үү).

Үүнийг эргэцүүлэн бод

Хэн нэгнийг уучилснаар ямар ач тустай байж болох вэ?

2015 ОНЫ 4-Р САРЫН ЧУУЛГАНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).

Та нар 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулганыг эргэн харахдаа амьд бошиглогч, төлөөлөгчдийн хамгийн сүүлд заасан зүйлсээс сурч, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд эдгээр хуудсыг (мөн дараагийн дугаарууд дахь чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.

БОШИГЛОГДСОН АМЛАЛТ



Ариун сүмийн адислалуудыг үнэлж баршгүй юм

“Бид ариун сүмд очихдоо тэнд хийсэн гэрээгээ санаж байвал тэдгээр уруу таталтыг даван, сорилт бэрхшээлээ тэсэж гарах илүү сайн чадвартай байх болно. Ариун сүмд бид амар амгаланг олж чадах билээ.

Ариун сүмийн адислалуудыг үнэлж баршгүй юм. Би амьдралдаа өдөр бүр талархаж байдаг нэгэн адислалыг хайрт эхнэр Франсис-тайгаа хамт ариун сүмд тахилын ширээний дэргэд өвдөг сөгдөн, биднийг мөнхөд холбосон гэрээнүүдийг хийж байхдаа хүлээн

авсан юм. Миний хувьд бид хоёр дахин хамт байх болно гэсэн мэдлэгээс хүлээн авсан амар амгалан, тайтгарлаас илүү үнэ цэнэтэй адислал үгүй билээ.

“Тэнгэрлэг Эцэг маань биднийг ариун сүмд шүтэн бишрэх сүнстэй, мөн Түүний тушаалуудад дуулгавартай байж, бидний Эзэн Аврагч Есүс Христийн мөрөөр алхахдаа хянамаг байхаар адислах болтугай.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Ариун сүмийн адислалууд,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 93

СУРГААЛЫН ЧУХАЛ ХЭСЭГ



Шашны эрх чөлөөний онцлог чанар

“Бид хожмын энэ өдрүүдэд сүнс-лэг эрх чөлөөний замаар алхахдаа сонгох эрхээ итгэлээр ашиглах нь шашны эрх чөлөөтэй байхаас хамаардаг гэдгийг ойлгох ёстой. . . .

Бид хожмын үеийн гэгээнтнүүдийн хувьд шашны эрх чөлөөний дараах дөрвөн чухал онцлог чанарт найдаж, мөн тэдгээрийг хамгаалах ёстой.

Нэг дэх чухал онцлог нь итгэх эрх чөлөө юм. Хэн ч Бурханы талаар юунд итгэдгээсээ болж хувь хүмүүсээр юм уу, төр засгийн зүгээс ч гэсэн буруушагдан зэмлэгдэж, хавчигдах, эсвэл үг хэлээр доромжлогдох ёсгүй. . . .

Хоёр дахь . . . нь өөрсдийн итгэл бишрэлийн талаар бусадтай хуваалцах эрх чөлөө юм. . . .

Гурав дахь . . . нь шашны байгууллага, сүмийг байгуулж, бусадтай хамт энх тайвнаар шүтэн бишрэх эрх чөлөө. . . .

“Дөрөв дэх . . . нь итгэлийнхээ дагуу амьдрах буюу гэр орон, сүмд төдийгүй олон нийтийн газар итгэлээ чөлөөтэй ашиглах эрх чөлөө юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Роберт Д.Хэйлс, “Сонгох эрхийг хадгалж, шашны эрх чөлөөг хамгаалах нь,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 112

“ГЭР БҮЛ: ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ”



“Миний бодлоор тууштай хамгаалагчид онцгойлон хамгаалж байх ёстой гурван зарчим уг тунхаглалд бий. . . .


“ . . . Бүгд зоригтой зогсож, гэрлэлт, эцэг эх байх эрхийн, мөн гэр орныхоо хамгаалагчид нь байснаар Бурханы хаант улсыг байгуулахад гар бие оролцон тусалцаа. Бид Их Эзэний төлөвлөгөөг хамгаалж, түүний үнэнийг хойч үедээ зааж сургадаг, зоригтой, гуйвшгүй, бат дайчид нь байх ёстой.

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч Бонни Л.Оскарсон, “Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 15, 16


Гэрлэлт ба гэр бүлийн талаар илүү дэлгэрэнгүй унших бол 2015 оны 4-р сарын чуулганы Эмэгтэйчүүдийн нэгдсэн хуралдаан дээрх Чэрил А.Эсплиний “Гэр орноо гэрэл ба үнэнээр дүүргэх нь” хэлсэн үгийн 8-р хуудсыг, мөн Кэрл М.Стэфэнсийн “Бурханы гэр бүл” хэлсэн үгийн 11-р хуудсыг тус тус үзнэ үү.



1. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох гэрлэлт



2. Эцэг, эхийн үүрэг



3. Гэр орны ариун нандин байдал



ЧУУЛГАНЫ ГАЙХАЛТАЙ ТҮҮХҮҮД

Гайхалтай түүхээс илүү, юу нь бидний анхаарлыг татсан бэ? Чуулганаар хуваалцсан олон түүхээс зөвхөн гурвыг доор оруулав:

- Тариачны сургаалт зүйрлэлд дурдсанаар, та ямар төрлийн хөрс вэ? Үүнийг таньж мэдэх нь таны амьдралыг хэрхэн өөрчилж чадах вэ? —Даллин Х.Өүкс, “Тариачны сургаалт зүйрлэл,” 32-ыг үзнэ үү.
- Залуу эхийг Есүс Христийн сайн мэдээнд эргэн ирэхэд ямар хүчтэй туршлагууд тусалсан бэ? —Рөүзмэри М.Виксом, “Итгэлээ сэргээх нь,” 93-р хуудсыг үзнэ үү.
- Эгц хадны ирмэг дээр хэцүү байдалд орсон ах, дүү хоёрын гайхалтай түүх Есүс Христийн Цагаатгалын талаарх бидний ойлголтыг хэрхэн нэмэгдүүлдэг вэ? —Жэффри Р.Холланд, “Шударга ёс, хайр, нигүүлсэл хамтдаа,” 104-ийг үзнэ үү.

Ерөнхий чуулганы үгсийг conference.lds.org-оос уншиж, үзэх эсвэл сонсох боломжтой.

СҮМИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛ ТЭНГЭРЛЭГ ЮМ

Сүмийн шинэ гишүүд санваарын түлхүүрүүд, онцгойлон адислалт, гар тавилт, нас барагсдын төлөөх баптисм, мяочел, Халамжийн Нийгэмлэг гэх мэт урьд өмнө сонсож байгаагүй үг хэллэгүүдийг олонтоо сонсдог билээ. Мөн тэд дикон, патриарх, бишоп, зөвлөхүүд, ариун ёслол, дуудлага, дуудлагаас чөлөөлөх, гэрчлэл, ёслол болон бусад олон танил үг танил бус арга замаар ашиглагдахыг сонсдог.

Хэрэв та ийм нөхцөл байдалд байгаа бол бүү санаа зов. Та нар Сүмд явж, судрууд болон хичээлийн материалуудыг судалж, Сүмийн гишүүдтэй харилцахын хэрээр эдгээр үг хэллэгийг илүү сайн ойлгох

ТӨЛӨӨЛӨГЧИД БА БОШИГЛОГЧДЫН СУУРЬ

“Тийм бол та нар цаашид харь хүмүүс болон гаднын хүмүүс биш, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм;

“Та нар элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс Өөрөө булангийн чулуу нь ажээ.”

Ефес 2:19-20

болно. Энэ үедээ тойргийн эсвэл салбарын гишүүдээсээ асуухдаа бүү эргэлз, тэд танд ойлгомжгүй байгаа ямар ч зүйлийг тайлбарлаж өгөхдөө баяртай байх болно.

Эдгээртэй адил үг хэллэгүүд нь судруудаар болон орчин цагийн бошиглогчдод өгөгдсөн илчлэлтээр ирдэг Сүмийн сургаал, бодлого, дэг журам, зохион байгуулалт гэх мэт зүйлсийг төлөөлдөг учир чухал юм. Аврагч Өөрийн хүслийг Тэргүүн Зөвлөл (Сүмийн ерөнхийлөгч ба түүний хоёр зөвлөх) болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад илчилснээр өнөөдөр Сүмээ удирдаж байна. Сүм өнөөдөр Их Эзэн дэлхий дээр байхдаа Өөрийн сүмийг зохион байгуулсан яг тэр арга замаар зохион байгуулагдсан билээ (Итгэлийн Тунхаг 1:6-г үзнэ үү). Бидэнд Библийн цаг үед байсан шиг бошиглогч, төлөөлөгч, Далын гишүүд мөн хоёр хоёроороо явдаг номлогчид

болон бишоп, орон нутгийн бусад удирдагч байдаг.

Сүмд үйлчилдэг бүх хүн сайн дурынхан юм. Тэд удирдагчдынхаа хүлээн авсан сүнслэг удирдамжаар дуудагддаг (үйлчлэх хүсэлтийг хүлээн авдаг). Цаг нь ирэхээр та дуудлага буюу үйлчлэх үүрэг, боломжийг хүлээн авах болно. Та үүнийг хүсэж хүлээн аваад, хамгийн сайнаараа гүйцэтгэх юм бол Их Эзэн Өөрийнхөө хүүхдүүдэд үйлчлэх таны хүчин чармайлыг адислах болно. Та нар ямар нөхцөлд байдалд байгаагаасаа үл хамааран, үнэ цэнэтэй сүнслэг бэлгүүдээр хувь нэмрээ оруулж чадна. Сүмийн гишүүдийн хувьд, та нар “Христийн биеийн” (1 Коринт 12) нэг хэсэг юм. Таны хувь нэмэр Сүмийн үйл ажиллагаанд чухал билээ. ■

Илүү дэлгэрэнгүй судлах бол, Моронай 6; Сургаал ба Гэрээ 20 болон [lds.org/topics/vэбсайт/дээрх/Сүмийн_зохион_байгуулалт](https://www.lds.org/topics/vэбсайт/дээрх/Сүмийн_зохион_байгуулалт)-ыг үзнэ үү.

Тойргийн удирдагчид ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилдэг (ерөнхийлөгч болон хоёр зөвлөх):



Бишоп ба түүний хоёр зөвлөх нь бишопын зөвлөлийг бүрдүүлдэг бөгөөд тойргийг тэргүүлдэг.



Халамжийн Нийгэмлэгийн ерөнхийлөгчийн зөвлөл нь тойрог дахь эмэгтэйчүүдэд үйлчилдэг бөгөөд тэдний гэр бүлүүдийг хүчирхэгжэхэд тусалдаг.



Ахлагчдын чуулгын ерөнхийлөгчийн зөвлөл болон дээд пристийн бүлгийн удирдагчид нь тойргийнхоо эрэгтэйчүүдэд үйлчилж, гэр бүлүүдийг хүчирхэгжүүлэхэд тусалдаг.



Хүүхдийн хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл хүүхдүүдэд үйлчилдэг ба Залуу эрэгтэй, Залуу эмэгтэйчүүдийн бүлгийн ерөнхийлөгчийн зөвлөл 12-18 насны өсвөр үеийнхэнд үйлчилдэг.



Ням гаргийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөл нь Ням гаргийн ангиудыг хариуцаж, тойрогтоо сайн мэдээг заахад болон суралцах үйл явцаа дээшлүүлэхэд тусалдаг.

СҮМИЙН МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын талаар news.lds.org вэбсайтаас үзнэ үү.



ХҮГ Энэрлийн байгууллага: Үйлчлэлийн 30 жилийн ой

Бусдад үйлчлэх зарчим нь шинэ зүйл биш юм. Бүх эрин үеийн туршид Сүм ядуу болон гачигдалтай хүмүүст туслахад бүхнээ зориулсаар ирсэн билээ.

Одоогоос 30 жилийн өмнө, 1985 оны 1-р сарын 27-нд, Сүмийн гишүүд нэгэн онцгой мацаг барилтаар Этиоп дахь өлсгөлөнд өртсөн хүмүүст туслахаар 6 сая ам.долларыг хандивласан нь энэхүү бүхнээ зориулсан байдлын илрэл болсон юм. Энэ нь ХҮГ Энэрлийн байгууллагын үндэс суурь болсон. Мөн тэр жилийн 11-р сарын мацаг барилт нь өлсгөлөнгийн тусламжид зориулан 5 сая долларын санг босгосон байна. Энэ хоёр удаагийн мацаг барилт өнөө үед уг ажлыг маш их эрчимжүүлсэн юм.

Эдгээр мацгийн тусламжаас хойш 30 жилийн хугацаанд, Сүм зовж зүдэрч байгаа хүмүүст туслахын тулд 1.2 тэрбум долларыг

зарцуулжээ. Үүнд хоол хүнс, орогнох байр, эм, хувцас хунар болон тусламжийн эд зүйлс багтдаг. Үүнээс гадна, ХҮГ Энэрлийн байгууллага нь тэргэнцэр, дархлаажуулалт, цэвэр ус, гэр бүлийн хоол тэжээл, хараа зүйн болон эх нярайн тусламж үйлчилгээ зэрэг урт хугацааны тусламж үзүүлсээр ирсэн. Сүм бүх хандивыг хамгийн үр дүнтэйгээр ашиглахын тулд нэр хүнд бүхий энэрлийн байгууллагуудтай хамтарч ажилладаг.

Ерөнхийлөгч Томас С.Монсон, Сүмийн гишүүдийн хувьд бидэнд өлсгөлөнд нэрвэгдсэн, орон гэргүй, хүнд дарамт үүрсэн хүмүүст туслах үүрэг хариуцлага байдгийг байнга заасаар ирсэн юм. Сүмийн гишүүд энэ үүргээ сайн биелүүлсээр ирсэн. Тэд өөрсдийгөө алдаршуулах юм уу, албан ёсны талархал хүлээлгүйгээр, олон сая цагийн үйлчлэл болон олон зуун сая долларыг

чимээгүй хандивласаар байдаг. Гишүүд хандивын хуудсан дээрх хүмүүнлэгийн санд хандив өргөхөөс гадна ХҮГ буяны ажлуудад хандив өгч, номлолд үйлчилж, сайн найзууд болон хөршүүд байж, халамжийн байгууллага болон орон нутагт сайн дураараа хөдөлмөрлөдөг бөгөөд итгэл хүлээсэн орон нутгийн байгууллагуудын олон мянган хүнд хайр халамж болон цаг заваа зориулж байна.

Тэд үүнийг хийснээр ядуу болон гачигдалтай хүмүүсийг анхаарах талаар Аврагчийн заасан зүйлсийг гүйцэлдүүлж эхэлдэг.

“Учир нь Намайг өлсөж байхад та нар Надад идэх юм өгсөн. Намайг цангаж байхад уух юм өгсөн, Намайг харь хүн байтал урьж оруулсан: . . .

“Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:35, 40). ■



Ариун сүмүүд гэр бүлийн цагийг санал болгож байна

Гэр бүлүүдэд ариун сүмд хамтдаа ороход нь туслахын тулд, одоо удаан хугацаанд хүлээлгүй ариун сүмийн баптисмын усан санд төлөөлөн гүйцэтгэгдэх баптисмуудын цагийг товлох тодорхой цагийн хуваарьтай боллоо. Цаг лавлах, мөн цаг авахаар орон нутгийнхаа ариун сүм рүү залгана уу. ■

Гэр бүлүүдэд зориулсан тусламж

Эцэг, эхчүүдэд порнографтай тэмцэх талаар хүүхдүүддээ заахад туслах гэр бүлийн үдшийн хичээлүүд бэлэн боллоо.

overcomingpornography.org/resources вэбсайт дахь хичээлүүд нь “Миний бие махбод Бурханых,” “Сүнс надад сайн хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгоход тусалж чадна,” “Хэрэв би порнограф үзвэл юу хийх хэрэгтэй вэ?” “Аврагч өршөөхийг хүсдэг ба порнографын шархыг эдгээхийг хүсдэг,” мөн “Бэлгийн харилцааны дотно байдал нь ариун нандин хийгээд сайхан зүйл юм” зэрэг сэдвүүдийг агуулдаг.

Эдгээр эх сурвалж нь ярилцах санаануудаар хангаж өгөх ба ямар нэгэн тодорхой дарааллаар заагдах шаардлагагүй. ■

LDS.org вэбсайт үйлдлүүдээ сайжрууллаа

Шинэ цагаан дэвсгэр өнгө, цэнхэр цэснээс гадна, LDS.org вэбсайт нь энэ жилийн эхээр үйлдлүүдээ сайжруулж эхэлсэн.

Гишүүдэд өөрсдийн улс орны харилцах хуудас дээрх орон нутгийн мэдээллээ олоход илүү хялбар болгож, улс орны болон хэлний сонголтыг байрлууллаа.

Улс орны харилцах хуудас нь одоо LDS.org вэбсайт дээр байдагтай адил судрууд, сургаал, эх сурвалж, мэдээ зэрэг хажуугийн цэсүүдтэй. Энэ нь LDS.org вэбсайтыг нээлгүйгээр орон нутгийн мэдээ болон Сүмийн эх сурвалжууд руу орох, мөн хайж байх явцдаа орон нутгийн мэдээ болон LDS.org вэбсайтын мэдээллийн аль нэгийг сонгох боломжийг олгох болно. ■



Гэр бүлийн үдшийн гол үйл явдлууд

2015 онд гэр бүлийн үдэш түүхэн дэх томоохон хоёр үйл явдлыг тэмдэглэн өнгөрүүлэв.

100 жилийн өмнө, ерөнхийлөгч Жозеф Ф.Смит (1838–1918) болон түүний зөвлөхүүд Сүмийн гишүүдэд хамтдаа өсөж хөгжиж, суралцахын тулд нэгэн орой цаг гаргахыг уриалсан байна. Тэд үүнийг хэрэгжүүлсэн хүмүүс гэр орондоо илүү агуу хайрыг мөн эцэг эхдээ илүү их дуулгавартай байдлыг олж харах болно хэмээн амласан. Гэр бүлийн үдшийн талаарх энэ ойлголт нь бүхэлдээ шинэ зүйл байгаагүй ч, 1915 оны 4-р сарын 27-нд Тэргүүн Зөвлөлөөс гаргасан энэ уриалга илүү өргөн хүрээг хамарч, хэвшил болоход тусалсан юм.

50 жилийн өмнө, ерөнхийлөгч Дэвид О.Маккэй (1873–1970) гэр бүлийн үдэшт дахин илүү анхаарал хандуулж эхлэв. 1965 оны 1-р сард, тэрээр гэр бүл бүрд заагдах долоо хоногийн хичээлүүд бүхий гэр бүлийн үдшийн хамгийн анхны гарын авлагыг гаргасан. 1970 онд даваа гаргийн үдэш нь гэр бүлийн үдэш хийж байхаар санал болгогдсон билээ.

Хэрэгжиж эхэлснээс хойш 100 жил, чухал ач холбогдлыг нь дахин зарласнаас хойш 50 жил өнгөрсний дараа ч гэсэн гэр бүлийн үдэш нь Сүмийн гишүүдийн амьдралд чухал ач холбогдолтой хэвээр байна. ■



Далын
ахлагч
Маркус Б.Наш

АНХДАГЧИД

ӨНӨӨДРИЙН ЗАНГУУ

Анхдагчдыг болон тэдний түүхүүдийг, мөн тэдний итгэл, найдварын үр дүнд ирсэн Бурханы дэмжлэг, аврал, чөлөөлөлтийг санагтун.



Бурханд итгэх итгэлдээ хөтлөгдсөн, Исаак Бартлэтт Наш (дээд талын зурагт; баруун талд нь уран зураг) Солт Лэйк хотод байсан гэгээнтнүүдтэй нэгдэхээр төрөлх хот Уэльсээ орхиж, Атлантын далайг гатлан, хээр талыг туулсан юм.

1832 онд миний эхнэр Шэллигийн өвөг дээдэс Вэлта Брадфорд Хатч болон түүний нөхөр Айра хоёр АНУ-ын Нью Йоркийн Фармэрсвилл хэмээх жижигхэн тосгонд Сенека нуурын ойролцоо амьдардаг байв. Оливер Каудери, Парлей П.Пратт хэмээх номлогчдыг Хатчийн гэрт зочлон очиход Вэлта Мормоны Номыг худалдан авч, тэр даруй уншжээ. Энэ номыг үнэн гэдэгт итгэсэн учир тэр баптисм хүртэхийг хүссэн байна.

Гэвч хавчлага дарамтууд ихэсч мөн эхнэр нь удахгүй төрөх гэж байсан учраас нөхөр нь түүнд түр хүлээхийг зөвлөжээ. Вэлта хүүхдээ төрүүлээд удаагүй байхдаа, голын мөс дөнгөж цөмөрсний дараахан голын усанд баптисм хүртсэн байна!¹

Айра ч бас сайн мэдээний захиасыг сонирхож байлаа. Тэр илүү ихийг мэдэхийг, бас Көртландын ариун сүмийг барихад хувь нэмрээ оруулахыг хүсэж байв. Тиймээс тэр Вэлтатай хамт АНУ-ын Огайогийн Көртланд руу бошиглогч Иосеф Смиттэй уулзахаар морин тэргээр аялжээ. Тэд ирснийхээ дараа бошиглогчийг ойролцоох ойн цоорхойд мод огтолж байгаа хэсэг эртэй хамт байгаа гэдгийг сонсов.

Тэднийг ойн цоорхойд ирэхэд эрчүүдийн нэг нь сүхээ модонд зоогоод, тэдэн дээр ирж, “Хатч ах аа, Би таныг гурав хоног хүлээлээ. Таны авч ирсэн мөнгө ариун сүмийн индэрийг барихад тус болно” гэж хэлжээ.

Энэ хүн Иосеф Смит байлаа. Айра баптисм хүртэж, мөн Вэлта тэр хоёр гэр рүүгээ буцаж очин, хэрэгтэй эд зүйлсээ цуглуулаад, Көртланд дахь гэгээнтнүүдтэй нэгдсэн гэдгийг хэлэх ч шаардлагагүй юм.²

Миний өвөг дээдсийн нэг Исаак Бартлэтт Наш Вэйлст байхдаа Сүмд нэгдсэн бөгөөд Солт Лэйк дахь гэгээнтнүүдтэй нэгдэхээсээ өмнө Атлантын далайг гаталж, хээр талыг туулсан билээ. Тэр ирснийхээ дараа Сүмийн тэргүүлэх ахлагчдын нэгээс: “Энэ цугларалтан дээр амандаа тамхи зажилж байгаа ахлагчид байна, гахай хүртэл энэ хогийн ургамлыг тоохгүй дээ” хэмээн тамхины хэрэглээг шүүмжилж байгааг сонсжээ. Амандаа тамхи зажилж байсан Исаак тамхиа амнаасаа гаргаж, газар хаяад, тамхиндаа “Чам дээр эргэн иртэл эндээ байж бай” гэж хэлсэн гэдэг. Тэр дахин хэзээ ч тамхи татаагүй юм.³

Вэлтад зун болохыг хүлээлгүй, хөлдсөн голд баптисм хүртэхэд нь нөлөөлсөн зүйл юу байсан бэ? Айраг Нью-Йоркоос Огайо руу аялахад мөн гишүүн нь ч болоогүй байгаа Сүмийнхээ барьж байгаа ариун сүмд мөнгө хандивлахад хүргэсэн зүйл нь юу байсан бэ? Исаакийг төрсөн нутгаа орхиж, Атлантын далайг гатлан, хээр талыг туулж мөн тамхи зажлахаа болиход хүргэсэн зүйл юу байв?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008): “Сайн мэдээг хүлээн авсан өвөг дээдсийг маань хөдөлгөдөг байсан тэр хүч нь





Вэлта Брадфорд Хатч
Мормоны Номыг үнэн
гэдэгт итгэсэн учир
ирэх зуныг хүлээлгүй,
хөлдсөн голд баптисм
хүртэхийг хүссэн.

Бурханд итгэх итгэлийн хүч байсан юм. Египетээс гарч, Улаан тэнгис дундуур явсан хэсэг, цөлд хийсэн урт удаан аялал, Амлагдсан нутаг дахь Израилийн зохион байгуулалт гэх мэт зүйлсийг боломжтой болгосон нь үүнтэй адил хүч байсан юм”⁴ гэж хэлжээ.

Итгэл бол үйлдэл ба хүч чадлын аль алиных нь зарчим юм.⁵ Энэ нь “зүйлүүдийн талаар төгс мэдэлтэй байх бус юм” (Алма 32:21). Харин энэ бол биднийг үйлдэхэд (Иаков 2:17–26; 2 Нифай 25:23; Алма 34:15–17) болон Аврагчийг дагахад мөн золиослол, зовлон бэрхшээлтэй цаг үед хүртэл бүх зарлигийг дагахад (Ифер 12:4–6) хүргэдэг Сүнсний “баталгаа” мөн (Еврей 11:1, зүүлт тайлбар 6-г үзнэ үү).⁶ Өглөө нар мандах нь тодорхой байдаг шиг итгэл нь сайн зүйлсийг тохиолгох найдвар төрүүлж (Моронай 7:40–42-ыг үзнэ үү), биднийг дэмжих Их Эзэний хүчийг авчирдаг.⁷

Хэрэв итгэл нь бидний анхдагч өвөг дээдсийг хөдөлгөгч хүч байсан юм бол итгэлээр бий болсон найдвар нь тэдний түшиг тулгуур байсан юм. Моронай:

“Итгэлээр бүх зүйл гүйцэлддэг—
 “Иймийн тул, Бурханд итгэдэг хэн

боловч, илүү сайн дэлхийд, тийм ээ, Бурханы баруун гар талд байх нэгэн байрны төлөө лавтайяа найдаж болох, уг найдвар нь итгэлээр ирж, хүмүүсийн бодгальд зангуу болдог, тэр нь тэднийг тууштай мөн хөдөлшгүй сайн үйлээр үргэлж дүүрэн бас Бурханыг алдаршуулахад удирдагдах болгодог” (Ифер 12:3–4) хэмээн бичсэн.

Христэд суурилсан анхдагчдын итгэл нь тэднийг зөвхөн өөрсдийнхөө төлөө биш, харин үр удмынхаа төлөө—ирэх илүү сайн зүйлсийн төлөөх найдвараар үйлдэхэд хөтөлсөн билээ. Тэд энэ найдварынхаа ачаар, ямар ч зүйлээр дутагдаж, гачигдлаа ч гэсэн Бурханыг алдаршуулахаар удирдагдан, тууштай мөн хөдөлшгүй байв. Хөдөлшгүй итгэлтэй байсан тэдэнд Бурханы хүч гайхамшигт арга замуудаар илэрхийлэгдэж байлаа.

Эдгээр анхдагч өнөөдөр бидэнд хэрхэн зангуу болж чадах вэ? Би гурван зөвлөгөө өгье.

Анхдагчдыг сана

Анхдагчдыг болон тэдний түүхүүдийг, мөн тэдний итгэл, найдварын үр дүнд

ирсэн Бурханы дэмжлэг, аврал, чөлөөлөлтийг санагтун. Анхдагч эцэг, эх маань гэрээт хүмүүсийн хувьд бид хэн бэ гэдгээ мэдэхэд бидэнд тусалдаг бөгөөд бидний гэрээнд орсон мөн “өөрчлөгдөх нь үгүй” (Мормон 9:19) бидний Бурхан анхдагч өвөг дээдсийг маань адисалж байсныхаа нэг адилаар хүнд хэцүү, сорилтын цаг үеүдэд биднийг ч бас адислах болно гэдгийг баталдаг билээ.

Бурхан “[бидэнд] өгөх тэр бүх амлалтуудаа гүйцэлдүүлэх болно, учир нь тэрээр [бидний] эцэг өвгөдөд өгсөн амлалтуудаа гүйцэлдүүлсэн билээ” (Алма 37:17) хэмээн Алма заасан юм. Үүнийг мэдсэнээрээ бид, үүнтэй адил итгэлтэйгээр үйлдэх сүнслэг урмыг анхдагчдаас авах бөгөөд найдвараар бөхлөгдөх болно.

Энэ бол түр зуурын зовлон зүдгүүртэй дэлхийд бидний ёс суртахуун, сүнслэг байдлын хувьд эрэлхийлдэг тэр зангуу буюу Христэд итгэх итгэлтэйгээр амьдарч, урагшлах, мөн Түүний арга замуудаар биднийг тогтоодог тэрхүү найдвар юм.

Вилли, Мартин хоёрын гар тэрэгний багийнхны түүх эртний анхдагчдын итгэл, найдварын бэлгэдэл болсон юм. Багийн 1000 орчим гишүүнээс ердөө 200-аад хүн нас барсан нь гайхалтай.⁸ Тэнгэрлэг тусламжийн ачаар итгэл, найдвараар дүүрэн аврагчдын хичээл зүтгэл гар тэрэгний багийнхныг аварсан юм.⁹

Солт Лэйкийн хөндийг орхисныхоо дараа аврагчид гар тэрэгний багийнханд тулгарсантай адил эхний, хахир ширүүн өвлийн шуургатай нүүр тулав. Байгалийн хахир ширүүнтэй нүүр тулсан аврагчдын зарим нь итгэлдээ эргэлзэж, итгэл найдвараа алдан, эргэж буцаж байлаа.

Харин Рэддик Олрэд аврах өртөөг гурван долоо хоногийн турш өвлийн цаг агаарын аюултай нөхцөлд тогтвортой байлгажээ. Өөр нэгэн аврагч Олрэд ахыг түүнтэй хамт буцахыг ятгасан боловч Рэддик татгалзсан бөгөөд:

“Би түүний саналаас татгалзаж, харин ч . . . биднээс шалтгаалж байгаа багийнхныхаа амийг аварч үлдэхийн тулд үлдэхийг түүнд зөвлөсөн” гэж тэмдэглэлдээ бичсэн байдаг. “Дараа нь тэр . . . өртөөний удирдагчийн хувьд бид юу хийх ёстойгоо

мэдэж авахын тулд намайг Их Эзэний үгийг хүлээн авах ёстой гэж тэд надад итгэл хүлээлгэдэг гэж хэлсэн юм. [Их Эзэн] [биднээр] юу хийлгэхийг хүсэж байгаага аль хэдийн хэлсэн учраас би үүнээс татгалзсан.”¹⁰

Сорилт бэрхшээлтэй цаг үед ийм гуйвшгүй итгэлтэй байх нь тууштай, гуйвшгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг бий болгож, шуурга ширүүсэх үед итгэл найдвар өгдөг. Ийм итгэлийн үр жимснүүдийн нэг нь бусдыг асран хамгаалж, аварч, адисалснаар үүнийг эзэмшиж байгаа хүмүүс юм. Гар тэрэгний аяллынхан Рэддик Олрэдийн өртөөнд ирж байгааг харах үед түүнд ямар халуун дулаан мэдрэмж төрснийг төсөөлөн бод доо. Гар тэрэгний аяллынхны түүнийг хараад мэдэрсэн баяр баясгаланг төсөөлөөд үз!

Тэдний нэгдмэл байдлыг санагтун

Анхдагчид үндсэндээ нэгдмэл байсан гэдгийг сана. Хожмын үеийн гэгээнтнүүдийн баруунаас ирсэн нүүдэл нь Америкийн баруун хэсгээс ирсэн бусад нүүдлээс огт өөр байсныг түүхчид ажигласан байна.

“Тэд үнэндээ баруун зүгийн нүүдлүүдийн түүхэнд хэзээ ч сонсогдоогүй дэг журамтай, эв санааны нэгдэлтэй, сахилга баттай, нэгдмэл хүмүүс байсан юм. . . .

“Калифорни эсвэл Орегон руу цагаачилж байсан хүмүүсийн цөөхөн нь л араасаа ирж байгаа хүмүүст санаа тавьж байв. . . . Мормончууд бол тийм байгаагүй. Анхдагчдын багийнхны хамгийн эхэнд хийдэг байсан зүйл нь түр буудаллахад тохиромжтой болон мод, ус, зүлэг сайтай газруудыг тэмдэглэх ажил байв. Тэд болон тэдний дараагийн багийнхан гүүр барьж, голын өндөр эргүүдийг доош ухан, ажилаж байлаа. Тэд сал завинууд болон бяргааз хийж, тэднийг дараагийн ирэх хүмүүсийнхээ хэрэглээнд зориулан үлдээдэг байв.”¹¹

Ийм ялгаатай байгаагийн шалтгаан нь Сүмийн гишүүд Сионыг барихаар ирсэнд байв. “Мөн хүн бүр ах дүүсээ өөр шигээ хүндлэг, мөн ариун журам хийгээд цэвэр ариун байдлыг [Их Эзэний] өмнө байнга үйлдэгтүн” (С ба Г 38:24). Сион—зөв шударга ёсонд оршин суудаг, тэдний



ДЭЛХИЙД ӨНӨӨДӨР АНХДАГЧИД ХЭРЭГТЭЙ БАЙНА

“Бид өмнөх үеийн анхдагчдын зан төлөвийг тодорхойлдог байсан эрэлхэг зориг, зорилгоо хэрэгжүүлэхийн төлөө тууштай тэмцдэг чанарыг өөртөө бий болгон хөгжүүлж чадах уу? Та нар бас би жинхэнэ ёсоор анхдагчид байж чадах уу? Бид анхдагчид байж чадна гэдгийг би мэднэ. Ай, дэлхийд өнөөдөр анхдагчид хэчнээн их хэрэгтэй байна вэ!

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Дэлхийд өнөөдөр анхдагчид хэрэгтэй байна,” 2013 оны 7-р сарын *Лиахона*, 5.



**Бошиглогч Иосеф Айра Хатч ахтай анх уулзаа-
даа “Таны авчирсан
мөнгө ариун сүмийн
индэрийг барихад тус
болно” гэж хэлжээ.
Бошиглогч онцгой сэт-
гэгдэл төрүүлсэн учраас
Айра баптисм хүртэж,
эхнэртэйгээ хамт Нью
Йоркоос Огайогийн
Кертландад нүүж ирсэн.**

дунд ядуус байгаагүй, нэг зүрх сэтгэл нэг оюунтай хүмүүсийн нэгдэл (Мосе 7:18-ыг үзнэ үү) байсан ба “хөршийнхөө анхаарал тусламжийг эрэлхийлж мөн бүх зүйлийг Бурханы алдар суугийн төлөө бүхнээ зориулж буй хүн бүрийн” (С ба Г 82:19) ачаар бий болох юм.

Энэ нийгмийн болон хамтын үүрэг хариуцлагын талаарх ойлголт нь Бурханы бошиглогчийг дагах нэгдмэл хүчин чармайлтыг бий болгосон билээ. Энэ нь анхдагчдын амжилтын агуу том шалтгаан бөгөөд энэ нь тэдний бидэнд өвлүүлдэг өвийн чухал хэсэг юм. Тэд биднийг Их Эзэний бошиглогчийг даган, нийгмийн болон хамтын үүрэг хариуцлагын тухай ойлголтоор нэг мэт үйлдсэнээр Их Эзэний хүчээр бид ч бас өсөж дэгжих болно гэж шивнэдэг.

Анхдагчдын Сүнсийг өвлүүлэн үлдээ

Бид анхдагчдын алхааг удирдан чиглүүлсэн тэрхүү сүнсийг хүүхдүүдэдээ болон ач зээ нартаа зааж, сургах үүрэгтэй. Бид үүнийг хэрхэн хийж болох энгийн жишээг Эквадорын Отавалогийн Мунозын гэр бүлийнхнээс харж болно. Би 2013

оны 3-р сард Жуан Хосе Муноз Отавало ах, түүний эхнэр Лаура болон тэдний хөвгүүдийн нэг Жуан Амадо нартай Сүмд өнгөрөөсөн цаг хугацааных нь талаар мэдэж авахаар уулзсан юм. Би Муноз ахыг Отавало дахь эхэн үеийн хөрвөгчдийн нэг гэдгийг олж мэдэв.

Муноз ах бага байхдаа испани хэл дээр бичигдсэн Мормоны Номыг олж авчээ. Тэр үүнийг ойлгож чадахгүй байсан ч үүнийг барьж үзэх үедээ гүн гүнзгий хүч болон сүнсийг мэдэрсэн байна. Ах нар нь номыг устгана гэдгийг тэр мэдэж байсан учраас номоо гэртээ нуужээ.

Тэр номоо үе үе нуусан газраасаа гаргаж ирж, барьж үзэх төдийд л номын хүчийг мэдэрдэг байв. Тэр хүнд хэцүү сорилт бэрхшээл, эсэргүүцлийг даван туулж, Сүмд нэгдэн орж, Отавало тосгоноос дуудагдсан хамгийн анхны номлогчдын нэг болсон юм. Хожим нь тэр буцаж ирсэн номлогч эгчтэй гэрлэж, тэд хамтдаа итгэлтэй, сайн мэдээнд төвлөрсөн гэр бүлийг бий болгожээ. Тэр Сүмийн удирдагчаар итгэлтэйгээр үйлчилж, Мормоны Ном болон ариун сүмийн ёслолуудыг

өөрийн төрөлх күйчү хэл дээр орчуулахад тусалсан юм.

Биднийг Муноз ахын итгэлийн түүхийг сонсож байх үед буцаж ирсэн номлогч Жуан Амадо үйлж байв. Аавыгаа ярьж дуусахад энэ сайн хүү: “Би гар тэргээрээ тал газрыг туулсан Хойд Америкийн эртний анхдагчдад талархсаар ирсэн. Тэдний итгэл, үнэнч байдал болон бүхнээ зориулсан байдал нь надад сүнслэгээр нөлөөлж, амьдралын минь туршид гүн гүнзгий нөлөө үзүүлсэн юм. Гэхдээ би өнөөдрийг хүртэл, Отавалод анхдагчид байдгийг, тэр нь миний эцэг эх гэдгийг огт анзаараагүй явжээ! Энэ нь намайг баяр баяслаар дүүргэж байна” гэжээ.

Муноз ах, эгч хоёр, анхдагч байснаар бусдын дагах сайн мэдээний замыг нээж, үзүүлж, мөн үүний дагуу амьдарснаар итгэлийн анхдагчдын өвийг өвлүүлэн үлдээдэг гэдгийг бидэнд заасан юм. Бид Их Эзэнд итгэх итгэлээ тогтмол хөгжүүлж, Түүнд найдах найдвараар өөрсдийн бодгалийг бэхэлснээр “тэр нь тэднийг тууштай мөн хөдөлшгүй сайн үйлээр үргэлж дүүрэн бас Бурханыг алдаршуулахад удирдаг” (Ифер 12:4). Дараа нь бид Рэддик Олрэд шиг амьдралын сорилт бэрхшээлүүдэд төөрөн одсон хүмүүст үйлчлэх болно. Мөн ирээдүй үеийнхэн ийм амьдралын хүч, амар амгаланг биднээс суралцах болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч М.Рассэла Баллард:

“Итгэл, зориггоо харуулахын тулд тоотой хэдхэн юмаа тэргэнд ачаад, тэрэгнүүдээ гараар түрж, 2090 км газрыг явган туулахыг бидний ихэнхээс хүсэхгүй шүү дээ. Өнөөдөр бидэнд тулгарч байгаа сорилтууд өөр, бидний авирах уулс ч өөр, “замаар цэцэг дэлгэрүүлэх” (Исаиа 35:1) хөндий ч өөр юм. . . .

“Бидэнд тулгарч байгаа нэг хүндрэл бэрхшээл бол бид нүгэл хилэнцээр дүүрэн бөгөөд сүнслэг байдалд хайхрамжгүй ханддаг, аминч үзэлтэй, мөн шударга бус явдал, шунал тачаалд живсэн дэлхийд амьдарч байгаа явдал мөн. Өнөөгийн цөл төөрөгдүүлсэн,



Эквадорын Отавало-гийн Жуан Хосе Муноз Отавало болон түүний эхнэр Лаура нар бусдад дагах сайн мэдээний замыг нээж, үзүүлж мөн үүний дагуу амьдарснаар өв өвлүүлдэг гэдгийг бидэнд заасан юм.

зөрчилтэй мэдээллээр дүүрэн байна” гэж гэрчилжээ.

Тэгээд бид Бурханы зарлигуудыг бие-лүүлэх явдалд хайхрамжгүй хандах ёсгүй хэмээн ахлагч Баллард нэмж хэлсэн юм. “Хилэнцэт дэлхийн уруу таталтуудаас зайлсхийхэд өнөө үеийн жинхэнэ анхдагчаас итгэл, тэвчээр хатуужил шаардагдана.”¹²

Бидний хүн нэг бүр мөн адил анхдагч байж, өмнө явж, гэм нүгэл, төөрөгдөл, эргэлзээгээр дүүрэн дэлхийд тэмцэж яваа бусдад зам нээж өгөх шийдвэр гаргах болтугай. Бид анхдагчдыг болон тэдний түүхүүдийг санах болтугай. Тэд нэгдмэл хүч чармайлтаар Сионыг байгуулахаар ирсэн бөгөөд дараа нь бидний уулзах бүтдэд, ялангуяа ирээдүй үеийнхэнд ийм итгэлийг суулгах үүрэг хүлээж, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр урагшилсан мөн Түүгээр дамжин ирэх сайн зүйлсэд найдах найдвараар бэхлэгдсэн амьдралаар өөрс-

дийн амьдралыг “амьд тахил” (Ром 12:1) болгон өргөж, үүнийг хийхээр ирсэн гэдгийг санах болтугай.

Анхдагч байна гэдэг нь “сайныг үйлдэхэд шантрамтгай байхгүй байхыг” (С ба Г 64:33) хэлдэг. Вэлта Хатч мөсөн голд баптисм хүртэж байхдаа ер бусын онцгой зүйл хийж байна гэж бодоогүй нь эргэлзээгүй. Исаак Наш ч гэсэн зажилж байсан тамхиа газар хаяхдаа үүнийг тийм чухал зүйл гэж бодоогүй. Рэддик Олрэдийн хувьд Их Эзэний түүнээс хийгээсэй гэж хүссэн зүйлсийг л хийсэн.

Эдгээр өчүүхэн мөн энгийн зүйлээр агуу их зүйлүүд улиран авчрагдсан юм! Агуу хүчин чармайлтуудад жижиг зүйлс байдаггүй гэдгийг бүтдээрээ санацгаая. Бид сайн мэдээний дагуу амьдарч, бошиглогчийг дагаж, эргэлзэхээсээ илүү итгэлтэй байхыг сонгож, итгэлээ хөгжүүлж, сэтгэлийн зангууны найдварыг бий болгох үед бүтдээрээ бусдын дагах замыг бэлтгэж буй анхдагчид байх болно. ■

2013 оны 7-р сарын 24-нд Солт Лэйк хот дахь Ютагийн анхдагч хөвгүүдийн үүрийн туяа хэмээх үйлчилэл дээр хэлсэн “Анхдагчид--ирээдүйн зангуу” хэлсэн үгнээс эш татав.

ЭШЛЭЛҮҮД

1. *Wandering Home: Stories and Memories of the Hatch Family* (1988), 3-ыг үзнэ үү.
2. *Wandering Home*, 3-ыг үзнэ үү.
3. Исаак Бартаэтт Наш, *The Life-Story of Isaac B. Nash* [nd], 2.

4. Гордон Б.Хинкли, “The Faith of the Pioneers,” *Ensign*, 1984 оны 7-р сар, 5.
5. *Lectures on Faith* (1985); Еврей 11:4–40; Иаков 4:6; Ифер 12:7–22.
6. *Lectures on Faith*, (1985), 69-ийг үзнэ үү.

7. Библийн толь бичиг, “Faith”; мөн Алама 57:19–27; 58:10–13; Мормон 9:8–21; Моронай 7:33–37; Сургаал ба Гэрээ 27:17-г үзнэ үү.
8. Андриу Д.Олсэн, *The Price We Paid: The Extraordinary Story*

of the Willie and Martin Handcart Pioneers (2006), 470.

9. Олсэн, *The Price We Paid*, 473–474-ийг үзнэ үү.
10. Олсэн, *The Price We Paid*, 160-ыг үзнэ үү.
11. Валлэс Стэгнэр, *The Gathering of Zion: The*

Story of the Mormon Trail (1964), 11.

12. М.Рассэла Баллард, “Анхдагчдын итгэл ба тэсвэр хатуужил-тэр үед ба өнөөдөр,” *Лиахона*, 2013 оны 7-р сар, 20, 21.

МОРМОНЫ НОМ

ирсэн нь



*Та нар Иосеф Смит шиг Бурханы
мудар дахь хүчирхэг зэмсэг байхын тулд төгс
амьдралаар амьдрах шаардлагагүй.*

Мэттью С.Холланд

Энэ нь бошиглогч Иосеф Смитийн талаарх цуврал хоёр өгүүллийн сүүлийнх нь юм. “Палмирад хүрэх зам” хэмээх эхний өгүүлэл нь Лиакхона сэтгүүлийн 2015 оны 6-р сарын дугаарт нийтлэгдсэн.

Иосеф Смитийн Палмирад хүрэх зам нь зовлон зүдгүүр, уй гашуу, сорилтуудаар дүүрэн байсан шиг түүний Мормоны Номыг авчрах хүчин чармайлт—нэгэн цагт болсон үйл явц нь түүнийг маш ихээр цөхрөхөд хүргэж байсан юм.

1823 оны 9-р сарын 21-ний орой Иосеф нэг л тогтворгүй байв. Тэр аль сүм нь зөв бэ гэсэн чин сэтгэлийн залбирлынхаа хариуд Бурхан Эцэг болон Түүний Хүү, Есүс Христийг нүүр тулж харснаас хойш 3 жилийн хугацаа өнгөрсөн байв. Тэр өдрөөс хойш тэр “удаа дараа олон мунхаг алдаа гарган, залуу насны сул тал хийгээд хүмүүний төрөлхийн жижиг сажиг сул тал илрэн гарч байв” (Иосеф Смит—Түүх 1:28).

17 настай Иосеф эдгээр алдаа дутагдлаа ойлгон, “түүний бүх нүглүүд хийгээд тэнэглэлүүдийг өршөөнө үү” (Иосеф Смит—Түүх 1:29) хэмээн гуйж залбирсан юм. Иосеф үүний хариуд нэгэн тэнгэр элч орных нь хажууд үзэгдэн, “Их Эзэн намайг, миний гэм нүглүүдийг өршөөсөн хэмээн тэр хэлсэн”¹ гэж Иосеф хэлэв.

Өөрийгөө Моронай хэмээн танилцуулсан тэнгэр элч “алтан ялтсууд дээр бичигдсэн” мөн “үүрдийн сайн мэдээний бүрэн байдлыг” агуулж буй нэгэн ном түүний гэрийн ойролцоо Нью Йоркийн Палмирад хадгалагдсаныг Иосефт хэлжээ. Тэр номтой хамт “мөнгөн хүрээнд суулгагдсан хоёр чулуу—мөн эдгээр чулуунууд Урим ба Туммим гэгчийг бүрдүүлдэг цээжний хуягтай холбогдож,” . . . “Бурхан тэдгээрийг уг номыг орчуулах зорилгын тулд бэлтгэсэн” (Иосеф Смит—Түүх 1:34, 35) байв.

Моронай тэр шөнө, үлэмж их гайхширсан залуу хүүд өмнө нь хэлсэн бүхнээ анхааралтай давтан хэлж, дахин хоёр удаа зочилсон юм. Тэр тухай бүрд “надад сануулга болгон нэмж, (эцгийн минь гэр бүлийн ядуу тарчиг амьдралын үр дагавраас болж) ялтсуудыг баяжих зорилгын тулд эзэмшүүлэхээр Сатан намайг уруу татахыг хичээх болно гэдгийг хэлэв. Үүнд тэрээр надад хориг тавин, бибээр уг ялтсуудыг авахдаа Бурханыг алдаршуулахаас өөр бусад ямар ч сонирхлоос татгалзах ёстой хэмээв, мөн түүний хаант улсыг байгуулахаас өөр ямар нэгэн шалтгааны нөлөөлөлд автагдах ёсгүйг; өөрөөр бол бибээр тэдгээрийг авч чадахгүйг хэлэв” (Иосеф Смит—Түүх 1:46).

Маргааш өдөр нь урд шөнө болсон явдлаас болж Иосеф ядарч, тамирдсан байв. Аав нь түүнийг фермийн ажлаас чөлөөлсөн ба Иосефийг амрахаар гэр

рүүтээ явах үед Моронай түүн дээр дөрөв дэх удаагаа айлчлан иржээ. Тэнгэр элч Иосефт, аавдаа буцаж очоод, үзэгдлийн талаар түүнд хэлэхийг зааварлав. Иосеф дуулгавартай дагажээ. Дараа нь тэр ойролцоох гүвээ рүү явав (Иосеф Смит—Түүх 1:49–50-ыг үзнэ үү).

Иосеф тэр гүвээн дээр ирснийхээ дараа ялтсуудыг хадгалсан, шороонд булагдсан чулуун хайрцгийг хөшиж онгойлгоод, тэдгээрийг гаргахаар завдав. Үүнийг хийж байхад нь нэгэн хүчтэй цохилт түүнийг арагш унагааж, хүчийг нь тамирдуулжээ. Эдгээр ялтсыг яагаад авч чадаагүйгээ асуухад Моронай “Учир нь чи Их Эзэний зарлигуудыг сахьсангүй”² хэмээн түүнд хэлсэн юм.

Тэнгэр элч маш тодорхой сэрэмжлүүлсэн боловч Иосеф эдгээр ялтас нь түүний гэр бүлийн санхүүгийн зовлон зүдгүүрийг шийдвэрлэж болох юм гэж бодсон байв.³ Үүнээс болж, Моронай Иосефт ийм ариун нандин ажлыг хийхдээ цэвэр ариун зорилгоор дуудлагдаа хандахын тулд зүрх сэтгэл, оюун санаагаа бэлдэх, мөн төлөвших 4 жилийн туршилтын хугацаа өгсөн байна.

Орчуулгын ажилд тулгарсан саад бэрхшээлүүд

Дөрвөн жилийн дараа Иосеф бараг бэлэн болсон байв. Гэсэн хэдий ч, ялтсуудыг орчуулахад саад бэрхшээлүүд асар их байсан юм. Шинэхэн гэрлэсэн Иосеф



Иосефийг фермийн ажлаасаа чөлөөлөгдөн, гэр рүүгээ амрахаар явах үед Моронай түүн дээр дөрөв дэх удаагаа айлчилсан юм.

Эммагийн болон өөрийнхөө хэрэгцээг хангахын зэрэгцээ бас түүний тусламжинд найдсаар байсан гэр бүлийнхнийхээ төлөө ажиллах хэрэгтэй байлаа. Магадгүй хамгийн их саад болж байсан зүйл бол Иосефт ялтсуудыг дэлгэн үзүүлэхийг, мөн ялтсыг олж авах гэж сүрдүүлж байсан өргөн хүрээтэй олон нийтийн эсэргүүцэл ба шунахай сэдлүүдтэй учирч байсан явдал юм.

Тэр Палмирагийн дээрэмчид Иосефоос ялтсуудыг үзүүлэхийг шаардаж, биенд нь давирхай түрхэж, өд цацах үед явах ёстойгоо мэдсэн билээ.⁴ Тиймээс 1827 оны сүүлээр Иосеф Эммагийн эцэг эхтэй хамт амьдрахаар ялтсуудаа шошны торхонд хийж, зарим холбогдох эд зүйлийг нь баглаж, өөрийн найз, эртний итгэгч Мартин Харрисаас 50 доллар зээлэн, жирэмсэн эхнэрээ дагуулаад, өмнө зүгийг чиглэн, 161 гаруй км замыг туулан, Пеннсильванийн Хармони руу явжээ. Тэр энэ өөрчлөлт нь тэдний өдөр тутмын ажлыг хөнгөвчилж, Палмирад тархаад байсан шунахай сэдлээс болон өс хонзонгийн тогооноос тэднийг чөлөөлөх байх гэж найдаж байв.

Тэр өвөл нөхцөл байдал хангалттай сайжирсан учраас Иосеф Мормоны Номын цөөн хэдэн хуудсыг орчуулах боломжтой болов. Мартин Харрис Иосефт бичээч хийж туслахын тулд 4-р сард Хармони руу нүүн ирж, орчуулгын ажил жинхэнэ утгаараа эхэлсэн юм. 6-р сарын дундуур буюу Иосеф эдгээр ялтсыг олж авахаар Кумора гүвээ рүү анх удирдуулсан тэр чухал өдрөөс хойш бараг 5 жилийн дараа тэд орчуулгын 116 хуудас гар бичмэлийг дуусгаад байв.⁵

Энэ үед Мартин, өөрийг нь цаг болон эд хөрөнгөө юунд ингэж их үрээд байгааг нотлох зарим баримтыг маш ойлгомжтойгоор харахыг хүссэн эхнэр Люсидээ гар бичмэлийг үзүүлэхийн тулд Палмира руу авч явах зөвшөөрлийг Иосефоос гуйсаар байв. Гэсэн ч, Их Эзэнээс асуусны дараа Мартинд гар бичмэлийг өгч явуулж болохгүй хэмээх хариу Иосефт хоёр удаа иржээ.⁶

Мартин эхнэрийнхээ үл итгэгч байдлыг болон улам хурцдаж байсан шаардлагуудыг нь намжаахын тулд Иосефийг дахин шалав. Зовж шаналсан Иосеф Их Эзэнээс гурав дахь удаагаа асуусан юм. Их Эзэн хариуд нь, Мартин гар бичмэлийг тодорхой таван хүнд үзүүлээд, тэр даруй авчирна гэвэл гар бичмэлийг авч болно гэж Иосефт хэлжээ. Мартин Их Эзэний зааварласны дагуу хийнэ гэж гэрээнд гарын үсэг зурсны дараа Иосеф гар бичмэлийг түүнд дурамжхан өгсөн байна.⁷

Энэ нь Иосефт тохиолдох ямар ч зүйлээс илүүгээр түүнийг сэтгэлээр унагасан, дараалсан үйл явдлуудыг эхлүүлсэн юм. Эмма Мартиныг явсны дараа удалгүй хүү

**Мартин Харрис Смитийн
хашааны хаалган дээр
ирж зогсоод, хашаан дээр
гарч сууж, малгайгаараа
нүүрээ даран суув.**



төрүүлэв. Эмма, Иосеф хоёр 5 жилийн өмнө нас барсан, Иосефийн эрхэм ахыг хүндэтгэж, анхны хүүхдээ Алвин хэмээн нэрлэжээ. Харамсалтай нь, сэтгэлийн шаналлыг нь багасгах учиртай байсан бага Алвин төрсөн өдрөө буюу 1828 оны 6-р сарын 15-нд нас барсан юм.

Төрөхийн өмнөх асар удаан, хүчтэй өвдөлтөөс болоод ядарч туйлдсан, мөн хүүхдээ алдсанаасаа болж сэтгэлээр унасан Эммад тэвчин гарах арга зам байхгүй мэт санагдаж, өөрөө бараг үхлийн аюултай тулгарчээ. Иосеф хоёр долоо хоногийн турш, Алвин хүүгээ алдсандаа гашуудан ажиллаж байхдаа ч, Эммагийн эрүүл мэндэд санаа тавьж, асарч байв. Эммагийн эрүүл мэнд



сайжирч байгааг хараад, Иосеф Мартиныг болон гар бичмэлийн талаар бодож эхэлжээ.⁸

Эмма Иосефийн сэтгэл түгшиж байгааг ойлгож байсан учир түүнийг Мартины хойноос буюу гар бичмэлийн араас Палмира руу явахыг нь дэмжжээ. Тэрээр хойд зүг рүү морин тэрэг хөлслөөд явж байхдаа гунигтай харагдаж байлаа. Иосеф морин тэрэгнээсээ бууж, сэтгэл нь түгшсэн нэгэн зорчигчийг (“үл таних хүнийг”) өрөвдөн, гараас нь түшээд, харанхуй шөнө 32 км алхаж, аяллынхаа турш идэж, унтах боломжгүй явсаар эцэг эхийнхээ гэрт очсон юм.⁹

Иосеф ирснийхээ дараа бага зэрэг тэнхрээд, Мартиныг дуудуулав. Тэрээр Смитийнхэнтэй өглөөний хоол идэх байсан ч үд дунд хүртэл ирээгүй л байв. Тэрээр аажуухан алхлан, хашааны хаалган дээр ирж зогсоод, хашаан дээр гарч, малгайгаараа нүүрээ даран суув.¹⁰

“Бүх юм байхгүй боллоо!”

Эцэст нь Мартин гэрт орж ирэв. Тэрээр нэг ч үг хэлэлгүй хоолоо идэхээр халбага, сэрээ авлаа. Гэвч тэр идэж эхлэхээсээ өмнө “Ай, би сүнсээ алдлаа!”¹¹ хэмээн дуу алджээ.

Үүнийг сонссон Иосеф үсрэн босч: “Мартин, чи гар бичмэлийг алдчихсан юм уу? Чи тангарагаа зөрчиж, миний болон өөрийнхөө толгой дээр шийтгэл авчирлаа гэж үү?” гэж уулга алдав.

“Тийм ээ, алга болчихсон, би хаана байгааг нь мэдэхгүй”¹² гэж Мартин гунигтай хариулжээ. (Мартин “заль мэхэнд автан,” нөгөө таваас өөр хүмүүст гар бичмэлийг үзүүлсэн байв. Иосеф дараа нь “тэдгээр нь түүнээс авагдсан юм” хэмээн дурсан хэлсэн байдаг.”¹³)

Иосеф “Бүх юм байхгүй боллоо! [Б]үх юм байхгүй боллоо! Би одоо яах вэ? Би гэгч амьтан Бурханы уур хилэнг өдөөх нүгэл үйлдлээ” гэж цурхиран уйлж байв. Үүнээс болоод Иосеф энэ бүхэнд хамгийн их шаналан зовж, “уйлах ба ёолох дуу, хамгийн гашуун гашуудал гэрийг нь дүүргэсэн юм.”¹⁴

Орчуулгын ажил хэсэг хугацаанд зогсож, Иосефоос ялтсууд болон орчуулгад шаардлагатай эд зүйлс 9-р сарын 22-ныг хүртэл түүний өмнөх сорилтын хугацааны гашуун сануулга болгон авагдсан билээ. Тэрээр мөн Их Эзэнээс ирсэн энэхүү хатуу зэмлэлд зовж шаналж байв:

“Мөн болгоогтун, Бурханы хуулиуд хийгээд зарлигуудыг чи хичнээн олон удаа зөрчиж, мөн хүмүүний ятгалгад хөтлөгдсөн билээ.

“Учрыг болгоогтун, чи Бурханаас илүүтээр хүмүүнээс айх ёсгүй байсан билээ. Хэдийгээр хүмүүн нь Бурханы зөвлөгөөг үл ойшоон, мөн түүний үгсийг эс хэрэгслээ ч гэсэн тэр—

“Чи итгэлтэй байх ёстой байсан юм; мөн тэрбээр гараа сунган мөн дайсны бүх галт сумны эсрэг чамайг дэмжих байсан юм; мөн гай зовлон тохиолдох бүрийд тэрбээр чамтай хамт байх байсан юм” (С ба Г 3:6–8).

Ийм илчлэлт хүлээн авах ямар хэцүүт төсөөлөн бод доо. Иосеф анхны хүүгээ алдаад удаагүй байв. Тэр хайртай эхнэрээ бараг л алдах дөхсөн. Гар бичмэлийг

Мартинд өгөх түүний хүсэл нь ариун нандин ажлыг хийхэд нь тусалж байгаа найздаа туслахыг хүссэн түүний чин сэтгэлийн хүслээр өдөөгдсөн байв. Тийм ээ, Иосеф хэчнээн их зовж шаналсан ч бай, өөрийгөө Мартин Харрисаас хэчнээн их хараат гэж бодсон ч бай, Бурханы шавь нараасаа бүрэн дүүрэн хүсэн хүлээдэг нэг зүйл болох хүмүүний гарт биш, Их Эзэний мутарт үргэлж итгэх тэр найдварыг алдсан байлаа. Иосеф дахин хэзээ ч ийм алдаа гаргаагүй бөгөөд ийм гүн гүнзгий, бүрэн төгс арга замаар энэ сургамжийг олж авснаараа үүрд үнэлэгдэх учиртай юм. Үүнээс хойш тэрээр удалгүй ялтсуудыг болон орчуулгын хэрэгслүүдээ дахин хүлээн авч, Есүс Христийн хувийн тохинуулаас хойш дэлхийд огт харагдаагүй шашны хувь нэмрээ маш



Мормоны Номыг орчуулж байхдаа Иосеф, Оливер хоёр сургаал номлож, илчлэлтүүд хүлээн авч, тэдгээрийг бичиж тэмдэглэн, мөн баптисм хүртэв.

хурдан эхлүүлсэн билээ. Тэрээр 1829 оны хавраас эхлэн хажуудаа Оливер Каудериг байлган, 65 ажлын өдөрт багтаан Мормоны Номын гайхалтай 588 хуудсыг орчуулсан юм.¹⁵ Энэ хурд нь түүний өмнө гаргаж байсан хүчин чармайлтуудтай харьцуулахад тун гайхалтай байлаа. Бэлтгэгдсэн 47 эрдэмтэн Хаан Жеймсийн Библийн орчуулгыг гэхэд л өөрсдийнхөө сайн мэддэг хэл дээрээ орчуулахад 7 жилийг зарцуулсан гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй юм.¹⁶

Цаашилбал, Иосеф, Оливер хоёр энэхүү асар том ажлынхаа дундуур сургаал номлож, илчлэлтүүд хүлээн авч, тэдгээрийг бичиж тэмдэглэн, Аароны болон Мелкизедек санваарыг сэргээхэд оролцож, баптисм хүртэж, гэр орныхоо үүрэгт ажлуудад хүртэл оролцож байсан бөгөөд мөн гар бичмэлээ хэвлүүлэхээр Нью-Йоркийн Фейетте рүү нүүсэн билээ. Гэвч энэ бүгдийн хамгийн гайхамшигтай зүйл нь хэр зэрэг хурдан гүйцэтгэсэнд биш, харин маш их хугацаа шаардагдах ийм нарийн түвэгтэй орчуулгыг хийсэнд оршино.

Гайхалтай, цогц ном

Иосеф эдгээр орчуулгын ажлын 65 өдөрт юуг үр дүнтэй хийсэн тухай саяхан нэгэн эрдэмтний дүгнэн хэлснээр энд оруулав: “[Мормоны Номон дахь] түүхийн олон мянган жилийн турш дахь хоёр зуун хүний нэр болон бараг зуугаад өөр газрын нэрсийг багтаасан, бас түүх нь гурван үндсэн редактор/түүхчийн буюу Нифай, Мормон, Моронай нарын ажлаар танилцуулагдсан ийм ном түүхэнд байхгүй билээ. Эдгээр тоо нь эргээд, урьд өмнө бичигдсэн хэдэн арван түүх дээр үндэслэгдсэн гэж үздэг. Үр дүн нь шууд ярианаас эхлээд, номлол, захидал, судрын тайлбар, шүлэг хүртэл багтсан, олон уран бүтээл тусгасан цогц хослол юм. Энэ нь цаг тоолол, газар зүй, угийн бичиг болон эх сурвалжийн цэдгүүдийн бүх нарийн ширийн зүйл дээр ажиллах ихээхэн тэвчээр шаардаг ч Мормоны Ном бол энэ бүхэнд гайхалтай нийцдэг. Өнгөрсөн үйл явдлын дараалал хэд хэдэн удаа алдагдаж, түр давхардсан өгүүлэгчтэй байсан ч, үнэндээ энэ цаг тоолол нь өчүүхэн ч хүндрэлгүйгээр өвлөгдөн ирсэн билээ; . . . Мөн өгүүлэгчид нь нифай үндэстний хорин зургаан түүх бичээч болон жаредчуудын дөчин нэгэн хааны дундах (өрсөлдөгч үеийнхнийг багтаасан) он тоолол ба гэр бүлийн холболтын аль алиныг маш сайн хангаж өгсөн юм. Иосеф Смитийн эхнэр, тэр орчуулахаасаа өмнө ямар нэгэн зүйл чээжилдэггүй, эсвэл орчуулж байхдаа зөвлөлддөггүй гэж маш тодорхой үгүйсгэсэн хэдий ч, зохиогчийг хүснэгтэнд эсвэл газрын зурган дээр ажилаасан байх магадлалтай хэмээн сэрдэж, асуудал үүсгэдэг байв. Эмма Иосефийг гар бичмэлүүдийг харалгүй, чээжээр бичүүлдэг байсан, мөн бичүүлсэн зүйлээ сүүлд нь эргэн хардаггүй байсан хэмээн мэдэгдсэн билээ.¹⁷

Нарийн түвэгтэй уран зохиолын бүтэц, эртний ёс заншлуудтай зохицож буй гайхалтай харьцуулалт, ном ба үүний орчуулгатай холбоотой бусад зүйл доторх харилцааны хэлбэрүүдийн талаар хэлэх зүйл юу байх билээ.¹⁸



Ийм зүйлтэй тулгарсан үед хэн нэгэн хүн, тэр тусмаа ямар ч албан ёсны боловсролгүй хүн ийм гавьяаг хэрхэн байгуулсныг зүгээр л асуух ёстой. Миний бодлоор Иосеф Смит Мормоны Номыг зохиогоогүй. Яагаад гэвэл тэр зохиож ч чадахгүй юм. Гэвч энэ учир шалтгаан нь хүчтэй мэт санагдаж болох ч үндсэндээ энэ номын бодит байдлын шийдвэрлэх баталгаа нь бөгөөд миний гэрчлэлийн үндэс суурь болж ч чадахгүй байх байсан. Энэ нь хэдэн жилийн өмнө намайг бүрэн цагийн номлогч байх үед Сүнсний надад заасан зүйлийг хүчирхэгжүүлдэг. Би Провогийн Номлогчийг бэлтгэх төвийн ариун нандин ханануудын дунд болон Шотландын ногоон хөндийд Иосеф Смит Бурханыг дуудсаныхаа дараа хүлээн авсан тэрхүү сүнслэг гэрчийг хүлээн авсан юм. Тэр бол хожмын өдрүүд дэх Түүний зэмсэг бөгөөд түүнийг төрөхөөс ч өмнө оршиж байсан тэр номыг авчирсан билээ. Энэ ном нь—харьцуулшгүй аз жаргалтай бурханлаг амьдралд үнэ цэнэтэй, ер бусын үнэн ном билээ.

Би ч бас Иосеф Смитийн амьдрал бол энэ номын талаарх нэгдмэл захиасын хурц гэрчлэл гэдгийг тунхаглаж байна. Мормоны Номыг нээх үед Нифай “Тэвч болгоогтун, итгэлийнх нь учир бүр тэднийг аюулаас ангижрах чадалтай болтол нь хүчтэй болгохоор сонгосон бүгдийн дээр Их Эзэний нигүүлсэл байдгийг би, Нифай та нарт үзүүлэх болно” хэмээн тунхагладаг билээ (1 Нифай 1:20; тодотгол нэмэгдсэн). Энэ номыг хаах үед Моронай “Болгоогтун, та нар эдгээр зүйлийг уншихдаа . . . Адам бүтээгдсэнээс бүр та нар эдгээр зүйлийг хүлээн авах тэр цагийг хүртэл Их Эзэн хүмүүний үрсэд хичнээн нигүүлсэнгүй байсаар буйг та нар санан мөн үүнийг зүрх

сэтгэлдээ тунгаахыг та нарт ухуулъя би” (Моронай 10:3; тодотгол нэмэгдсэн) хэмээн мэдэгддэг юм.¹⁹

Эхлэлээс төгсгөл хүртэлх Мормоны Номын гэрчлэл ба түүх нь Бурхан Өөрт нь жинхэнээсээ гэмшиж, итгэсэн байдлаар Түүнд эргэн хандавал, тэдний гэм нүгэл болон төгс бус байдлаас үл хамааран тэдэнтэй ажиллаж, тэднийг эдгээж, адислахыг хүсдэг гэдгийг харуулдаг билээ.

Бурханд итгэл найдвараа тавь

Та нар Иосеф Смит шиг Бурханы мутар дахь хүчирхэг зэмсэг байхын тулд төгс амьдралаар амьдрах шаардлагагүй. Алдаа, уналт, эргэлзээ зэрэг нь Иосефийн амьдрал ба номлолын нэг хэсэг байсан шиг тэдгээр нь та нарын амьдралд ч гэсэн тохиолдох болно. Бүү цөхөр. “Бүгд үгүй боллоо” гэж бодож, бүү уруу татагд. Бүгд үгүй болоогүй бөгөөд нигүүлсэнгүй Бурханд найдан амьдрах тэдний хувьд хэзээ ч үгүй болохгүй байх болно.

Та нарыг харж халамжилдаг, та нарыг аврахад бэлэн байдаг, бас та нарын гараас хамаагүй илүү хүчтэй—үнэндээ бүх махбодоос ч илүү хүчтэй гараараа та нарын үйлчлэлийг урагшлуулах Ах та нарт байгаа билээ. Тэдгээр мутар “гай зовлон тохиолдох бүрийд” (С ба Г 3:8), хэчнээн их ганцаардаж, шантарсан байсан ч та нарыг дэмжиж мөн адислахын тулд байдаг билээ. Тиймээс та нар итгэлээрээ урагшлах үедээ тэдгээр мутарт итгэж, мөн “тууштай, зоригтой бай. Чиний Бурхан Эзэн чамтай хамт явдаг учраас бүү ай . . . ; Тэр чамайг орхихгүй, чамайг хаяхгүй” (Дэд хууль 31:6).

Иосеф үүнийг олж мэдсэн бөгөөд дэлхийг өөрчилсөн юм. Та нар ч бас чадна. ■

ЭШЛЭЛҮҮД

1. In *Histories, Volume 1: 1832–1844*, vol. 1 of the Histories series of *The Joseph Smith Papers*, (2012), 14; мөн josephsmithpapers.org вэбсайтыг үзнэ үү.
2. In *Histories, Vol. 1: 1832–44*, 83.
3. Оливер Каудери, “A Remarkable Vision,” *The Latter-day Saints Millennial Star* 7 (Nov. 1840): 175-ыг үзнэ үү.
4. Мартин Харрис, in *Tiffany’s Monthly*, June 1859, 170-ыг үзнэ үү.
5. *Histories, Vol. 1: 1832–44*,

- 244; Gospel Topics, “Book of Mormon Translation,” lds.org/topics-ыг үзнэ үү.
6. *Histories, Volume 1: 1832–44* 245-ыг үзнэ үү.
7. *Histories, Vol. 1: 1832–44*, 245–246-г үзнэ үү.
8. Люси Мак Смит, *Biographical Sketches of Joseph Smith, the Prophet, and His Progenitors for Many Generations* (1853), 118-ыг үзнэ үү.
9. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 119–120-ийг үзнэ үү.
10. Люси Мак Смит, *Biographical*

- Sketches*, 120-ийг үзнэ үү.
11. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 121-ийг үзнэ үү.
12. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 121-ийг үзнэ үү.
13. In *Histories, Vol. 1: 1832–44*, 247.
14. Люси Мак Смит, *Biographical Sketches*, 121–22-ыг үзнэ үү.
15. Жонн В.Вэлч, “How Long Did It Take Joseph Smith to Translate the Book of Mormon?”-ыг үзнэ үү. *Ensign*, 1988 оны 1-р сар, 47.
16. “King James I of England,” kingjamesbibleonline.org/

- King-James.php хуудсыг үзнэ үү.
17. Грант Харди, *Understanding the Book of Mormon: A Reader’s Guide* (2010), 6–7.
18. Тэрри А.Гивэнс, *By the Hand of Mormon: The American Scripture that Launched a New World Religion* (2002), 156-г үзнэ үү.
19. Грант Харди, *Understanding the Book of Mormon*, 8-ыг үзнэ үү.



Зөв шударгын ШАГНАЛУУДЫГ хураан авах нь

*Тэрээр шулуун шударга явагчдаас
ямар ч сайн юмыг нуудаггүй.*

Бүхэл дэлхий үймээн самуунд байна (С ба Г 45:26-г үзнэ үү). Бидэнд тохиолддог олон сорилт бэрхшээл сүнслэг хүрээнд бий болдог. Хувь хүний хувьд бидэнд өөрсдөө шийдвэрлэж чадахааргүй нийгмийн асуудлууд байдаг. Гэсэн хэдий ч, дэлхий даяар зөв шударга байдал бууран доройтож байгаа энэ үед ч гэсэн, хувь хүмүүсийн хувьд бидэнд олж авч чадах бодит шагналууд бий.

“Зөв шударгын шагналууд”-ын жинхэнэ санаа нь өнөөгийн дэлхий дээрх байр сууринд хамаарах ойлголт юм. Зөв шударгыг сонгоход хүмүүсийг үнэмшүүлэх нь удаан хугацааны турш асуудал болсоор байна. “Эгэл хүн бол Бурханы дайсан” (Мозая 3:19). “Бүх зүйлд үргэлж сөрөг тал” байсаар ирсэн (2 Нифай 2:11).

Өнөөгийн ялгаатай байдал нь “агуу хийгээд нүсэр барилгын” (1 Нифай 8:31) үл итгэгчид миний амьдралын ямар ч цаг үеийнхээс илүү чанга, илүү зөрчилдөөнтэй, тэвчээргүй болж байна. Тэд олон тохиолдолд Бурханы хувьд буруу зүйлийг хийхээсээ илүүтэй, түүхэнд муу нэртэй үлдэхээсээ айсан үедээ өөрсдийнхөө өчүүхэн итгэлийг харуулдаг. Энэ нь хүмүүсийн дийлэнх хувь нь олон нийтийн үзэл бодлоор, эсвэл тэр үеийн зонхилох үзэл санаагаар бус, харин Бурханы зарлигуудаар шүүгдэх болно гэж ойлгодог байсан үе байсан юм. Зарим хүн Бурханд шүүгдэхээсээ илүүтэй, бусдын шүүмжлэлд өртөхөөсөө айж, санаа зовдог.

Сайн, муугийн хоорондын тэмцэл шинэ зүйл биш юм. Гэхдээ өнөөдөр хүмүүсийн дийлэнх хувь нь бүх хүний дагавал зохих ёс суртахууны болон зөв шударгын жишгүүд байхгүй болсон гэж буруу дүгнэж байна.

Гэсэн хэдий ч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм хэзээ ч одоогийнхоос илүү олон итгэлтэй гишүүнтэй байгаагүй юм. Сүмийн гишүүд, өөрсөдтэйгөө адилхан ёс суртахууны эрхэмлэх зүйлс бүхий бусдын хамт эргэлзээ болон итгэлгүй байдлын далай дээрх итгэлийн арлыг төлөөлдөг. Бошиглогч Алмагийн тунхагласнаар “ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй” (Алма 41:10) бөгөөд хүүхдүүдээ зориулсан Эцэгийн төлөвлөгөө нь “аз жаргалын төлөвлөгөө” (Алма 42:8, 16) гэдгийг бид мэднэ.



Арванхоёр
Төлөөлөгчийн
чуулгын
Ахлагч
Квинтин Л.Кук



**Хэрэв бид
болгоомжтой
байхгүй бол
дэлхий бид-
нийг сүнслэг
амлалтуудаас
маань холдуу-
лах зүйлс дээр
анхаарлаа
хандуулахад
нөлөөлөх
болно.**

Би та нарт хувиараа болон гэр бүлээрээ хамтдаа зөв шударгын шагналуудыг илүү сайн ойлгож, тэдгээрийг олж авахад тань тусалж болох зарим зүйлийг санал болгохыг хүсэж байна.

Сүнслэг байдлын шагнал

“Би сүнслэгээр өсөж хөгжихийг хичээх үедээ материаллаг зүйлстэй холбоотой санаа зовнилуудаа хэрхэн зохих байранд нь тавьдаг вэ?”

Энэ дэлхий бидэнд маш их нөлөөлдөг. Өдөр тутмын амьдралын материаллаг талууд тодорхой асуудал болоод байна. Нийгэм бүх зүйлийг дэлхийн шагналуудын жишгээр харах хандлагатай болжээ.

Сургаал ба Гэрээний өмнөх үг нь биднийг аюулаас сэрэмжлүүлж, өөрсдийгөө одоо болон ирээдүйд бэлтгэж, мөн хамгаалах удирдамж өгч, энэ сэдвийн талаар чухал ойлголтууд өгөхийн тулд яг энэ сэдвийг онцолсон юм: “Түүний зөв шударга ёсыг бий болгохын тулд тэд Их Эзэнийг эрэлхийлдэггүй, харин дэлхийнхтэй адил дүр төрх бүхий өөрийнхөө бурхны дүр төрхийг дуурайн хүн болгон өөрийнхөө замаар замнадаг” (С ба Г 1:16-г үзнэ үү).

Ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбалл (1895–1985) хиймэл шүтээнүүдэд диплом, зэрэг дэв, өмч хөрөнгө, орон сууц, гэрийн тавилга болон бусад материаллаг эд зүйл орж болно гэж заажээ. Бид эдгээр зохистой зүйлийг бидний Их Эзэнийг шүтэн бишрэх байдлыг бууруулж, Түүний зөв шударга байдлыг бий болгох, Тэнгэр дэх Эцэгийн хүүхдүүдийн дунд авралын ажлыг гүйцэлдүүлэх бидний хүчин чармайлтуудыг сулруулах тийм арга замаар дээш өргөх юм бол хиймэл шүтээнүүдийг бий болгочихсон байна гэсэн үг хэмээн тэр хэлсэн.¹

Дэлхий өдөр тутмын материаллаг эдийн засгийн асуудлууд дээр анхаарлаа хандуулж байгаа ч бидний анхаарал сүнслэг зүйлүүдэд хандах хэрэгтэй.



Заримдаа дэлхийн жишгүүд нь анхаарал татахуйц, сэтгэл хөдлөм агуу эд баялгууд руу биш ч, биднийг гүн гүнзгий сүнслэг амлалтуудаас маань холдуулах асуудлууд дээр анхаарлаа хандуулахад хүргэдэг.

Би олон жилийн өмнө хэд хэдэн онцгой үйл явдлыг багтаасан сонирхолтой үзүүлбэрийн талаар сонссон юм. “Хэрэв Христ өнөө орой ирвэл, Тэр хэн дээр ирэх байсан бол?” хэмээн бичсэн том уриа лоозон дор өөр өөр үйл явцууд харагдана. Хэрэв би зураглалуудыг зөв санаж байгаа бол эдгээр нь дараах үйл явцуудыг агуулсан байв:

- Сувилагчаар асруулж, орон дээрээ хэвтэж байгаа өвчтэй, ахимаг настай эмэгтэй
- Шинэ төрсөн хүүхдээ тэвэрсэн, баяр баясгалантай залуу ээж
- Хүүхдүүд нь өлсөж, бас уйлж байгаа гэр бүл
- Баян чинээлэг гэр бүл
- Хүүхдүүд нь хамтдаа баяртайгаар дуулж буй олон хүүхэдтэй, даруухан, сайхан гэр бүл

Бид Аврагчийн дахин ирэх өдөр, цагийг мэдэхгүй гэдгээ мэднэ. Бид Христийн шашинтнуудын хувьд ядуу, тусламж хэрэгтэй болон бэлэвсэрсэн хүмүүсийг, мөн өнчин хүүхдүүдийг халамжилдаг гэдгийг мэднэ. Гэхдээ тэр лоозон дээр “Хэрэв Христ өнөө орой ирвэл хэн Түүнийг угтахар бэлтгэгдсэн байна вэ?” гэж бичигдсэн байсан бол илүү тохиромжтой байх байсан юм.

Надад орж ирсэн дараагийн бодол бол тэр зураглалууд хүмүүсийн бие махбодын нөхцөл байдлын талаар бидэнд их мэдээлэл өгсөн ч, тэдний сүнслэг байдал ба Христэд өгсөн амлалтын талаар юу ч өгүүлээгүй тухай юм.

Өөрсдийн амьдралыг мөн Аврагчид болон Түүний сайн мэдээнд өгсөн амлалтаа эргэн харах эхлэх цэг бол баптисм юм. Шинэ хөрвөгчид болон хүүхдүүдийнхнийг эс тооцвол, бидний баптисм нэлээн хэдэн жилийн өмнө болсон билээ.

Агуу бошиглогч Алма бидэнд хандан уран цэцэн үгээр: “Мөн эдүгээ болгоогтун, би та нарт хэлнэ, ах дүүс минь, хэрэв та нар зүрх сэтгэлийн өөрчлөлтийг эдэлсэн бол, мөн хэрэв та нар гэтэлгэх хайрын дууг дуулмаар санагдсан бол, би асууя, та нар одоо тийн мэдэрч чадна уу?” гэж хэлсэн (Алма 5:26).

Алма дараа нь өнөө үеийнхэнд хамаатай чухал захиасаа үргэлжлүүлсэн билээ. Тэр үнэн хэрэгтээ, хэрэв бид үхэх гэж байсан бол Бурхантай уулзахаар бэлтгэгдсэн үү гэж гэгээнтнүүдээс асуудаг. Алма дараа нь, бид Бурханы өмнө гэм зэмгүй



Бид өөрсдийн амьдралд анхаарлаа хандуулж, ялангуяа сүнслэг зүйлст илүү анхаарах хэрэгтэй.

байхад хэрэгтэй 4 зан чанарыг онцлон хэлсэн юм:

Нэгдүгээрт, “[бид] хангалттай даруу байна уу?” Энэ утгаараа, өөрсдийгөө даруусгаж, харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй байх нь эргээд баптисмд тавигдах шаардлага болдог.

Хоёрдугаарт, “[бид] бардамналаасаа ангижирсан уу?” Алма Ариун Нэгэнийг хөл доороо дэвсэлж, бардамналаа хөөрөн, зүрх сэтгэлээ дэлхийн хоосон зүйлүүд дээр тавьж, өөрсдийгөө нэг нь нөгөөгөөсөө илүү дээр гэж бодохгүй байхад сэрэмжлүүлсэн билээ.

Гуравдугаарт, бид “атаа жөтөөнөөсөө ангижирсан уу?” Өөрсдөө агуу адислалууд хүлээн авсан ч гэлээ, бусдад байгаа зүйлс дээр л анхаарлаа хандуулдаг талархаж чаддаггүй тэр хүмүүсийн хувьд атаа жөтөө нь хамгийн хортой зүйл байж болох юм. Нийгмийн ихэнх давхаргын хувьд нэр алдар, эд хөрөнгө нь итгэл болон гэр бүлийг орлож эхлэх үед “Амьдралын хэв маягийн атаархал”² өсөн нэмэгдэж эхэлсэн юм.

Дөрөвдүгээрт, бид ах дүүсээрээ доог тохуу хийх юм уу, хавчлага овоолдог уу? Бид өнөөгийн дэлхийд үүнийг айлган сүрдүүлэлт хэмээн нэрлэж болох юм (Алма 5:27–30, 53–54-ийг үзнэ үү).

Өнөө үед даруу байдал, бардамнал, атаа жөтөө, хавчлагын талаарх энэхүү захиасаас илүү чухал ач холбогдолтой өөр зүйл байна гэж үү? Дэлхийн ихэнх хэсэгт болж буй томоохон хэмжээний хэлэлцүүлгүүд түр зуурын өдөр тутмын эдийн засгийн асуудлуудын талаар ярьж байна. Харин Бурхантай уулзахаар бэлтгэхэд болон бидний сүнснүүдийн нөхцөл байдал руу чиглэсэн Христтэй илүү адил болох зарчмуудад эргэн хандах талаар маш бага яригдаж байна. Бид өөрсдийн амьдралд анхаарлаа хандуулж, сүнслэг байдалдаа тавих ач холбогдлоо өсгөн нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Зөв шударга гэр бүлүүдийн шагнал

“Бид Сүмийн цөөхөн гишүүнтэй, муу муухай, зөрчилдөөн болон зөв шударга ёсны эсрэг сөргөлдөөнүүдээр дүүрэн газруудад гэр бүлээ өсгөх хэрэгтэй юу?”

Миний эхнэр, Мэри бид хоёрт 1960 оны сүүлээр АНУ-ын Калифорни дахь Сан Францискогийн Бэй дүүрэгт хүүхдүүдээ өсгөж эхлэх үед ийм асуудлууд тулгарч байсан юм. Хожмын үеийн гэгээнтнүүдийн тоо харьцангуй цөөн байв. Хүмүүсийн дийлэнх хэсэг нь гайхалтай байсан ч Бэй дүүрэг мансууруулах бодис хэрэглэдэг, бусад бүхий л төрлийн садар самуун, нүгэл хилэнц үйлдэгчдийн цугларах дуртай газар байлаа.

Нийгэм дэх энэхүү өөрчлөлт чухал нөлөөтэй байсан учраас сэтгэл түгшсэн нэгэн гадасны ерөнхийлөгч Сүмийн гишүүдийг Бэй дүүрэгт үлдэхэд нь урамшуулан дэмжих хэрэгтэй эсэхээ Сүмийн удирдлагаас асуужээ. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын хамгийн ахмад гишүүн байсан ахлагч Харолд Б.Лийг (1899–1973) энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр томилжээ. Их Эзэн гишүүдийг энэ газар нутгийг орхин яваасай гэж хүссэн бол энд ариун сүм барих илчлэлт өгөхгүй байх байсан хэмээн тэр тайлбарласан юм. Түүний бидэнд өгсөн зөвлөгөө нь энгийн хэрнээ гүн гүнзгий ач холбогдолтой байв.

1. Сионыг зүрх сэтгэлдээ болон гэр орондоо байгуул.
2. Амьдарч байгаа хүмүүсийнхээ дунд гэрэл нь бай.
3. Ариун сүмийн ёслолууд болон тэнд заагддаг зарчмууд дээр анхаарлаа хандуул.

Бид ахлагч Лийгийн хэлсэн зөвлөгөөг баяртай хүлээн авч, гэр бүлдээ хэрэгжүүлэхээр хичээсэн юм.

Бид Сионыг өөрсдийн зүрх сэтгэл, гэр оронд байгуулахдаа өдөр бүр гэр бүлээрээ залбирч, судраас судалж,

мөн долоо хоног бүр гэр бүлийн үдшээ хийж, гэр орондоо шашны зан үйлд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Ингэснээр бид хүүхдүүдээ зааж мөн сургаж чадна. Бид хүүхдүүдээ болон ханиа хэтрүүлэн шүүмжлэхээс зайлсхийж; хайр, нинжин сэтгэлээр үүнийг хийж чадна.

Бид хаана амьдарч байгаагаасаа үл хамааран бүх зүйлийг зөв хийж байхад хүртэл зарим хүүхэд хориглогдсон зам руу чиглэх ухаалаг бус сонголтууд хийдэг. Үнэндээ, бусад хүн зохисгүй эсвэл ёс суртахуунгүй явдлыг залуучуудад санал болгох үед хэлэх эсвэл хийх зүйлээ урьдчилан шийдэхэд тэдэнд туслах нь чухал юм.

Хүүхдүүд маань хоёр, гуравхан л ХҮГ хүүхэд явдаг байсан сургуульд явдаг байсан. Хичээлийн шинэ жил эхлэхэд, эсвэл сургуулийн үйл ажиллагаануудад оролцохын өмнө бид гэр бүлийн үдшээрээ, хэрэв тэд аюултай нөхцөл байдалд орвол юу хийх тухай мэдвэл зохих хариултуудын талаар ярилцдаг байв. “Битгий тэнэглэ л дээ, хүн бүр л үүнийг хийдэг,” “Эцэг эх чинь үүнийг мэдэхгүй шүү дээ,” эсвэл “Ганц удаа хийхэд зүгээр дээ” гэж тэдэнд хэлж болох найзууддаа юу гэж хариулах байсныг бид тэднээс асуудаг байсан.

Бид өөрсдийнхөө үүрэг хариуцлагын талаар Их Эзэнтэй ярьдаг байсан.

Бид даруу хувцаслаж, цэвэр, зохистой үг хэрэглэж, порнографаас татгалзсанаараа Христийн үлгэр жишээг дагадаг гэж онцлон хэлдэг байв. Хүүхдийн хэсэгт

хамаарах хүүхдүүд цэвэр ариун амьдралаар амьдарч болохын тулд тэдэнд эдгээр зүйлийг одоо л заах хэрэгтэй юм.

Бид Потифарын эхнэрийн зохисгүй үйлдэлтэй тулгарсан үедээ зугтаасан Египетийн Иосефийн тухай ярилцдаг байсан (Эхлэл 39:7–12-ыг үзнэ үү).

Бүх хүүхэд маань ийм бэлтгэл чухал болох талаар дор хаяж нэг үйл явдлыг мэддэг байсан ч, ихэнхдээ найзууд нь тэдний жишиг, итгэл бишрэлийг мэддэг учраас тэднийг хамгаалдаг байв.

Бидний охин Кэтрин коллежид суралцахаар явсныхаа дараа ээжтэйгээ утсаар ярьдаг байсан бөгөөд Мэри түүнд Аврагчийн талаарх дуртай зүйлсийг нь ярьж өгдөг байв. Мэри Кэтриний ярилцахаар утасдсан асуудлуудад нь туслахын тулд үргэлж Аврагчийн үлгэр жишээ, зан чанаруудыг ашигладаг байсан юм.

Хэрэв хүүхдүүд маань Есүс Христэд болон Түүний сайн мэдээнд бат бөх суурьтай байх юм бол, бид бараг дэлхийн хаана ч зөв шударга хүүхдүүдийг өсгөж чадна гэдэгт би итгэдэг. Нифай “Мөн бидний хүүхдүүд нүглээс ангижрахын тулд ямар сурвалжийг хайж болохыг мэдэж болохын тулд бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, бид Христийн тухай бошиглож, мөн бид бошиглоуудынхаа дагуу бичдэг болой” (2 Нифай 25:26) гэж хэлж, гэр бүлийнхэндээ болон хүмүүстээ заах гэж юу болохыг тодорхойлжээ.

*Хэрэв хүүхдүүд
маань Есүс
Христэд болон
Түүний сайн
мэдээнд бат
бөх суурьтай
байх юм бол
бид дэлхийн
хаана ч зөв
шударга
хүүхдүүдийг
өсгөж
чадна.*



Бид үүнийг хийх юм бол хүүхдүүд маань ухаалаг бус сонголт хийх үедээ бүх зүйл алдаг-даагүй бөгөөд тэд гэртээ харих замаа олж чадна гэдгээ мэдэх болно. Есүс Христэд итгэх итгэлээр дамжуулан гэр бүлийн гишүүн бүрээ хүчирхэгжүүлэхийг хичээснээр та болон гэр бүлийнхэн тань адислагдах болно гэдгийг би батлан хэлмээр байна.

Хэрэв бид эргэн тойронд маань амьдарч байгаа хүмүүсийн дунд гэрэл нь байх ахлагч Лийгийн хэлсэн зөвлөгөөг дагах юм бол, өөрсдийн жишгүүдийг нууж чадахгүй. Бидний биеэ авч яваа байдал бидний эрхэмлэх зүйлс, итгэл үнэмшлийг харуулдаг байх хэрэгтэй. Бид тохиромжтой үед олон нийтийн улс төрийн үйл ажиллагаануудад оролцож байх хэрэгтэй.

Ариун сүмийн эрхийн бичиг авахуйц зохистой амьдарч, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, гэрээнүүдээ үнэнч байх нь гэрээнийхээ зам дээр үлдэхэд анхаарлаа хандуулах боломжийг бидэнд олгодог. Өсвөр үеийнхэн маань нас барагсдынхаа баптисмыг гүйцэтгэхүйц зохистой амьдарснаар тэдний амьдрал зохих байрандаа үлдэх болно.

Бид зөв шударга гэр бүлүүдийн шагналыг хүртэж, мөнхийн гэр бүлүүд болж болохын тулд Христийн талаар ярьж, Христэд баясаж, Христийн тухай номлож, мөн Христийн тухай бошиглосноор гэр бүлүүдээ хүчирхэгжүүлэхэд эрч хүчээ зориулах хэрэгтэй.

Гэрлээгүй ч зөв шударга амьдарч байгаа хүмүүсийн хувьд бидний сургаал тайтгаруулагч болдог: “Энэ амьдралын нөхцөл байдлаас шалтгаалан мөнхийн гэрлэлтийг болон эцэг эх болох адисла-луудыг хүлээн авах боломжгүй байгаа итгэлтэй гишүүд Бурхантай хийсэн гэрээнүүдээ сахих юм бол амлагдсан бүх адислалыг мөнх амьдралдаа хүлээн авах болно.”³

Аз жаргалын шагнал

“Би хүүхдүүдээ амьдралдаа аз жаргалтай, амжилттай байлгахын тулд ямар давуу талуудаар хангах хэрэгтэй вэ?”

Хэрэв бид сонор сэрэмжтэй байхгүй бол Люси-фер зөв шударгад үл нийцэх, биднийг төөрөгдөлд оруулах аз жаргалын хууран мэхлэлт буюу төөрөгдлийг бий болгосон. Өнөөдөр бидэнд тохиолдоод байгаа зовлон бэрхшээлүүдийн ихэнх нь шашнаас ангид дэлхий аз жаргалын талаар буруу тодорхойлолтыг дагаж байгаа учраас үүсч байна. Бид Мормоны Номноос энэ асуудал нь бүх үеийн

Хайр бол энэ дэлхий дээрх аз жаргалын үндсэн хэсэг юм.



турш оршин тогтнож байгаа тухай уншдаг. Бид бас зарлигуудын дагуу амьдрахаас ирдэг тэрхүү адислалуудыг мэддэг.

Хаан Бенжамин “Бурханы зарлигуудыг дагадаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай хэмээн хүснэ би. Учир нь болгоогтун, тэд бүх зүйлд, биеийн мөн сүнсний аль алинд нь адислагдсан болой; мөн хэрэв тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэвчвээс, тэгвэл тэд Бурхантай хамт хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тулд тэд тэнгэрт хүлээн авагдах болно. Ай санагтун, эдгээр зүйлүүд үнэнийг санагтун; учир нь Их Эзэн Бурхан үүнийг ярьсан юм” (Мозая 2:41) хэмээн хэлжээ.

Би олон жилийн турш 1930-аад оны үед эхэлсэн нэгэн судалгааны төслийг мөрдөж ирлээ. Энэ судалгаанд эхлээд өөрсдийнхөө бүхий л амьдралыг үе үе судлуулж байсан, нэр хүндтэй нэгэн их сургуулийн 268 эрэгтэй хамрагдсан юм. Дараа нь, эмэгтэйчүүд судалгааны нэг хэсэг болсон байна. Энэ судалгаа ойролцоогоор 70 жил үргэлжилжээ. Анх судалгааны зорилго нь амжилт ба аз жаргалын тухай боломжийн хэрээр олж мэдэх явдал байлаа.

Уг судалгаа нь коллежийн элсэлтийн оноо болон дүнгийн дундаж нь ирээдүйн амьдралдаа амжилттай эсвэл аз жаргалтай байх эсэхийг урьдчилан тодорхойлодоггүйг харуулжээ. Харин хамгийн их хамааралтай байсан зүйл нь хүүхэд насны гэр бүлийн аз жаргал байв. Аз жаргалтай, амжилтад хүрсэн насанд хүрэгчид, ээжүүд нь хайр энэрлээ ялангуяа амаараа илэрхийлдэг байсан ба хатуу ширүүн аргаар сахилгажуулдаггүй байсан гэж ихэвчлэн хэлдэг ажээ. Тэдний эцэг эх бие биедээ энхрий ялдам ханддаг байсан бөгөөд халуун дулаанаар сэтгэлээ илэрхийлдэг харилцаанд

өссөн хүүхдүүддээ ч тийнхүү хандах боломжтой байв. Эцэг эх нь тогтвортой гэр бүлийн орчинг бүрдүүлж, хүүхдүүдийнхээ бие даасан байдлыг хүндэтгэн үздэг байв.

Энэ судалгааны 2012 онд хэвлэгдсэн сүүлийн номонд: “Амьдралын турш олж авах амжилтын олон хэмжүүрийг хайраар дүүрэн, хайрлуулж өссөн хүүхэд наснаас илүүтэй, бага насны санхүүгийн болон нийгмийн давуу талуудаар урьдчилан таамаглах нь найдвар багатай байдаг” хэмээн мэдээлжээ. Аз жаргалтай хүүхэд нас нь оюун ухаан, нийгмийн давхарга эсвэл спортоор хичээллэхээс ч илүүтэй амжилтанд шууд нөлөөлдөг. Энэ судалгаа бас “хүүхэд насанд болж буй зөв зүйлс нь буруу зүйлсээс илүү ирээдүйг урьдчилан харахад тусалдгийг”⁴ олж тогтоожээ.

Чухал ач холбогдолтой асуудлууд бий болсон үед, бүр зарим нь буруугаар эргэсэн үед хүртэл ихэнх хүүхэд уян хатан байдаг бөгөөд эцэг эхчүүдийн, ялангуяа эх нь хүүхдүүдтэйгээ хайраар дүүрэн харилцааг үүсгэх үед энэхүү итгэл найдвар урт удаан, амьдралынх нь турш үргэлжлэх аз жаргалд нөлөөлж чадна гэдгийг энэ судалгаа харуулдаг. Миний хувьд намайг гайхшируулаагүй ч сонирхлыг минь татсан нэг зүйл нь энэ судалгаа бүхэлдээ гэр бүлийн талаарх судар болон Сүмийн заадаг зүйлстэй нийцэж байсан явдал юм. Хүүхдийг аз жаргалтай, амжилтанд хүрсэн хүн болгож төлөвшүүлнэ хэмээн тодорхойлсон гэр бүлийн үдэш, гэр бүлийн залбирал, хайраа илэрхийлэх, гэр бүлээрээ хамтдаа байх болон бусад гэр

бүлийн уламжлалуудтай адил олон төрлийн үйл ажиллагааг Сүм онцолж хэлдэг билээ.

Нифай Мормоны Номыг “буянт сайн эцэг эхдээ” (1 Нифай 1:1) талархах талархлаар эхэлдэг ч, бидний үр удам ч гэсэн сайн эцэг эхээс мэндэлсэн гэдгээ баяртайгаар тэмдэглэн үлдээж болохын тулд бидний хүн нэг бүр ямархуу маягийн эцэг эх болохоо шийдэх нь жинхэнэ сургамж болдог.

Та нарын хийж чадах хамгийн чухал зүйл бол таны хүүхдүүд болон таны асран хамгаалдаг хүмүүс таны тэдэнд хайртайг мэддэг байх явдал мөн. Хайр бол аз жаргалтай байхын үндсэн хэсэг юм.

Нутагтаа дэгжсэнээр ирэх шагнал

“Манай гэр бүл материаллаг байдлын хувьд тийм ч их амжилтанд хүрээгүй. Энэ нь бид хангалттай зөв шударга байгаагүй учраас тэр үү?”

Бид зарлигуудын дагуу амьдарснаар нутагтаа өсөж, дэгжих боломжтой болдог талаар судрууд дээр тодорхой байдаг. Гэхдээ би нутагтаа дэгжих гэдэг нь таны дансанд хэдэн төгрөг байгаагаар тодорхойлогддоггүй гэдгийг та нарт сануулмаар байна. Энэ нь үүнээс илүү бүрэн дүүрэн утгыг илэрхийлдэг.

Бошиглогч Алма хүү Хиламандаа “Бурханы зарлигуудыг дагахын хэрээр та нар нутагтаа дэгжих болно гэдгийг мэдвэл зохино; мөн та нар түүнчлэн, та нар Бурханы зарлигуудыг дагахгүй байхын хэрээр та нар түүний дэргэдээс тусгаарлагдах болно гэдгийг мэдвэл зохино” (Алма 36:30) хэмээн заадаг.

Үүний дагуу, бид өөрсдийн амьдралд Сүнсийг байлгаснаар газар нутагтаа дэгжих чухал хүчин зүйл болдог. Хэрэв бид зарлигуудыг дагавал бидэнд ч бас тодорхой амлалтууд өгөгдөх болно (Ефес 6:1–3-ыг үзнэ үү). Тухайлбал Мэргэн ухааны үгийн дагуу амьдарснаар ирэх амлалт, эрүүл мэндийн адислалууд болон мэдлэгийн агуу өвийг эдлэх болно гэж Сургаал ба Гэрээ 89-д бичсэн байдаг.

Согтууруулах ундаанаас зайлсхийх гэсэн нэгэн хүчин зүйлийг Мэргэн ухааны үгээс онцлон авч үзэх нь бидэнд олон зүйлийг заадаг. Миний дээр дурдсан урт хугацааны судалгаагаар согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх нь Америкийн гэр бүлүүдийн гуравны нэгд нөлөөлж, нэгдсэн эмнэлгүүдэд хүргэгдэн ирж буй хүмүүсийн дөрөвний нэгийг хамарч, үхэл, гэр бүл салалт, эрүүл мэндээр хохирох, ажлын бүтээмж буурах гэх зэргээр ихээхэн хэмжээний хор хохирол учруулж байгааг тогтоожээ.



Энэ дэлхий дээрх жинхэнэ хөгжил цэцэглэлт нь гэр бүлийнхнээсээ гадна Аврагчийг хайрлаж мөн үйлчлэх тэнцвэртэй байдлаас ирдэг.



Зөв шударга амьдарснаар ирэх эцсийн шагнал нь “энэ дэлхий дээр амар амгалан болон ирэх дэлхийд мөнх амьдрал юм.”

Калифорни дахь Сүмийн идэвхтэй гишүүдийг хамруулсан урт хугацааны нэгэн судалгаагаар АНУ-ын эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй харьцуулахад Сүмийн эмэгтэйчүүд 5,6 жилээр, эрэгтэйчүүд нь 9,8 жилээр илүү урт насалж байгааг тогтоосон байна. Судалгааг явуулсан эмч нар Мэргэн ухааны үгийг дагавал зохих дор хаяж нэг шалтгааныг тодорхойлсон юм. Мэргэн ухааны үгээр амьдрах нь нутагтаа дэгжих боломжийг бидэнд олгож байна.⁵

Би нэгэн ариун сүмийн онцгойлон адислалтад оролцохоор ерөнхийлөгч Гордон Б.Хинклитэй (1910–2008) хамт нисэж байхдаа түүнтэй ярилцсан. Тэрээр хожмын үеийн гэгээнтнүүд нутагтаа дэгжсэн учраас Сүмд ариун сүмийн тоог өсгөх хөрөнгө мөнгө байгаа гэж баяртайгаар хэлсэн юм. Аравны нэгээ итгэлтэй төлдөг хүмүүс байгаа учраас тэд ариун сүмүүд барих эх үүсвэрүүдийг хангасан байв.

Дэгжих болон эд хөрөнгөтэй байх гэдэг нь заавал ижил утгатай байх шаардлагагүй. Нутагтаа дэгжих гэдэг үгэнд илүү тохирох сайн мэдээний тодорхойлолт нь өөрсдийн амьдралд Сүнсний элбэг дэлбэг адислалуудыг авахын зэрэгцээ материаллаг хэрэгцээгээ хангалттай олж авах гэсэн утгатай. Бид гэр бүлийнхээ хэрэгцээг хангаж, Аврагчийг хайрлаж мөн үйлчлэх юм бол Сүнтэй байж, нутагтаа дэгжсэнээр ирэх шагналуудыг эдлэх болно.

Амар амгалангийн шагнал

Зөв шударга байснаар ирэх сүүлийн амлагдсан шагнал нь Сургаал ба Гэрээ 59:23 дээр тодорхой дүрслэгдсэн байдаг: “Гэвч зөв шударгын үйлсүүдийг хийх тэрээр шагналаа, бүр энэ дэлхийд амар амгаланг хийгээд ирэх дэлхийд мөнх амьдралыг хүлээн авах болно гэдгийг мэдэж авагтун.”

35 гаруй жилийн өмнө ерөнхийлөгч Кимбалл олон “сайн эмэгтэй Сүмд татагдан ирэх учраас агуу өсөлт хөгжилт Сүмд тохиох болно” хэмээн заасан. Тэрээр “Энэ нь Сүмийн эмэгтэйчүүд өөрсдийн амьдралд зөв шударга болон тодорхой байдлаа харуулж, . . . аз жаргалтай арга замаар явж, дэлхийн эмэгтэйчүүдээс ялгаатай, өөрөөр харагдах тэр үед энэ нь тохиолдох болно”⁶ хэмээн тунхагласан юм.

Энэ нь үнэхээр ийм байсаар ирсэн бөгөөд ирээдүйд ч ийм байх болно.

Их Эзэн Бурхан үнэндээ нар болон бамбай бөгөөд ач ивээл болон алдар сууг өгөх болно. Тэрээр шулуун шударга явагчдаас ямар ч сайн юмыг нуудаггүй (Дуулал 84:11-ийг үзнэ үү). Та нар бидний Их Эзэн Аврагч Есүс Христийг итгэлтэй дагах үедээ зөв шударгын шагналуудыг хадаж авах болтугай хэмээн би залбирч байна. ■

2014 оны 5-р сарын 2-нд БЯИС-ийн эмэгтэйчүүдийн чуулган дээрх “Зөв шударгын шагналууд” хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Спэнсэр В.Кимбалл, “The False Gods We Worship,” *Ensign*, 1976 оны 6-р сар, 2-6-г үзнэ үү.
2. Лэйн Андэрсэн, *Deseret News*, “The Instagram Effect: How the Psychology of Envy Drives Consumerism,” 2014 оны 4-р сарын 15, С7-г үзнэ үү.
3. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 1.3.3. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бонд К.Пакэр, 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр хэлсэн “Гэрч” хэмээх үгэндээ үүнийг дахин баталжээ, х.94–97.
4. Жорж И.Валлиант, *Triumphs of Experience: The Men of the Harvard Grant Study* (2012), 108–109.
5. Жэймс И.Энстром болон Лэстэр Брэсло, “Lifestyle and Reduced Mortality among Active California Mormons, 1980–2004,” *Preventive Medicine* 46 (2008), 135.
6. Спэнсэр В.Кимбалл, “The Role of Righteous Women,” *Ensign*, 1979 оны 11-р сар, 103–104-ийг үзнэ үү; мөн *Teachings of Presidents of the Church: Spencer W. Kimball* (2006), 223-ыг үзнэ үү.



*Шашин, засгийн газар хоёр
ялгаатай ч зэрэгцэн орших
замууд юм. Тэд бие биенээ
хамгаалж мөн дэмжисж байгаа
үедээ хамгийн амжилттай,
үр дүнтэй байдаг.*



Шашин ба засгийн газар

Шашин ба засгийн газар нь, заримдаа хамт амьдрахад хэцүү ч тусдаа амьдарч чадахгүй гэдгээ мэддэг хостой адил юм. Шашин, засгийн газар хоёрын аль аль нь илүү сайн хөгжихийн тулд бие даасан байх хэрэгтэй ч бүрмөсөн салах нь сайн биш гэдгийг түүх батлан харуулдаг. Тэд ялгаатай ч зэрэгцэн орших замууд юм. Тэд бие биенээ хамгаалж мөн дэмжиж байгаа үедээ хамгийн амжилттай, үр дүнтэй байдаг.

Засгийн газрууд шашны эрх чөлөөг хамгаалж, дэмжлэг үзүүлж, нийгэм дэх сүмүүдийн үүргийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Аз болоход, өнөөдөр дэлхий дээрх ихэнх засгийн газар наад зах нь шашны эрх чөлөөг ямар нэгэн хэмжээгээр хүлээн зөвшөөрдөг ба иргэдээ шүтэн бишрэх, өөрсдийн ухамсрын дагуу шашнаа хэрэгжүүлэх эрхээр хангадаг. Энэ нь үргэлж ийм байгаагүй.

Олон үеийнхэн засгийн газар нь төрийн шашнаа шүтэхийг тулгаснаас болоод эрх чөлөө нь боомилгон, алдагдахыг харсан. Бусад нь засгийн газар шашныг бүхэлд нь хориглосноор ёс суртахууны хувьд унахыг ч харсан. Бид өнөөгийн дэлхий дээрх улс орнуудын үндсэн хуулийн дийлэнх хэсэг нь шашны итгэл үнэмшил, зан үйл нь хэдийгээр засгийн газраасаа тусдаа байж болох ч хавчлага дарамтаас хамгаалагдаж, баталгаажигдах ёстой гэсэн нийгмийг төсөөлөн харж байгаад талархалтай байдаг.¹

Мормоны Номонд дүрслэгдсэн тэнгэрлэг засгийн газар нь хүмүүстээ шашин шүтэх эрх чөлөөг болон үүнийгээ хэрэгжүүлэх боломжийг олгодог байв.

“Эдүгээ хэрэв хүмүүн Бурханд үйлчлэхийг хүсвэл, энэ нь түүний эрх байв; эсвээс, хэрэв тэр Бурханд итгэдэг бол түүнд үйлчлэх нь түүний эрх байв; харин итгэдэггүй бол түүнийг шийтгэх хууль үгүй байв. . . .

“Учир нь хүмүүс гэмт хэргүүдийнхээ дагуу шүүгдэх ёстой хэмээх нэгэн хууль байв. Гэсэн хэдий ч, хүмүүний сүсэг бишрэлийн эсрэг хууль байсангүй” (Алма 30:9, 11).

Бид итгэл бишрэлтэй хүмүүсийн хувьд, биднийг хүссэн үедээ шашны итгэлээ хүлээн авч мөн амьдралдаа хэрэгжүүлэх боломжийг олгож буй засгийн газрын хамгаалалтуудад талархах хэрэгтэй.

Шашны үндсэн үүрэг

Шашин ба ёс суртахууны байдал нь сайн, үр дүнтэй засгийн газарт дэмжлэг үзүүлж, нөлөөлөхөд чухал үүрэг гүйцэтгэдэг гэдэг нь заримынх нь хувьд ойлгомжгүй байдаг байж болно. Өнөөгийн дэлхийд тулгамдаж байгаа ноцтой асуудлуудыг шийдэж болох цорын ганц бодит шийдэл бол улс төрийн эсвэл эдийн засгийн асуудлууд биш, харин сүнслэг зүйлс юм. Жишээ нь, арьс өнгөөр ялгаварлах үзэл, үзэн ядалтаас үүдсэн гэмт хэргүүд нь сүнслэг асуудлууд бөгөөд тэдгээрийг шийдвэрлэх цорын ганц шийдэл нь сүнслэг зүйлс юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс:

“Барууны нийгмийн чухал ёс суртахууны олон хөгжил дэвшилд шашны зарчмууд нөлөөлж, индэр дээр номлож буй зүйлсийг албан ёсоор хэрэгжүүлэхийг ятгаж байна. Жишээ нь, үүнд Англи дахь боолын худалдааг хүчингүй болгох болон [Нэгдсэн Улс] дахь чөлөөлөлтийн тунхаг орно. Мөн адил өнгөрсөн хагас зууны Иргэний эрхийн хөдөлгөөний үнэн байдал үүнд орно” гэж заасан байна².

Аливаа нийгэмд ёс суртахууны дэг журам тогтооход шашин болон сүмүүд ихээхэн нөлөөлдөг. Засгийн газрууд ёс суртахуун, зан байдал болон итгэлээр дутмаг нийгмээс үүссэн гэмт хэрэгтнүүдийг байршуулах



ШАШНЫ ИТГЭЛ ҮНЭМШЛИЙН ЧУХАЛ НӨЛӨӨ

“Манай нийгэм юуны өмнө хуулиар болон хуулийн шахалтаар оршин тогтнодоггүй, харин хамгийн чухал нь зөв шударга эсвэл зөв зан авирын дотоод жишгүүдээр сайн

дураараа дуулгавартай дагадаг хүмүүсээс болж оршин тогтнодог. Зөв, буруугийн талаарх шашны итгэл үнэмшил нь манай олон иргэнд ийнхүү сайн дураараа дагаж мөрдөхөд чухал нөлөө үзүүлдэг.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Даллин Х.Өүкс 2013 оны 5-р сарын 16-нд Нью Йорк хотод болсон The Becket Fund for Religious Liberty Canterbury Medal Dinner үйл ажиллагаан дээр хэлсэн “Шашны эрх чөлөөг хүчирхэгжүүлэх нь” үгээс авав; mormonnewsroom.org вэб хуудсыг үзнэ үү.

хангалттай олон шоронг хэзээ ч барьж чадахгүй. Эдгээр зан чанар нь хууль тогтоолоос эсвэл цагдаагийн хүчнээс илүүтэй шашны зан үйлээр илүү сайн хөхиүлэн дэмжигддэг билээ. Засгийн газрын хувьд хүн төрөлхтний зүрх сэтгэлээс үүсэн бий болох зан чанарууд, хүсэл болон итгэл найдварыг хянах боломжгүй юм. Гэхдээ эдгээр үр нь засгийн газрын зохицуулах ёстой үйлдэл болдог.

Францын түүхч, улс төрийн зүтгэлтэн Алэксис дэ Токүвиллэ бичихдээ: “Дарангуйлал нь итгэлгүйгээр засаглаж болно, гэхдээ эрх чөлөө үүнгүйгээр засаглаж чадахгүй”³ гэжээ. Дарангуйлал ч гэсэн итгэлгүйгээр удаан оршин тогтнож чадахгүй юм. ОХУ-ын анхны ерөнхийлөгч Борис Ельцин “Та нар жадаар хаант ширээ босгож болох ч үүн дээр суух маш хэцүү” хэмээн онцлон тэмдэглэжээ.⁴

Есүс Христ Уулан дээрх номлолоороо номонд бичигдсэн хуулийг зүрх сэтгэлд бичигдсэн хуультай харьцуулсан юм.

“Энэ нь хуучин цагийн тэднээр хэлэгдсэнийг та нар сонссон, чи алах ёсгүй, мөн алсан хэн боловч, Бурханы шүүлтийн дор аюултай байдалд байх болно;

“Гэвч би та нарт хэлнэ, ахдаа уурласан хэн боловч түүний шүүлтийн дор аюултай байдалд байх болно” (Матай 5:21–22).

Засгийн газар номонд бичигдсэн хуулийг хүчилж байхад, шашин зүрх сэтгэлдээ бичигдсэн хуулийг дагахыг зааж, урамшуулан дэмжиж байдаг. Сүүлийнхийг дагадаг хүмүүс өмнөхийг ховор тохиолдолд зөрчдөг. Бид Сургаал ба Гэрээнээс уншдагчлан “Бурханы хуулиудыг сахьдаг тэрээр уг нутгийн хуулиудыг зөрчих шаардлагагүй билээ” (58:21).

Харин зүрх сэтгэлийн асуудлуудыг үл тоосон газарт засгийн газрын хар үсэгтэй хууль болон хуулийн механизм эцэстээ намагт живэх болно. Нийгэм дэх сайн харилцаа нь хүмүүсийн дийлэнх нь хууль тогтоомжийн эсвэл цагдаагийн хүчээр шахуулахгүйгээр хийх хэрэгтэй хэмээн итгэсэн ёс суртахуунтай зүйлсийг хийсэн үед бий болдог.

Засгийн газар нь иргэдийнхээ биеэ хэрхэн авч явахад анхаарч байдаг. Засгийн газар тэднийг биеэ төлөв төвшин, ёс суртахуунтай авч явдаг болгох гэж хичээдэг. Шашин эсрэгээрээ, тэднийг төлөв төвшин, ёс суртахууны арга замаар биеэ авч явах *хүсэлтэй* болгохоор хичээдэг. Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Уайт Д.Эйзенхауэрийн засгийн газрын гишүүн, ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) нэгэн хамгийн чухал онцлогийг заасан юм.

“Их Эзэн дотроос нь гадагшаа ажилладаг. Дэлхий



гаднаас нь дотогшоо ажилладаг. Дэлхий хүмүүсээ ядуу тарчиг амьдралаас нь гаргахыг хүсдэг. Харин Христ ядуурлыг хүмүүсийн дотоод сэтгэлээс гаргасны дараа тэд өөрсдийгөө ядуурлаас гаргадаг. Дэлхий хүмүүсийн хүрээлэн буй орчинг өөрчлөх байдлаар тэднийг төлөвшүүлдэг. Харин Христ эхлээд хүмүүсийг өөрчилж, тэд дараа нь хүрээлэн байгаа орчноо өөрчилдөг. Дэлхий хүмүүсийн зан төлөвт нөлөөлж болох ч, харин Христ хүмүүсийн мөн чанарыг өөрчилж чадна.”⁵

Цаг хугацаа өнгөрөх тусам бүх чөлөөт засгийн газар эцэстээ иргэдийнхээ хувийн сонголтоор хийх сайн үйлс ба дэмжлэгт тулгуурлах ёстой. Домогт улс төрийн зүтгэлтэн, гүн ухаантан Эдманд Бөрк хэлэхдээ “Оюун ухаанаа захирч чаддаггүй хүмүүс эрх чөлөөтэй байж болохгүй гэдэг нь юмсын мөнхийн үндсэн хуулиар тогтоогдсон. Тэдний хүсэл тэднийг дөнгөлдөг”⁶ гэжээ.

Сайн засгийн газар энэ зорилгоор шашныг хамгаалж, шашны эрх чөлөөг хөхиүлэн дэмждэг. Сайн шашин нь сайн иргэдийг болон орон нутгийн хуулийг дагахад урамшуулан дэмждэг.

Сайн засгийн газар нүүр тал хардаггүй. Засгийн газар нэг шашинг нөгөөгөөс илүү дэмжиж, эсвэл давуу эрх олгох ёсгүй. Засгийн газрын төлөөлөгчид өөрсдийн ухамсрын дагуу итгэж, үйлдэх чөлөөт эрхтэй байх ёстой. Үүнтэй адил, сайн шашин нь ямар нэгэн нам эсвэл

Биднийг улс орныхоо асуудлуудыг болон нэр дэвшигчийг анхааралтай судалж, шударга ажиллана гэж итгээж байгаа хүнийхээ төлөө саналаа өгөхөд урамшуулан дэмждэг.

нэр дэвшигчийг хүлээн зөвшөөрөх, эсвэл эсэргүүцэх ёсгүй. Мөн итгэгчид хамгийн сайн нь гэж үзсэн нам эвслийн, эсвэл нэр дэвшигчийнхээ улс төрийн үйл ажиллагаанд оролцож, дэмжих эрхтэй байх ёстой.

Дуу хоолойгоо өргөх

Сүм нь байгууллагын хувьд улс төрийн төвийг сахисан байр суурьтай гэдгээ олон дахин илэрхийлсэн бөгөөд хожмын үеийн гэгээнтнүүдийг улс төрийн үйл ажиллагаанд оролцож, олон хэлэлцүүлэгт дуу хоолойгоо өргөхийг урамшуулан дэмждэг. Бид хаана ч амьдардаг байлаа гэсэн сайн иргэд байх нь манай шашны нэг хэсэг билээ.

Гарын авлага 2: Сүмийг удирдах нь гарын авлага дээр хэлэхдээ “Гишүүдийг өөрсдийнхөө төр засгийн хуулийн дагуу санал өгөхөөр бүртгүүлэх, улс орныхоо асуудлуудыг болон нэр дэвшигчдийг анхааралтай судлах, мөн шударга болон мэргэн ухаанаар ажиллана гэж үзсэн хүмүүсийн төлөө саналаа өгөхийг дэмждэг. Зарчимч, шударга, сайн, ухаалаг удирдагчдыг эрж олон, тэдний төлөө саналаа өгч, дэмжих онцгой үүрэг хожмын үеийн гэгээнтнүүдэд бий (С ба Г 98:10-ыг үзнэ үү).”⁷

Аврагч нэг л өдөр эргэж ирэх болно. Хаадын Хаан болон бидний агуу Дээд Пристийн хувьд удирдаж мөн засаглах нь Түүний эрх юм. Тэгээд засгийн газрын эрх болон санваарын хүч нэг болон нэгдэх болно.

Тэр агуу өдрийг хүртэл шашин, засгийн газар хоёр нь хүн төрөлхтний түүхийн замаар нягт хэлхээ холбоотойгоор, нэг нь нөгөөгийнхөө бие даасан байдлыг хүндэтгэн, нөгөө нь нэгнийхээ чухал хувь нэмэрт талархан, хамтдаа алхах ёстой. ■

ЭШЛЭЛҮҮД

1. W. Cole Durham Jr., Silvio Ferrari, Cristiana Cianitto, Donlu Thayer, eds., *Law, Religion, Constitution: Freedom of Religion, Equal Treatment, and the Law* (2013), 3–5-ыг үзнэ үү.
2. Далайн Х.Өүкс, “Strengthening the Free Exercise of Religion,” address given at The Becket Fund for Religious Liberty Canterbury Medal Dinner, New York City, 2013 оны 5-р сарын 16, 1; мөн mormonnewsroom.org вэбсайтаас үзэх боломжтой.
3. Алэксис дэ Токүвиллэ, *Democracy in America*, 2 vols. (1835–40), 1:306.
4. Борис Ельцин, Доналд Муррэйгийн бичсэн номонд, *A Democracy of Despots* (1995), 8.
5. Эзра Тафт Бэнсон, “Born of God,” *Ensign*, 1985 оны 11-р сар, 6.
6. Эдманд Бөрк, *A Letter from Mr. Burke, to a Member of the National Assembly; in Answer to Some Objections to His Book on French Affairs*, 2nd ed. (1791), 69.
7. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 21.1.29.

БИ ХУУЛАХГҮЙ

Би коллежийн шинэхэн оюутан байхдаа заримдаа ангийнхандаа урам хугардаг байв. Учир нь, тэдний олон нь шалгалтын үеэр хуулдаг байсан юм. Зарим нь бичсэн зүйлсээ ангийнхандаа сэм тараадаг. Зарим нь бусдадаа шалгалтын хариунуудаа бичиж өгдөг. Цөөн хэд нь ангийнхныхаа шалгалтыг бүр хуулж өгдөг байлаа.

Хуулдаг оюутнууд үргэлж надаас өндөр оноо авдаг байв. Гэсэн хэдий ч, би тэдэнтэй нэгдэхээр уруу татагдаагүй юм. Би хулгайгаар 100 оноо авснаас үнэнчээр 0 оноо авсан нь дээр гэж үргэлж оюун ухаан, зүрх сэтгэлдээ хэлдэг.

Хэрэв би хуулбал тэдэнд үлгэр жишээ үзүүлж чадахгүй. Би Есүс Христийн сайн мэдээг тэдэнтэй хуваалцаж болох арга замаар амьдарч чадахгүй болох болно. Би энэ Сүм үнэн гэдгийг тэдэнд харуулж чадахгүй.

Би нэг өдөр үлдэгдэл төлбөрийнхөө талаар асуухаар коллежийнхоо кассын ажилтан дээр очив. Би дараа долоо хоногт сүүлчийн шалгалтуудаа өгөхийн тулд бүх төлбөрөө төлөх ёстой байсан юм. Би алхаж байхдаа надад хэрэгтэй байсан мөнгийг хаанаас олж болох талаар санаа зовж байлаа. Над шиг өөрийгөө авч явдаг оюутны хувьд санхүү маш хэцүү байв.

Би оффис дээр очоод, кассын ажилтнаас хэр их төлбөр төлөх ёстойгоо асуулаа.

“Чи төгслөө ямар ч өргүй байна” гэж тэр хэлэв.

Би гайхсандаа түүнээс та итгэлтэй байна уу эсвэл надаар тоглож байна уу? гэж асууж билээ.

Тэр “Тийм ээ, би итгэлтэй байна, тоглоогүй байна” гэж хэлээд, “Удирдлагын зөвлөх таны сенатын гишүүнээс тэтгэлэг авах тухай өргөдлийг боловсруулсан. Та одоо

тэтгэлэгт хамрагдсан” гэлээ.

Би энэ үгсийг сонсоод, маш их баярлав. Би түүнд талархаад, удирдах зөвлөлийн гишүүний өрөөнд орж, хийсэн зүйлд нь талархлаа илэрхийлэхээр гүйн очлоо.

Намайг түүнд талархаж мөн ямар их баярлаж байгаагаа хэлсний дараа “Чи надад талархах шаардлагагүй шүү дээ” гэж зөвлөх хэлсэн юм. “Би зөвхөн зэмсэг байсан.”

Би гарч явах үедээ үргэлж хуваалцах дуртай судраа санасан юм: “Мөн эцсийн өдөр миний нэрэнд итгэлтэй хэвээр байх адислагдсан болой, учир нь тэр нь дэлхийн үүслээс түүнд зориулагдан бэлтгэгдсэн хаант улсад оршин байхаар тэр өргөгдөх болно. Мөн болгоогун үүнийг ярьсан нь [Есүс Христ] билээ” (Ифер 4:19).

Би зөв зүйл хийснээр, Тэнгэрлэг Эцэгийнхээ зарлигуудыг дагахдаа, бүр шударга бус зүйлс нийтлэг байгаа тийм нөхцөлд хүртэл итгэлтэй байдлаа харуулсан юм. Түүнд итгэх итгэлдээ баттай зогссон үед Тэр намайг хэзээ ч орхихгүй гэдгийг би мэднэ.

Би одоо ямар ч төлбөрт санаа зовохгүйгээр суралцаж чадах болсондоо баяртай байна. Би зөвхөн хүлээж авч болох шагнал, адислалуудаас болж биш, харин Тэнгэрлэг Эцэгийг болон надад жишээ үзүүлсэн Түүний Хүү, Есүс Христийг хайрладаг учраас зөв зүйлээ үргэлжлүүлэн хийх урам зоригтой болсон юм. ■

Жоанна Мае Рангга, Филиппин, Өмнөд Лэитэ

Хуулдаг байсан оюутнууд надаас үргэлж өндөр оноо авдаг байв. Гэсэн хэдий ч би тэдэнтэй нэгдэхээр уруу татагдаагүй юм.





Би хуримынхаа өдрөөр тэр даашинзыг өмсөж үзэхийг маш их хүсэж билээ.

ЭЭЖИЙН МИНЬ ХУРИМЫН ДААШИНЗ

Би жаахан охин байхдаа анх удаа ээжийнхээ хуримын даашинзыг харж билээ. Даашинзыг хайрцган дотор нямбай гэгч эвхэж хийсэн байсан ба ээж минь үүнийг надад үзүүлэхийн тулд болгоомжтой гаргаж ирснийг би санаж байна. Энэ нь хэчнээн гоё байсан гээч! Би хуримаа хийх өдрөө тэр даашинзыг өмсөж үзэхийг маш их хүсэж билээ.

Ээж минь даашинзаа эвтэйхан далд хийгээд, ирээдүйд үүнийгээ надад өмсүүлнэ гэж амласан юм. Энэ даашинз аавын минь түүнд өгсөн онцгой бэлэг байсан гэж тэр надад хэлсэн. Ээж хуримын зурагнууд дээрээ маш хайр булаам, үзэсгэлэнтэй харагдаж байв. Эцэг эх маань Сүмийн гишүүд биш байсан ч гайхалтай хүмүүс байлаа.

Би ирээдүйн нөхөртэйгөө танилцах үедээ Сүмийн талаар мэдэж авсан. Хэдийгээр тэр Сүмдээ идэвхгүй байсан ч бидний тэр уулзалт Анхны үзэгдлийн түүх рүү хөтөлсөн учраас ер бусын байсан юм. Энэ түүх гайхалтай байсан, гэвч би үүнийг хүлээж авахад бэлэн биш байв.

Бид 16 сар болсоны эцэст ээжийнхээ урт хормойтой хуримын

даашинзыг өмсөж, хурсан олны дундуур сүйт залуу руугаа алхах үед миний мөрөөдөл биелж билээ. Би бас маш хүчтэй дурласан байлаа. Олон хүн намайг ээжийнхээ гэрлэж байсан үеийнхтэй адилхан харагдаж байсан гэж хэлэв.

Олон жил улиран өнгөрч, бид хоёр хүүтэй болсон. Нөхрөө Сүмдээ эргэн ирэхээр хичээх үед би түүний хичээл чармайлтуудад саад болдог байв. Би өсвөр насандаа сүмд идэвхтэй байгаагүй ч, өөр сүмийг сонгох нь надад хэцүү байсан юм.

Энэ нь гэрлээд 19 жил болсны дараа л үндсэндээ өөрчлөгдсөн. Нөхөр маань Сүмдээ эргэн ирж, түүнээс хэдхэн долоо хоногийн дараа би түүнтэй хамт Сүмд явж эхэллээ. Миний гэрчлэл хурдан өсөж, би баптисм хүртэж, гишүүнээр батлуулав. Үүний дараа ариун сүмд нөхөртэйгөө лацдан холбогдохын тулд өөрийгөө бэлдэх нь миний хамгийн агуу хүсэл болж билээ.

Бидний лацдан холбогдох баярт өдөр ирэхэд би ээжийнхээ цагаан даашинзыг дахин өмссөн юм. Сүмийн нэг найз маань үүнийг ариун сүмд өмсөж болохуйц болгон засаж

өгөв. Би түүнээс хойш ариун сүмд үргэлж энэ даашинзаа өмсөж байгаа.

Аавыг минь нас барах үед ээжийн минь бие муудсан байсан ч тэр сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад бэлэн болоогүй л байв. Гэхдээ би түүнд сэргээлтийн талаар олон гайхалтай зүйлсийг ярьсан. Тэр хөшигний цаана гарах үедээ үнэн сайн мэдээний захиасыг сонсох болно гэж би түүнд хэлсэн юм. Нэг жилийн дараа тэрээр төлөөлөн гүйцэтгэдэг ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, мөн аавтай минь лацдан холбогдож болохын тулд түүний өмнөөс даашинзаа өмсөх болно гэж би түүнд амласан билээ. Тэгээд би амласныхаа дагуу хийсэн.

Одоо миний даашинз хуучирсан бөгөөд нэгэн өдөр би үүнийг өмсөж чадахаа болино гэдгээ мэднэ. Тэр өдрийг хүртэл би үүнийг нөхөр, ээж, аавынхаа төлөө мөн ариун сүмд өмнөөс нь үйлчилсэн гэр бүлийнхээ гишүүд болон үнэн сайн мэдээний төлөө түүнчлэн ариун нандин ёслолууд, Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү, Есүс Христийн төлөө хайраар үргэлжлүүлэн өмсөх болно. ■

Анжелика Флорэс Алгаба,
Мексик, Кьюретаро

ИХ ЭЗЭН АМАР АМГАЛАНГААР НАДАД ЯРИВ

Карли охин маань хэдэн өдрийн турш өвдөж, би ердөө ханиад байх гэж бодож байлаа. Гэвч түүний шинж тэмдгүүд даамжирсаар байсан учир би илүү ноцтой зүйл байж магадгүй гэж бодож эхлэв.

Эмчийн үзлэгээр миний айдас батлагдан, улам ихэсч, Карлиг 1-р хэлбэрийн чихрийн шижинтэй гэж оношлов. Тэр чихрийн шижингийн комын байдалд шилжиж байсан ба түүнийг эмнэлэгт хурдан хүргэх шаардлагатай байлаа. Би тайвшрахын тулд, бас эмч нар түүнд туслах боломжтой байхын төлөө зүрх сэтгэлдээ залбирч байв.

Биднийг яаралтай тусламжийн өрөөнд ирэхэд эмч, сувилагчид түүний амийг аврахаар хичээж, хурдан шуурхай ажилласан юм. Би тайвшрал, амар амгаланг хүлээн авахын төлөө Тэнгэрлэг Эцэгтээ залбирч байлаа.

Нам гүм болох тэр мөчид нөхөр минь аавтайгаа хамт Карлид санваарын адислал өгөв. Нөхөр минь адислал өгөхдөө түүний амьдрал Тэнгэрлэг Эцэгийн хүслийн дагуу байх болно хэмээн хэллээ. Би амар амгаланг мэдэрч эхлэв.

Карлигийн биеийн байдлыг сайжруулахын тулд эмч нар зүүгээр хатгаж, сорил авч, үзлэг хийж байгааг хараад би цөхөрч байв. Түүний өрөө шөнө нэг цагийн үед арай намгүм болсон байлаа. Би юу болохыг мэдэхгүй байсан бөгөөд унтаж ч чадахгүй, ганцаардаж байв.

Би эмнэлэг дээр эгчийнхээ авчирч өгсөн Мормоны Номыг гаргаж, судруудаас хэрэгтэй байгаа баталгаагаа хүлээн авахын төлөө залбирсан юм. Ном Алма 36:3 дээр нээгдэв. Намайг уншиж байх үед Их Эзэн надад хандан ярьж байгаа юм шиг санагдаж: "Бурханд найдлага тавьсан хэн боловч өөрсдийн зүдгүүрүүдэд, мөн өөрсдийн бэрхшээлүүдэд хийгээд өөрсдийн зовлонгуудад дэмжигдэх болно, мөн эцсийн өдөр өргөгдөх болно гэдгийг би мэднэ" гэхийг би уншлаа.

Би тэр шөнө хоёр дахь удаагаа амар амгаланг мэдэрсэн юм. Би Тэнгэрлэг Эцэг биднийг мэдэж байгаа гэдгийг мэдсэн. Тэр тэнд байгаа бөгөөд би Түүнд итгэх итгэлтэй байх хэрэгтэйг Тэр намайг мэдээсэй гэж хүссэн билээ.

Би тэр өдөр болсон үйл явдлуудыг тунгаан бодож байхдаа Их Эзэн биднийг хэрхэн адисалсан талаар бодож үзэв. Би Карлиг аваад, эмч рүү яаралтай явах хэрэгтэй гэж мэдэрсэн. Бид эмнэлэг дээр аюулгүй явж ирсэн. Санваартнууд мөн адислал өгөхөөр эмнэлэг дээр тэр даруй ирсэн.

Бид тэр өдрөөс хойш түүний цусан дахь сахарын хэмжээг шалгаж, хоолны дэглэм бариулдаг болсон. Бид чихрийн шижинг эмчлэх явц нь хэрхэн биед нөлөөлж болох талаар сурч авсан. Карлигийн чихрийн шижин зовлон зүдгүүр болсоор байгаа ч бид Тэнгэрлэг Эцэгтээ өдөр бүр итгэж сурсан.


Эмнэлэгт өнгөрүүлсэн тэр өдөр миний дахин дурсахыг хүсдэггүй өдөр боловч үүрд талархалтай байх тэр өдөр минь байсан юм. Энэ бол суралцах, итгэлээ хөгжүүлэх, талархалтай байх өдөр байсан. Тэнгэрлэг Эцэг хүүхэд бүрээ мэддэгийг, Тэр биднийг зовлон бэрхшээлтэй үед үнэхээр дэмжих болно гэдгийг би мэдэж авсан. ■

Триша Томкинсон Риггс, АНУ, Аризона

Биднийг яаралтай тусламжийн өрөөнд ирэхэд эмч, сувилагчид түүний амийг аврахаар хичээж, хурдан шуурхай ажилласан билээ.



9 насанд хүрэгч,
8 хүүхэд
тахианы махны
найман жижиг
хэсэг болон нэг
таваг будаа, эгчийн
авчирсан нэг аяга
гоймон болох
багахан хоолыг
хувааж идэхээр
болов.



ТАХИАНЫ НАЙМАН ЖИЖИГ ХЭСЭГ

Нөхөр маань хэсэг хугацаанд
ажилгүй байх үед том болж буй
таван хүүхэдтэй гэр бүлийн хувьд
бүх хэрэгцээгээ хангах хэцүү бай-
лаа. 2013 оны 10-р сарын Ерөнхий
чуулганы шууд нэвтрүүлгийн өмнөх
өдөр бид хүнсний нөөцөө шалгаж
үзэн, чуулганы хуралдааны зав-
сарлагаагаар шарсан тахиа болон
будаагаар энгийн өдрийн хоол
бэлтгэхээр шийдсэн юм.

Ням гараг болж, бид бүгд бэлэн
боллоо. Манай эцэг эх, эгч нар
болон тэдний гэр бүлийнхэн шууд
нэвтрүүлэг эхлэхээс цаг хагасын
өмнө гадасны төв дээр тааралдав.

Бошиглогч, үзмэрч, илчлэгч-
дийн манай үеийнхэнд зориулан
онцгойлон хуваалцах захиасуудыг
сонсох нь ямар их баяртай үйл
явдал хийгээд адислал байсан
гээч. Би зөвлөгөөг сонсож, мөн
Тэнгэрлэг Эцэгээс ирж буй амар

амгаланд болон хайрын гайхалтай
сүнсэнд баясаж байхдаа, хэрэв би
үргэлжлүүлэн итгэлээ хөгжүүлж,
Аврагчаар амьдралаа удирдуулах
юм бол бүх зүйл сайхан болж, гэр
бүлийн маань сүнслэг болон мате-
риаллаг хэрэгцээнүүд хангагдаж,
ядуурлаас болон бусад гачигдлаас
чөлөөлөгдөх болно гэсэн баталгааг
хүлээн авсан юм.

Би тэр ням гаргийн сүнсэнд
баясаж байхдаа өдрийн хоолныхоо
талаар мартсан байв. Хуралдаан
хоорондын завсарлага болоход,
бид арвандолуулаа байлаа. 9 насанд
хүрэгч, 8 хүүхэд тахианы махны
найман жижиг хэсэг болон нэг таваг
будаа, эгчийн авчирсан нэг аяга гой-
мон болох багахан хоолыг хувааж
идэхээр болов.

8 настай Хэнри талархал илэр-
хийлж, хоолноос идсэн хүн бүр
цадахын төлөө хоолоо адисалж

залбирав. Би эгчийг тавагнууд
дээр гоймон болон будаагаа тавих
үед тахианы махны жижиг хэсэг
бүрийг хувааж, хүүхдүүд рүү дам-
жууллаа. Бүх хэсгийг хугалж, гой-
мон болон будааг хуваасны дараа
хүн бүрийн жижиг тавагнаас гадна
дахин нэг илүү тавагтай хоол үлд-
сэнийг хараад би нулимсаа барьж
чадаагүй юм. Бүгд идэж, мөн цадав.

Би Аврагч үнэхээр таван талх,
хоёр загасыг хувааж, хурсан олон
“эмэгтэйчүүд хүүхдүүдээс гадна
таван мянга орчим эрчүүдийг”
(Матай 14:14–21-ийг үзнэ үү)
хооллосон гэдэг нь үнэхээр үнэн
гэдгийг мэднэ гэж эцэг эхдээ бо-
лон нөхөртөө хэлж билээ. Зарим
шүүмжлэгч болон үл итгэгчид
гайхамшгууд нь зүйрлэл ихтэй, хэт-
рүүлэгтэй эсвэл боломжгүй хэмээн
хэлдэг. Гэхдээ миний гэр бүл бо-
лон миний хувьд энэ түүх бичигд-
сэн шигээ үнэн юм.

Талархлаа илэрхийлж, идсэн хүн
бүр цадаж, шим тэжээл аваасай гэж
хүссэн итгэлтэй хүүгийн залбирлыг
Тэнгэрлэг Эцэг сонссон байв.

Биднийг Ерөнхий чуулганы
зааланд эргэн ирэх үед би зүрх
сэтгэлдээ баясаж байлаа. Хэрэв
бид анхаарч мөн сонсох аваас
бид хэзээ ч өлсөж эсвэл цангах
нь үгүй (Иохан 6:35-ыг үзнэ үү)
хэмээн амладаг Түүнтэй үлдэж
бас суралцахыг би хүссэн бөгөөд
надад Есүсийн хооллосон хурсан
олонтой хамт байгаа юм шиг са-
нагдаж байв.

Бид хүүхдүүдтэйгээ хамт да-
руйхан суудлаа эзэлж, Тэнгэрлэг
Эцэгийн сонгогдсон үйлчлэгчдийг
сонсоход бэлэн болсон юм. Энэ нь
бидний үргэлж дурсан санах үйл
явдал болж өнгөрсөн билээ. ■
Абигайл Алмэриа, Филиппин, Себу

АМЬДРАЛ БА ЭРЧ ХҮЧЭЭР ДҮҮРГЭГДЭВ



Рандалл А.Райт

Таны нэг найз хувийн илчлэлт хүлээн авах замаар зөвлөгөө хүсэж, тань дээр ирсэн гэж төсөөлье. Хэрэв та ганцхан зүйл санал болгож чадах байсан бол юу санал болгох байсан бэ?

Шинээр дуудагдсан ерөнхий эрх мэдэлтний хувьд ахлагч Марион Ж.Ромни (1897–1988) чухал дуудлагаа биелүүлэхэд хангалтгүй байгаагаа мэдэрчээ. Тиймээс тэрээр өөрийн найз Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Харолд Б.Лийгээс (1899–1973) зөвлөгөө хүссэн байна. Тэр өдрийн санал болгосон зөвлөгөө ахлагч Ромниг гайхшируулж бас урам зориг өгчээ. Ахлагч Лий хэлэхдээ: “Хэрэв та ерөнхий эрх мэдэлтний хувьд амжилттай байхыг хүсэж байгаа бол сүнслэг удирдамж авдаг байх хэрэгтэй. Та илчлэлт авах хэрэгтэй. Би чамд нэг зөвлөгөө өгье: *Эрт унтаж, эрт босож бай.* Хэрэв та үүнийг хийвэл таны бие, оюун ухаан тань амарч, өглөө эрт нам гүм цагт та өдрийн ямар ч цагаас илүү сүнслэг удирдамж болон бодлуудын гялбааг хүлээн авах болно” гэжээ.

Олон жилийн дараа ерөнхийлөгч Ромни тэрхүү туршлагаа дурсан ярихдаа: “Тэр өдрөөс хойш би энэ зөвлөгөөг дагаж эхэлсэн бөгөөд энэ нь хэрэгждэгийг мэднэ. Би ноцтой асуудалтай тулгарах бүрдээ эсвэл Сүнсний нөлөөг хүлээн авах хэрэгтэй гэж үзсэн бүтээлч шинж чанартай зарим нэг даалгавартай байгаа үедээ үргэлж өдрийн ямар ч цагаас илүү өглөө илүү их тусламж хүлээн авдаг”¹ гэж хэлжээ.

Би анх энэ түүхийг сонсоод, ахлагч Лийгийн өгсөн зөвлөгөөнд бас гайхаж байв. Би хэзээ ч өдөр бүр эрт босохыг илчлэлт хүлээн авахтай холбон бодож байгаагүй. Гэхдээ би одоо энэ нь шууд хамааралтайг мэднэ. Би бас намайг эрт унтаж, эрт босох үед залбирах,

судар судлах, мацаг барих, ариун сүмийн ёслолууд хийх, ариун сүмд орох, үйлчлэх гэх мэт илчлэлт авахтай холбоотой уламжлалт үйлдлүүд эрс өсөн нэмэгддэг гэдгийг мэдэж авсан.

Судрын жишээнүүд

Сүнслэгээр нөлөөлөгдсөн бүхий л насны эрэгтэй, эмэгтэй хүмүүс унтах талаарх энэхүү тэнгэрлэг зөвлөгөөг дагадаг байв. “Абрахам өглөө *эрт босоод*, Эзэний өмнө зогсож байсан тэр газар руугаа очив” (Эхлэл 19:27; тодотгол нэмэгдсэн). “Мосе өглөө *эрт босоод*, *Эзэний тушаасан ёсоор* Синай ууланд гарав. Тэр гартаа хоёр чулуун хавтан барьжээ” (Египетээс гарсан нь 34:4; тодотгол нэмэгдсэн).

“Маргааш нь Иошуа өглөө *эртлэн босож*, мөн тахилч нар Эзэний авдрыг дамнав” (Иошуа 6:12; тодотгол нэмэгдсэн).

Их Эзэн мөнх бус тохинуулынхаа үеэр өдрийг хэрхэн эхэлдэг байсан бэ? Марк номон дээр “Өглөө *эрт харанхуй байхад*, Тэр босоод гадагш гарч, зэлүүд газарт очин, тэндээ залбирч байв” (Марк 1:35) хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Үнэнч шавь Мариа Түүний

үлгэр жишээг дагаж, ингэснээр бидэнд хүчирхэг хичээл заасан юм: “Долоо хоногийн эхний өдөр *эрт, харанхуй байхад* Магдалын Мариа хадан булш уруу очиж, булшны амнаас хадыг зайлуулсан байхыг харав” (Иохан 20:1). Тэрээр өглөө эрт амилсан Их Эзэнийг харсан анхны хүн болсон юм.

Эрт босоноор ирэх адислалууд

Өнөө үеийн агуу удирдагчид бас илчлэлт авахдаа өглөөний цагуудыг ашигладаг. Би өмнө нь Далын нэгдүгээр чуулгын нэг гишүүн гадасны чуулган дээр эрт

**Хэрэв тууштай,
сахилга баттай
дагасан бол илүү
эрүүл, эрч хүчтэй, сүнслэг
удирдамж авахад тань
ямар үйлдэл туслах
байсан бол?**

• • • • •



босдог талаараа ярьж байхыг сонссон. Цуглааны дараа би түүнтэй өглөө эрт босдог заншлынх нь талаар товчхон ярилцаад, Тэргүүн Зөвлөлийн болон Арванхоёрын чуулгын гишүүдийн хэд нь үүнтэй адил хуваарийг баримталдаг болохыг асуув. Тэр “Тэд бүгд үүнийг хийдэг!” гэж хариулж билээ. Энэ нь нөлөө бүхий мөч байсан бөгөөд эрт унтаж, эрт босох нь үнэхээр илчлэлт хүлээн авахтай холбогдож чадахыг Сүнс надад гэрчилсэн юм.

Унтах талаарх Их Эзэний зөвлөгөөг дагадаг хүмүүст нэмэлт адислалууд амлагдсан байдаг. Эдгээр гайхалтай амлалтыг бодож үзээрэй: “Шаардлагатайгаас илүү удаан унтахаа боль; та нар *ядрахгүй* байхын тулд; эрт босч бай, та нарын бие хийгээд оюун чинь *амарч* болохын тулд орондоо эрт орж бай” (С ба Г 88:124; тодотгол нэмэгдсэн). *Амрах* гэдэг нь “амьдрал ба эрч хүчээр дүүрэх” гэсэн утгатай юм.

Эртний гүн ухаантан Аристотель: “Өглөө эрт босох нь ашиг тустай байдаг, учир нь ийм дадал хэвшил нь эрүүл мэнд, эд хөрөнгө болон мэргэн ухаанд хувь нэмрээ оруулдаг юм”² хэмээн өглөөний эртэч хуваарь баримталдаг хүмүүст бусад ашиг тусыг санал болгосон байна. Нэгдсэн Улсын эртний улс төрийн зүтгэлтэн Бенжамин Франклин хожим олонд танигдсан хэлсэн үгэндээ: “Эрт унтаж, эрт босох нь хүнийг эрүүл, чинээлэг, мэргэн болгодог”³ гэж хэлсэн. Ихэнх хүн амьдралдаа хамгийн их хүссэн зүйлсийнхээ эхэнд эрүүл мэнд, эд хөрөнгө, мэргэн ухааныг тавьсан байдаг.

Эрүүл мэнд

Америкт компанийн гүйцэтгэх захирлуудын дундаж нас 55 байна.⁴ Тэгвэл олон улсын нэгэн байгууллагын гүйцэтгэх захирал 97 настай хүн байсан гэдгийг мэдвэл та гайхах уу? Та бас түүнийг энэ өндөр насандаа үт хэлж, удирдагчдыг сурган, төрийн албан хаагчидтай уулзаж, хэвлэл мэдээллийн томоохон байгууллагууд дээр ярилцлага хийж, дэлхийгээр аялсаар байсан гэдгийг мэдвэл яах бол? Түүний хоёр зөвлөх нь 79 ба


87 настай, маш идэвхтэй, эрч хүчтэй хүмүүс байсан гэвэл ямар вэ? Тиймээ, энэ бол ерөнхийлөгч Гордон Б.Хинклигийн (1910–2008) Сүмийн ерөнхийлөгчөөр үйлчилсэн үйлчлэлийн төгсгөл хэсэг байсан юм. Өглөөний эртэч хуваарь нь зөвхөн хувь нэмэр оруулагч төдийгүй, Сүмийн удирдагчдад урт наслахад нөлөөлдөг хүчин зүйлүүдийн нэг нь юм шиг санагддаг.

Бригам Янгийн Их Сургуулийн ерөнхийлөгч асан Эрнэст А.Вилкинсон эртэч хуваарийг баримтлах нь эрүүл мэндийн ашиг тустай холбоотой хэмээн санал болгожээ. Тэрээр тухайн үед Сүмийн ерөнхийлөгч байсан ерөнхийлөгч Дэвид О.Маккэйг (1873–1970) дурсан: “Ерөнхийлөгч Маккэй ийм сайхан, урт удаан, эрүүл саруул амьдарсан агуу шалтгаануудын нэг нь тэр залуу байхаасаа эрт унтаж, ерөнхийдөө нар мандахаас өмнө, өдрийнхөө ажлыг хийхэд оюун ухаан сэргэг, бие махбод нь эрч хүчтэй байх үед буюу эрт босох хэвшлийг бий болгосных гэдэгт би эргэлзэхгүй байна”⁵ гэжээ.

Эртэч хуваарийг баримтлах болон оюун ухаан, сэтгэл санааны эрүүл мэнд нь хоорондоо уялдаа холбоотой. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон “Ялагдаж бас дарлагдсан гэж бодож байгаа хүмүүст хандан, өөрсдийнхөө авралын төлөө эрт босож бай”⁶ гэж хэлжээ.

Мэргэн ухаан

Унтах загвар, мэргэн ухаан хоёрын хоорондын уялдаа холбоо нь зөвхөн онол биш юм. Бригам Янгийн Их Сургуулийн судлаачдын авсан судалгаа: “Орой орондоо орж, маргааш нь орой босдог зуршилтай оюутнууд эрт унтаж, эрт босож хэвшсэн оюутнуудаас доогуур голч оноотой байдаг” хэмээн мэдэгдсэн байна. Оюутнууд өглөө хэдий чинээ их унтана, тэдний дүн төдий чинээ доогуур байх хандлагатай байв. Судлагдсан бүх хүчин зүйлээс гадна хичээлийн болон амралтын өдрүүдэд сэрэх цаг нь оюутны голч дүнтэй шууд хамааралтай байдаг байна. Оюутнууд ажлын өдрүүдэд дунджаар нэг цаг илүү унтах нь голч дүнг (0.0–4.0 оноо) 0,13 оноогоор



бууруулдаг гэсэн хамаарал ажиглагдсан юм.”⁷

Би саяхан 203 ХҮТ коллежийн оюутнаас тэдний унтдаг хэв маягийн талаар санал асуулга авав. Эдгээр оюутан дунджаар хичээлтэй өдрүүдэд 7:30-д сэрдэг бөгөөд амралтын өдрүүдэд 9:15-д сэрдэг гэсэн байлаа. Тэд хичээлтэй өдрүүдэд дунджаар шөнө дунд, амралтын өдрүүдэд 1 цагт унтдаг байв. Эдгээр оюутан эрт хуваарь болон мэдлэг олж авахтай холбоотой судалгаанаас шууд эсрэг байв. Магадгүй эрт унтсанаар голч оноогоо өсгөнө гэдгийг олж мэдэх нь итгэхэд хэтэрхий энгийн сонсогдож болох юм. Бид “ут замын энгийн байдлын учир” могойд хатгуулахад Их Эзэний өгсөн ерөндгийг дагахаас татгалзсан Израилийн хүүхдүүдтэй адил болсон уу? (1 Нифай 17:41; мөн Хиламан 8:14–15-ыг үзнэ үү).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бонд К.Пакэрийн мэргэн ухааныг олж авах талаар өгсөн зөвлөгөөг бодож үзнэ үү: “Би хүүхдүүдэд шөнө бие махбод нь ядарч, оюун ухаан нь эцэж туйлдсан үед тэмцэхээсээ илүүтэй өглөө эрт эрч хүчтэй, сэргэг байгаа үедээ чухал хичээлүүдээ хийхийг зөвлөдөг.” “Эрт унтаж, эрт босож бай”⁸ хэмээх дүрмийн хүч чадлыг би олж мэдсэн. Энэ нь магадгүй бүрэн цагийн номлогчдын эрт унтаж, эрт босох хуваарийг дагадаг нэг шалтгаан нь байж болох юм.

Бусад адислал

Чөлөөндөө гарсан Далын ахлагч Жое Ж.Кристэнсэн эхнэр Барбарагийнхаа хамт, унтах тухай Их Эзэний зөвлөгөөг дагасан хүмүүст: “Эрт унтаж, мөн эрт босох энэ зарлигт маш сайн нэг шалтгаан байх ёстой [С ба Г 88:124-ийг үзнэ үү]. . . . Дэлхий өглөө эрт илүү үзэсгэлэнтэй байдаг. Амьдрал үнэхээр амгалан тайван байдаг. Богинохон цагт маш их зүйлийг хийж болдог” гэсэн илүү их адислал санал болгосон байна.⁹ Бригам Янгийн Их Сургуулийн галын дэргэдэх цутларалт дээр ахлагч Кристэнсэн цааш нь: “Та нарын зарим нь шаардлагатай амралтаа авч чадахгүй байна.” Зарим нь оройтож унтаж, мөн биедээ

шаардлагатайгаас их унтаж, ингэснээр хүлээн авч болох байсан сүнслэг удирдамжаа авч чадахгүйд хүрч байна”¹⁰ гэжээ.

Ерөнхийлөгч Хинкли дуулгавартай байдаг хүмүүст: “Хэрэв та нар орой 10 цагт орондоо орж, өглөө 6 цагт босох юм бол бүх ажил чинь бүтэх болно”¹¹ гэсэн өөр нэгэн амлалт нэмж өгсөн юм.

Унтах талаарх Их Эзэний энэ зөвлөгөөг дагах нь жижиг зүйл мэт санагдаж болох ч “Тийн өчүүхэн арга замаар Их Эзэн агуу үйл хэргүүдийг тохиох болгож чадна” (1 Нифай 16:29). Эртэч хуваарийг дагах нь миний амьдралд илчлэлт болон олон адислал авчирсан гэрчлэл надад бий. Би эрт унтаж, эрт босох үедээ хэчнээн их зүйл амжуулдаг нь хэчнээн гайхалтай гээч. Энэ хувийн сахилга батаас ирэх ашиг тус нь үүнийг хийхэд шаардлагатай хичээл зүтгэлээс хамаагүй илүү зүйл билээ. Бид гудсан дээрээ үргэлжлүүлэн хэвтэхгүй байх өдрийнхөө хамгийн эхний дайныг ялсан үед, тэр өдрийн турш дахь дайнуудад ялах илүү их магадлалтай болдог. Бид бас амьдрал ба эрч хүчээр илүү их дүүргэгдэх магадлалтай болдог билээ. ■

Зохиогч нь АНУ-ын Техаст амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Жое Ж.Кристэнсэн, *To Grow in Spirit: A Ten-Point Plan for Becoming More Spiritual* (1989), 27–28-ыг үзнэ үү.
2. Аристотель, in *Wit and Wisdom of Socrates, Plato, Aristotle*, ed. N. B. Sen (1967), 100.
3. *Selections from the Writings of Benjamin Franklin*, ed. U. Waldo Cutler (1905), 16.
4. *Forbes* сэтгүүл, “Emerging Culture, Worldwide Success,” 2012 оны 10-р сарын 25-ыг үзнэ үү.
5. Эрнэст А.Вилкинсон, *Lifting One's Sights*, Brigham Young University Speeches of the Year (1963 оны 10-р сарын 1), 4.
6. Рассэл М.Нэлсон, “Joy Cometh in the Morning,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 70.
7. *Journal of American College Health* 49 (2000): 125–130.
8. Бонд К.Пакэр, *Teach Ye Diligently*, (1975), 205.
9. Жое Ж. ба Барбара К.Кристэнсэн, *Making Your Home a Missionary Training Center* (1985), 33.
10. Жое Ж.Кристэнсэн, “Resolutions” (Brigham Young University fireside, Jan. 9, 1994), 5, speeches.byu.edu.
11. Гордон Б.Хинкли, in Sheri L. Dew, *Go Forward with Faith: The Biography of Gordon B. Hinckley* (1996), 166–167.

Унгар

дахь хүч чадлын баганууд

Маккэллэ Жорж

Унгарын залуу үеийн төлөөлөл болох Крисчиан Эстэр* сайн мэдээ нь Бурханд төдийгүй, өөдрөг үзэл, сэтгэл хангалуун амьдралд итгэх түүний итгэлийг хүчирхэгжүүлдэг гэжээ. “Унгарчууд гэрэлт ирээдүйнхээ тухай бодохын оронд өнгөрсөн үеийн харанхуйгаа бодох хандлагатай байдаг” гэж тэр хэлэв. Эстэрийн хэлсэн өнгөрсөн үе гэдэг нь Унгарын түүхэн дэх, Унгарын үндэсний сүлд дууллын—*Isten, áldd meg a magyart*, “Бурхан унгарчуудыг адислаг”—хэмээх үгс хэзээ ч дуулагдаггүй байсан (1949-1956) тэр үе юм.

Сайн мэдээ Унгарт ирэв

1988 онд Сүм Унгарт албан ёсоор хүлээн зөвшөөрөгдөж, 1 жилийн дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон Будапештийг харан, Гэллэрт (Mt. Gellért) уулын орой дээрээс онцгойлон адислалын залбирал хэлсэн юм. 1990 онд, 40 жилийн турш шашны эрх чөлөөгүй байсан Будапештэд нэг номлол нээгдсэн билээ. Одоо Бурханы нөлөө ялангуяа хожмын үеийн гэгээнтэн залуучуудын зүрх сэтгэлд маш хүчтэй тусаж байна.

Институтийг сурталчлах төвүүд

Сурталчилгааны төвүүд нь Төв болон Баруун Европ дахь

залуучуудад тусалдаг томоохон хэсэг юм. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Л.Том Пэрри Төв Европт айлчилж очихоос нэг өдрийн өмнө нэгэн хүчирхэг илчлэлт хүлээн авч, сэржээ. Дэлхийн энэ хэсэгт байгаа Сүмийн хүч энэ залуучуудын дунд орших болно хэмээн тэр мэдэрчээ. Одоо сурталчилгааны төвүүд өөрсөдтэйгөө адил итгэл үнэмшилтэй анги, үйл ажиллагаануудыг болон найзуудыг олж болох нээлттэй газар болоод байна. “Энд бид жишгүүд маань сорилт болох вий гэж санаа зоволгүй, хөгжилтэй байж чаддаг” гэж Эстэр хэлсэн.

Эстэр төрсөн хот Үжфэхэртод (Újfehértó) номлогчидтой уулзсан бөгөөд тэдний үнэгүй заагддаг долоо хоног тутмын англи хэлний хичээлд оролцдог байв. Удалгүй номлогчид түүнийг салбарын үйл ажиллагаануудад урьжээ. “Би бүр эхнээсээ л үдэш бүр зохиогддог тоглоом, гэр бүлийн үдэш, бүжиг зэрэгт оролцдог байв” гэж тэр хэлэв. “Би 18 хүрэхээсээ 3 долоо хоногийн өмнө баптисм хүртсэн. Би одоо Бурханы охин гэдгээ, мөн Тэнгэрлэг Эцэг Өөрийн охиныг хэзээ ч ганцааранг орхихгүй гэдгийг мэдэж авсан.”

Унгар дайн ба дарангуйллын улмаас сүйдсэн ч Сүмийн залуучууд итгэл найдвараар дүүрэн байна.

Залуучуудын үйл ажиллагаа

Эстэр Нүрегахаз (Nyíregyháza) дахь салбарынхаа залуучуудын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн явж байгаа. Унгарт залуучуудын тойрог эсвэл салбар хараахан нээгдээгүй байгаа ч “бид хамтдаа цугларсаар л байгаа” гэж Эстэр хэлэв. “Бид цэцгийн наадам, мэлхийн баяр болон амьтны хүрээлэн рүү явцгаасан.”

Ахлагч Пэрригийн зөгнөн хэлснээр, Унгар дахь залуучууд бүгдэд гэрэл болох болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

** Унгарт гэр бүлийн нэр нь нэрийнхээ өмнө бичигддэг.*

ЭСТЭРИЙН ТУХАЙ ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Унгарт хүмүүс яаж болздог вэ?

Залуу гишүүд бие биетэйгээ уулзах боломжуудыг бий болгодог ч, тэд улсынхаа хоёр өөр хэсэгт амьдардаг учраас энэ нь хэцүү байдаг.

Та нар ариун сүм рүү хэр ойрхон явдаг вэ?

Би жилд нэг удаа Германы Фрэйбэрг ариун сүм рүү очиж чаддаг учраас хамгийн азтай гишүүдийн нэг.

Унгарт боловсрол чухал байр суурь эзэлдэг үү?

Тийм ээ, гэхдээ эцэг эх маань хэд хэдэн дипломтой ч манай гэр бүл амьдрахад хэцүү байсан тул үүнд итгэхэд бэрх байсан. Би одоо боловсролын давуу талуудыг ойлгож, 2014 оны 1-р сараас коллежид сурч эхэлсэн.

УНГАРЫН ТУХАЙ ТООН МЭДЭЭЛЭЛ

Хүн ам 9 877 365 (2014 оны байдлаар)

Газар нутаг 35 919 хавтгай дөрвөлжин миль (93 030 кв км)

Халуун рашаанаараа алдартай Унгар улс 450 нийтийн халуун устай Унгар хэлэнд 14 эгшиг байдаг

УНГАР ДАХЬ СҮМ

5050 хожмын үеийн гэгээнтэн

22 тойрог ба салбар

1 гадас (2006 онд байгуулагдсан)

6 гэр бүлийн түүхийн төв

1 номлол (Будапешт)

УНГАРЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Нийслэл: Будапешт

Хэл: унгар (унгар хэл)



Есүс Христ— Энх Амгалангийн Ханхүү

Энх Амгалангийн Ханхүүг уйгагүй хайдаг
хүн бүхэнд амар амгалан ирэх болно.



Арванхоёр
Төлөөлөгчийн
чуулгын
ахлагч
Рассэлл
М.Нэлсон

Их Эзэнд болон мөнхийн амьдралд анхаарал хандуулах нь зуурдын амьдралын бүхий л бэрхшээлд маань тусалдаг. Энэ дэлхий дээр төгс бус хүмүүн бид бусад төгс бус хүнтэй хамт амьдарч байна. Бидний энэ унасан дэлхий бол хэтэрхий их өр, дайн, байгалийн гамшиг, өвчин эмгэг, үхлээр өвчилсөн дэлхий юм.

Бид бүгд хувь хувьдаа бэрхшээлүүдтэй тулгардаг. Санаа зовоосон зүйлийн шалтгаан юу байхаас үл хамааран бид бүгд дооод сэтгэлийн амар амгаланг эрэлхийлдэг.

Миний захиас бол цор ганц үнэн хийгээд үүрдийн амар амгалангийн эх сурвалж болох Аврагч Христ—Энх Амгалангийн Ханхүүгийн тухай юм.¹

Есүс хэлэхдээ “Хүүхдүүдийг зөвшөөр, Над уруу ирэхийг бүү болиул. Учир нь тэнгэрийн хаанчлал бол эдний адил хүмүүсийнх юм”² гэжээ.

Тэрээр дайнд нэрвэгдсэн хүмүүсийн амьдралд амар амгаланг авчирч чадна. Цэргийн алба хаах үүрэг хариуцлагын улмаас хагацсан гэр бүлүүдэд Солонгосын дайны үеэр миний оюун бодолд шингэсэн байсан шиг дайны дурсамжууд хадгалагдсан байдаг.

Өнөө үеийн дайн илүү нарийн түвэгтэй боловч гэр бүлүүдэд хүнд туссан хэвээр байна. Ийм зовлон амссан тэр хүмүүс Их

Эзэнд хандаж болно. Түүний захиас дэлхийд амар амгалан, хүмүүст сайн сайхныг авчирдаг.³

Сэтгэл нь тайван бус байгаа хүмүүст амар амгалан ирэх боломжтой. Зарим хүн шархдаж, зарим нь хайртай хүнээ алдсанаас эсвэл сэтгэлийн шархнаасаа болж сүнслэгээр өвдөж байна. Ах эгч нар аа, та бүхэн Энх Амгалангийн Ханхүүд итгэх итгэлээ хөгжүүлэх аваас амар амгалан та нарын бодгальд ирэх болно.

“Та нарын дунд өвчтөнүүд байна уу? Тэднийг нааш авчрагтун. Доголон, эсвээс хараагүй, эсвээс хазгар, эсвээс тахир дутуу, . . . эсвээс ямар нэгэн байдлаар зовж зүдрэгсэд байна уу? Тэднийг нааш авчрагтун мөн би тэднийг эдгээх болно.”⁴

“Та нарыг эдгээхэд итгэл тань хангалттайг би харж байна.”⁵

Зовж шаналсан хүнд амар амгалан ирэх боломжтой. Зовлон шаналал нь алдаа эсвэл гэм нүглээс улбаатай эсэхээс үл хамааран Их Эзэний биднээс шаардах ганц зүйл нь үнэн сэтгэлийн наманчлал юм. Сударт биднийг “Идэр насныхаа дур хүслүүдээс зугт . . . [харин] цэвэр зүрх сэтгэлээс Эзэнийг дууд”⁶ хэмээн урамшуулдаг. Тэгснээр Түүний “Тилеадын гавар” нүглээр өвчилсөн зүрх сэтгэлийг ч эдгээх болно.⁷

1725 онд Лондонд төрсөн Жон Ньютоны өөрчлөлтийг бод доо. Тэрээр боолын худалдаачны нүгэлт амьдралаа наманчлан, Английн сүмийн санваартан болсон юм. Зүрх сэтгэлийн энэхүү агуу өөрчлөлтөөр Жон “Amazing Grace (Гайхалтай ач ивээл)” дууллын үгийг бичсэн билээ.

*Гайхалтай ач ивээл! Юутай сайхан
сонсогдоно вэ*

Ичгүүргүй намайг ч аварсан.

*Нэгэн цагт би төөрөлдсөн байсан ч одоо
замаа олсон.*

Харалган байсан ч одоо би харж байна.⁸

“Гэмшсэн нэг нүгэлтний төлөө тэнгэрт илүү их баяр хөөр болох болно.”⁹

Хүнд хөдөлмөр эрхэлдэг хүмүүст амар амгалан ирэх болно.

“Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над уруу ир. Би та нарыг амраа.

“Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно.

“Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн”¹⁰

Гашуудсан хүмүүст ч амар амгалан ирэх болно. Их Эзэн “Гашуудаж буй хүмүүс ерөөлтэй ээ: Учир нь тэд тайвшрал авах болно”¹¹ хэмээн хэлжээ. Бид хайртай нэгнийгээ алдсан үед Сүнсний шивнээгээр Их Эзэний амар амгалангаар дүүргэгдэх боломжтой.

“Надад нас нөгчсөн тэд үхлийг үл амсана, учир нь энэ нь тэдэнд тааламжтай байх болно.”¹²

“Амар амгаланг Би та нарт үлдээнэ. Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. Ертөнцийн өгдгөөс өөр юмыг Би та нарт өгч байна. Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай.”¹³

“Би бол амилалт ба амь мөн. Надад итгэдэг хүн үхэвч амьдарна:

“Амьд бөгөөд Надад итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй.”¹⁴

Энх Амгалангийн Ханхүүг уйгагүй хайдаг хүн бүхэнд амар амгалан ирэх болно. Түүний захиас бол манай



номологчдын дэлхий дахинд хүргэдэг гайхалтай авралын захиас юм. Тэд Есүс Христийн Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн сайн мэдээг тунхагладаг. Номлогчид “Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь”¹⁵ хэмээх амьдралыг өөрчлөх Их Эзэний үгийг заадаг.

Багшийн замаар алхахыг сонгодог хүн бүгдэд амар амгалан ирэх болно. Түүний урилга нь “Ирээд, Намайг дага”¹⁶ гэсэн элэгсэг гурван үгээр илэрхийлэгдсэн байдаг.

Энх Амгалангийн Ханхүүг бид бүгд магтан дуулцаана,¹⁷ учир нь Тэр дахин ирнэ. Дараа нь “Эзэний алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ.”¹⁸ Мянган жилийн Мессиа Тэрбээр хаадын Хаан, эздийн Эзэний хувьд хаанчлах болно.¹⁹

Есүс Христийг дагахад Тэрээр биднийг гэр бүлүүдийн маань хамт Түүнтэй болон бидний Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдруулахаар хөтлөх болно. Бид зуурдын байдлын бэрхшээлүүд дунд хийсэн гэрээндээ итгэлтэй байж, эцсээ хүртэл тэвчиж чадвал Бурханы бэлгүүдийн хамгийн агуу нь болох мөнх амьдралд хүрэх боломжтой болно.²⁰ Түүний ариун оршихуйд бидний гэр бүл хамтдаа үүрд мөнх байх болно.

Хайрт ах, эгч нар аа, Бурхан та бүхнийг адислаг. Бидний Их Эзэн—Энх Амгалангийн Ханхүүгийн бүх адислалд та бүхэн болон таны хайртай хүмүүс үүрд мөнхөд баясах болтугай. ■

2013 оны Христийн мэндэлсний баярын онцгой цугларалт дээр хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Исаиа 9:6; 2 Нифай 19:6-г үзнэ үү.
2. Матай 19:14.
3. Лук 2:14-ийг үзнэ үү.
4. 3 Нифай 17:7.
5. 3 Нифай 17:8; мөн Матай 13:15; 3 Нифай 18:32; Сургаал ба Гэрээ 112:13-ыг үзнэ үү.
6. 2 Тимот 2:22; мөн 3 Нифай 9:13-ыг үзнэ үү.
7. Иеремиа 8:22; мөн “Залбиръя гэж бодов уу?” дууллыг үзнэ үү. *Hymns*, дугаар 140; “There Is a Balm in Gilead,” *Recreational Songs* (1949), 130.
8. “Amazing Grace,” *Olney Hymns* (1779), дугаар 41; мөн Иохан 9:25-ыг үзнэ үү.
9. Лук 15:7; мөн 10-р шүлгийг үзнэ үү.
10. Матай 11:28-30.
11. Матай 5:4; мөн 3 Нифай 12:4; Сургаал ба Гэрээ 101:14-ийг үзнэ үү.
12. Сургаал ба Гэрээ 42:46.
13. Иохан 14:27.
14. Иохан 11:25-26.
15. Иохан 14:15.
16. Лук 18:22.
17. “We'll Sing All Hail to Jesus' Name,” *Hymns*, дугаар 182-ыг үзнэ үү.
18. Исаиа 40:5.
19. Илчлэлт 19:16-г үзнэ үү.
20. Сургаал ба Гэрээ 14:7-г үзнэ үү.



НҮДЭЭ ОЛСОН ХАРИУЛТ



Би 14 настай багшийн хувьд гэрийн багшлалтад ямар хувь нэмэр оруулж чадах вэ?

Сударуудад дурдагдсанаар, гэрийн багшийн зорилго нь “гишүүн бүрийн гэрээр айлчлан, чанга болон чимээгүй залбирахыг, мөн гэр бүлийн бүх үүргээ гүйцэтгэхийг тэдэнд ухуулах” (С ба Г 20:51) явдал юм. Гэрийн багш нь заахаар томилогдсон хүмүүсээ “. . . харж хандах, мөн тэдэнтэй хамт байж мөн бэхжүүлдэг” (С ба Г 20:53). Тэд “сануулж, тайлбарлаж, ухуулж, мөн зааж, Христэд ирэхэд бүхнийг урьдаг” (С ба Г 20:59).

Одоо “Би эдгээр зүйлийг хийж чадах уу?” гэж өөрөөсөө асуу. Хариулт нь тийм юм. Ямар хувь нэмэр оруулж чадахаа хамтрагчаасаа асуу. Тэр чамд цаг хэрхэн тохирохыг мөн гэрчлэлээ хуваалцаж, хичээл зааж, бусад зүйлийг хийхэд тань тусалж чадна. Дараа нь чи айлчилж очдог хүмүүсийнхээ амьдралыг адисалж чадна гэдгээ өөрөө олж харж, амьдралынхаа турш энэ болон бусад санваарын үүргээ биелүүлэхэд Бурханы өгсөн бэлгүүдийг ашиглахдаа өөртөө итгэлтэй болох болно. ■

Би яагаад намайг гомдоосон хүнийг уучлах ёстой вэ?

Бүх хүнийг уучлах зарлиг нь бидний ихэнхийн тэмцэлддэг тэрхүү зарлиг юм. Гэвч бид тэднийг уучлах ёстой, эсвэл бид илүү агуу нүгэлд холбогдож байгаа хэрэг хэмээн Их Эзэн хэлсэн (С ба Г 64:9–11-ийг үзнэ үү). Энэ нь эхлээд бидэнд сайн ойлгогдохгүй байж

болох ч, Их Эзэн Өөртэй нь илүү адил болж, илүү агуу баяр баясгаланг олоход бидэнд туслахаар хичээж байгаа. Хэрэв бид Түүнд ачаагаа үүрүүлж, уур хилэн, хорсол, гомдлоо ардаа орхивол, энэ амьдралдаа амар амгаланг болон мөнх амьдралд агуу адислалуудыг олж

авах болно. Энэ нь цаг хугацаа, нулимс, мацаг, залбирал, санваарын удирдагчидтай зөвлөлдөх, ариун сүм рүү орох зэргийг шаардах ч энэ нь үнэ цэнэтэй зүйл байх болно.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф: “Бид өөрсдийн үзэн ядалт, атаа хорслыг арилгах ёстой. Мөнх бус амьдралын нэг зорилго бол иймэрхүү зан авируудаас зайлсхийж сурах явдал юм. Энэ л Их Эзэний зам билээ.

Уучлагдсан мөн бие биеэ уучилдаг хүмүүс тэнгэрт байдгийг санаарай” гэж хэлсэн (“Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна,” 2012 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 81). ■

Бусдыг уучлах талаар илүү дэлгэрэнгүй үзэх бол Гордон Б.Хинкли, “Forgiveness,” 2005 оны 11-р сарын Лиахона-г үзнэ үү; Жеймс Э.Фауст, “The Healing Power of Forgiveness,” Liahona, 2007 оны 5-р сар, 67–69.

A stylized illustration of a man from the chest up, wearing a dark grey suit jacket, a white dress shirt, and a colorful plaid tie. The background is a light beige color with a subtle pattern. In the top left corner, there is a yellow circular badge with a logo consisting of three overlapping circles in blue, red, and green. The text inside the badge is in Mongolian. A large orange arrow-shaped graphic points from the left towards the center of the page, containing the main title in large black letters. At the bottom left, there is a yellow rectangular box containing a quote in Mongolian.

**НЯМ ГАРГИЙН
ХИЧЭЭЛҮҮД**

Энэ сарын сэдэв:
**Ёслолууд ба
гэрээнүүд**

МЕЛКИЗЕДЕК САНВААР ХҮЛЭЭН АВАХАД БЭЛЭН ҮҮ?

*“Тиймийн тул, санваарыг хүлээн авдаг
тэд бүгд зөрчиж ч үл болох, мөн хөдөл-
гөж ч үл болох, Эцэгийн минь энэхүү
тангараг хийгээд гэрээг хүлээн авдаг
бөлгөө” (С ба Г 84:40).*

Тангараггүйгээр хүлээн авдаг Аароны санваартай адилгүй нь Мелкизедек санваарыг Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн тангарагаар хүлээн авдаг бөгөөд Тэнгэрлэг Эцэг болон таны хооронд хийгдсэн гэрээгээр хүлээн авагддаг. Дараах санаанууд нь Их Эзэний санваарын тангараг ба гэрээнүүдийг илчилсэн Сургаал ба Гэрээ 84:33–44 дээрх гол хэллэгүүдийг ойлгоход тань туслах болно.

ТЭНГЭРЛЭГ ЭЦЭГИЙН ХИЙСЭН ТАНГАРАГ ГЭЖ ЮУ ВЭ?

“Тангараг ба гэрээний боломжуудад зохистой байх нь бидэнд Бурханы бэлгүүдээс хамгийн агуу нь болох мөнх амийг авчирдаг. Энэ бол Мелкизедек санваарын зорилго юм. Бид санваарыг хүлээн авч, мөн ариун сүмийн ёслолуудыг хийж, шинэчилж, гэрээнүүдээ сахиснаар Түүний алдар суугийн бүрэн байдлыг олж авч мөн Түүн шиг амьдарч болохын тулд бидэнд Тэнгэрлэг Эцэг, Елохимийн өгсөн тангараг амлагдсан билээ.

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, “Итгэл ба санваарын тангараг, гэрээ,” 2008 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 61.

ЭНЭ ГЭРЭЭН ДЭХ ТАНЫ ХИЙХ ЗҮЙЛ ЮУ ВЭ?

“Эрэгтэй хүний энэ гэрээн дэх хийх хэсэг нь санваар дахь дуудлагаа эрхэмлэн биелүүлж, Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарч, зарлигуудыг дагах явдал юм [С ба Г 84:33-ыг үзнэ үү].

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972), “Magnifying Our Callings in the Priesthood,” 1970 оны 4-р сарын чуулган дээр хэлсэн үг, 59.

ТА НАРЫН БИЕ МАХБОД ШИНЭЧЛЭГДЭНЭ ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

“Би энэ амлалтыг өөрийнхөө болон бусдын амьдралд биелэгдэхийг харсан. Миний нэг найз номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн юм. Тэр үйлчилж байхдаа өдөр дуусах мөчид, маргаашийг дааж давж гарах хүчтэй байх эсэхтээ эргэлзэн, орондоо арайхийн ордог байснаа надад хэлсэн юм. Тэр маргааш өглөө нь түүний хүч, зориг шинэчлэгдсэн байдгийг олж мэджээ. Та нар үүнийг Их Эзэн Есүс Христийг болон сэргээгдсэн сайн мэдээг гэрчлэхээр зогсох бүрдээ шинэчлэгддэг юм шиг санагддаг ахимаг настай бошиглогчдын амьдралаас харж байсан. Энэ нь санваарын үйлчлэлдээ итгэлтэй урагшилдаг хүмүүст өгөгдсөн амлалт юм.”

Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг, “Faith and the Oath and Covenant of the Priesthood,” Лиахона, 2008 оны 5-р сар, 62.

ИХ ЭЗЭНИЙГ ХҮЛЭЭН АВНА ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?

“Санваарыг зохистойгоор хүлээн авсан эрчүүд Их Эзэн Есүс Христийг хүлээн авдаг, харин Их Эзэнийг хүлээн авсан нэгэн Бурхан Эцэгийг хүлээн авна. Эцэгийг хүлээн авсан нэгэн Түүнд байгаа бүхнийг хүлээн авна. Дэлхий дээрх бүх зохистой эрэгтэй, эмэгтэй хүмүүс мөн хүүхдүүд дээр энэхүү тангараг, гэрээний гайхамшигт адислалууд асгарах болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Расселл М.Нэлсон, “Гэрээнүүд,” 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 103.



ЗАЛУУ ЭМЭГТЭЙЧҮҮД ХЭРХЭН ЭДГЭЭР АДИСЛАЛЫГ ХҮЛЭЭН АВЧ ЧАДАХ ВЭ?


“Санваарын адислалууд нь зөвхөн эрэгтэйчүүдээр хязгаарлагдаагүй юм. Эдгээр адислал нь бас бидний эхнэр, охид болон Сүмийн бүхий л итгэлтэй эмэгтэйчүүд дээр асгардаг билээ. Эдгээр сайн эгч Их Эзэний өргөөний адислалуудыг хүлээн авахын тулд зарлигуудыг дагаж, Сүмд үйлчилснээр өөрсдийгөө бэлтгэж чадна. Их Эзэн Өөрийн хөвгүүдээр дамжуулан олж авч болох бүхий л сүнслэг бэлэг ба адислалыг охиддоо санал болгодог.

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит (1876–1972), “Magnifying Our Callings in the Priesthood,” in Conference Report, 1970 оны 4-р сар, 59.

Хэлхээ судар: Их Эзэнийг хүлээж авах нь

Санваарыг хүлээн авах нь Их Эзэнийг хүлээн авах нэг арга зам юм. Илүү дэлгэрэнгүй суралцахын тулд эдгээр шүлгийг уншина уу: Иохан 13:20 болон Сургаал ба Гэрээ 112:20.

ЭЦЭГТ БАЙГАА БҮХНИЙГ ХҮЛЭЭН АВАХ НЬ: ОРЧИН ЦАГИЙН СУРГААЛТ ЗҮЙРЛЭЛ



Нэгэн залуу эрэгтэй номлолд үйлчлэхээр бэлтгэж байлаа. Эцэг эх нь түүнийг номлолын дүрмүүдээ дагаж, шаргуу ажиллах юм бол номлолыг нь санхүүжүүлэхийг зөвшөөрөв. Тэр зөвшөөрлөө.

Тэр номлолын талбарт очсоныхоо дараа номлолын ажил бодож байснаас нь илүү хэцүү болохыг мэджээ. Шинэ хэл сурах, өөр соёлд дасан зохицох, хүмүүсийн эсэргүүцэлтэй тулгарах нь түүнийг сэтгэлээр унагав. Хамтрагч, номлолын ерөнхийлөгч хоёр нь түүнийг дэмжихийг хичээж байсан ч тэр бууж өгөхийг хүссэн хэвээр байлаа.

Тэр номлолын ерөнхийлөгчдөө гэртээ харихыг хүсэж байгаагаа хэлэв. Түүний номлолын ерөнхийлөгч залуу эрэгтэйн аав руу утасдаж, түүнд хүүтэйгээ ярих зөвшөөрөл олгожээ.

Номлогч аавдаа сэтгэлээр унасан тухайгаа хэлжээ. Түүний аав “Олон жилийн турш ээж бид хоёр чинь чамайг бүрэн цагийн номлолд үйлчлэх энэ өдрийг тэсэн ядан хүлээсэн. Есүс Христийн сайн мэдээг хүлээн аваагүй хүмүүст заах нь ямар чухал болохыг бид мэднэ” гэж хэлжээ.

Хүү нь “Аав аа, номлол таны хувьд ийм чухал гэдгийг би ойлгоогүй байжээ” гэв.

“Энэ бол миний хувьд бүх зүйл” гэж аав нь хэлжээ. “Би бүх л амьдралынхаа турш ажиллаж, бизнесээ босгож, чиний төлөө мөнгө хадгалсан. Миний зорилго бол чамайг элбэг хангалуун өв хөрөнгөөр хангах явдал.”

“Гэхдээ, аав аа “энэ чинь надад таалагдахгүй байгаа зүйлийг өөрчлөхгүй шүү дээ” гэж сануулав.

Аав нь түүний яриаг таслан, “Хэрэв чи хоёрхон жилийн хугацаанд Их Эзэнд үйлчлэн, өөрийгөө батлан харуулж чадахгүй бол би чамд хэрхэн өөрийнхөө бизнесийг хариуцуулан үлдээж чадах билээ?” гэлээ.

Хүү аавынхаа асуултыг тунгаан бодож, түр дуугүй зогсов.

Дараа нь аав нь “Хүү минь, хэрэв чи энэ дуудлагадаа итгэлтэй байж, өөрийнхөө зохистойг харуулах юм бол миний эзэмшиж буй бүх зүйл чинийх байх болно” гэж хэлсэн юм.

Энэ амлалт нөлөөлж, хүү аавдаа зоригтойгоор “Би үлдэнэ ээ” хэмээн хэлжээ.


Хүү үлдэж, итгэлтэйгээр үйлчилсэн юм. Тэрээр номлолын дүрмүүдийг дагаж, шаргуу ажилласан. Тийм ээ, тэр номлолынхоо дараа аавынхаа амлагдсан өв хөрөнгөнөөс, бүр түүнд ногдох ёстой байсан хувь болох аавдаа байсан бүтдийг хүлээн авсан юм.

Далын ахлагч Карлос Э.Эсэй (1926–1999), “The Oath and Covenant of the Priesthood,” Ensign, 1985 оны 11-р сар, 45.

САНВААРААР ДАМЖУУЛАН МИНИЙ ХҮЛЭЭН АВДАГ АДИСЛАЛУУД

Би Бурханы охины хувьд зөв зохистой амьдрах үед Түүний санваараар дамжуулан олон адислал хүлээн авч чадна. Би санваараар дамжин сэргээгдсэн Есүс Христийн Сүмийн гишүүн байж чадна. Миний гэрээнүүдийг шинэчлэхээр мөн надад бүрэн дүүрэн наманчлахад туслахаар Есүс Христийн санваарын хүчээр адислагдсан ариун ёслолоос би хүртэж чадна. Би санваарын адислалуудаар дамжуулан Тэнгэрлэг Эцэгээс хувийн удирдамж авч чадна. Би санваарын түлхүүрийг атгадаг хэн нэгний удирлаган дор онцгойлон адислагдаж, дуудлагаа хийх эрх мэдлийг хүлээн авч чадна. Би энэ эрх мэдлээ бүс-дын амьдралыг адислахын тулд ашиглаж чадна. Би ариун сүмд байдаг санваарын хүчээр дамжуулан Тэнгэрлэг Эцэгтэйгээ илүү олон гэрээ хийж чадна. Би зохистой санваарантай ариун сүмд гэрлэж, хамтдаа зөв шударга байдалд гэр бүлээ өсгөж чадна. Би мөнхийн гэр бүлтэйгээ хамт Тэнгэрлэг Эцэгт байгаа бүхнийг хүлээн авч чадна (С ба Г 84:38-ыг үзнэ үү).

Мелисса Харт, АНУ, Юта



ХАМТДАА ЯРИЛЦ

Ням гарагт тунгаан бодох зүйлс

- Гэрээнүүдээ сахих нь Тэнгэрлэг Эцэгт байгаа бүхнийг хүлээн авахад та нарыг хэрхэн бэлтгэдэг гэж та нар бодож байна вэ?
- Санваарыг “хүртэх” (С ба Г 84:33) болон санваарыг “хүлээн авах” (35-р шүлгийг үзнэ үү) нь хоорондоо ямар ялгаатай гэж та нар бодож байна вэ?
- Сургаал ба Гэрээ 98:11–12 дээрх сургаалууд та нарт “Бурханы ... үг бүрээр амьдрахад” (С ба Г 84:44) хэрхэн тусалж чадах вэ?

Таны хийж болох зүйлс

- Ариун Сүнстэй хамт байхуйц зохистой бай. Сүнслэг өдөөлт нь санваарын сургаалыг илүү сайн ойлгоход та нарт туслах болно.
- Сургаал ба Гэрээ 84:33–44 дээрх санваарын тангараг ба гэрээг чээжил.
- Алма 13 болон Сургаал ба Гэрээ 13; 20; 107; 121 гэх мэт санваарын талаарх нэмэлт судруудыг залбирч судал.



Далын ахлагч,
Ариун сүмийн
алба хариуцсан
гүйцэтгэх захирал
ахлагч
Кент Ф.Ричардс

ИХ ЭЗЭНИЙ ӨРГӨӨНД ОРОХОД БЭЛТГЭХ НЬ

*Ариун сүмийн тухай бодохдоо инээмсэглэ.
Энэ бол хүч ба адислалын газар юм.*

Ариун сүмийн нээлттэй хаалганы өдрөөр би ариун сүм дотор эцэг эхийнхээ ард зогсож байгаа хэдэн охиныг ажиглав. Тэд сүйт бүсгүйн өрөөний толинуудад өөрсдийгөө олж хараад, инээмсэглэлээ. “Та нар ямар онцгой болохоо мөн Тэнгэрлэг Эцэг та нарт ямар их хайртайг сана” гэж эмээ нь шивнэв. Охид бүр гоо үзэсгэлэнтэй, чадвартай, дэлхий дээрх зорилгоо биелүүлэхэд бэлэн болж, итгэлтэй эмэгтэйн хувиар ариун сүмд эргэн ирэх цаг хугацааг төсөөлөн бодож байлаа. Нээлттэй хаалганы өдөрт оролцож байсан хөвгүүд бас ирээдүйнхээ адислал, үүрэг хариуцлагуудыг зэрвэс харсан байв.

Эдгээр хүүхдийн ариун сүмд мэдрсэн зүйлс нь зөв байлаа. Тэнгэрлэг Эцэг та нарыг адислахыг хүсдэг. Та нарыг ариун нандин ёслолуудыг хүлээн авч, ариун нандин гэрээнүүдийг хийж, дагахаар ариун сүмд орох үед Түүний хамгийн агуу адислалууд ирдэг. Та ариун сүмд ороход бэлтгэж мөн бэлэн болох үүрэгтэй.

Ариун сүм нь та нарын амьдралд, ялангуяа бага байгаа үед тань тун чухал юм: Залуу эрэгтэй туршлагатай,

тогтвортой амьдралтай болсон аав, өвөөгөөсөө ч илүү ариун сүмд өөрийнхөө байх ёстой газарт хэрэгтэй байна; мөн амьдралд дөнгөж хөл тавьж байгаа залуу эмэгтэйд ариун сүмийн ёслолуудад оролцсоноос ирдэг сүнс, нөлөө, удирдамж хэрэгтэй байна.”¹ Эдгээр адислалыг бүрэн дүүрэн хүлээн авч, мөн ойлгох боломжтой байхын тулд зүрх сэтгэл, оюун ухаанаа одооноос бэлтгэ. (Матай 13:23; Марк 4:20-ийг үзнэ үү).

Сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авах нь

Хэрэв та нар ариун сүмд ороход бэлтгэх аваас, ариун сүмд “[Түүний] сайн мэдээний бүрэн байдлыг хүлээн авахад бэлэн” (С ба Г 35:12; тодотгол нэмэгдсэн) байх болно. Ариун сүм бол хүч ба адислалын газар. Их Эзэн бошиглогч Иосеф Смитийг болон эртний гэгээнтнүүдийг эцэст нь тэдний ариун сүм барьсан АНУ-ын Огайогийн Көртландад цуглаарх заавар өгсөн юм. “Мөн тэнд та нар тэнгэрийн хүчээр *хишиг хүртэх болно*” (С ба Г 38:32; тодотгол нэмэгдсэн).

Саяхны нэгэн ариун сүмийн

нээлттэй хаалганы өдрөөр нэг төлөөлөгч гэр бүлийнхнийгээ лацдан холболтын өрөөнд тахилын ширээг тойруулан цуглуулав. Тэр тэдэнд Сүмд бидний хийдэг бүх зүйл—хичээл, үйл ажиллагаа, хөтөлбөр, цуглаанууд биднийг ариун сүмийн тахилын ширээнд лацдан холбогдох ёслолуудыг хүлээн авахад бэлтгэдэг хэмээн заасан юм. Ариун сүм бол та нарын мөнхийн аз жаргал, өсөлт хөгжилд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний хамгийн чухал хэсгийг төлөөлдөг.

Бурхантай гэрээнүүд хийхэд бэлтгэх нь

Ариун сүмд орж, гэрээнүүд хийх бэлтгэл тань хурдан үйл явц биш юм. Энэ нь таны баптисм, Ариун Сүнсний бэлгээр эхэлж, залбирал, судраас судлах, дуулгавартай байдал, үйлчлэл зэргээр өсөж хөгжиж байдаг. Чи ариун ёслолд оролцсоноороо долоо хоног бүр цэвэр ариун байдлыг урьдаг. Энэ нь чамайг наманчлалаар дамжуулан өршөөлийг эрэлхийлж, жишгүүдийг дагаж мөн хязгаартай ариун сүмийн эрхийн бичгээ зөв зохистой авч



ГОЛ САНААНУУД

- Та ариун сүмд өөрийнхөө авралд зайлшгүй чухал ёслолуудыг хүлээн авдаг.
- Та өршөөгдөөгүй гэм нүглээсээ ангижирч, цэвэр ариун болсноор ариун сүмд орох ёстой.
- Судрууд дээр хэлсэнчлэн, ариун сүм дэх олон сургаал, ёслол бэлгэдийнх бөгөөд ариун сүмд очих бүрд чинь илүү их зүйл сурах боломжийг танд олгодог.

явж сурах үед тохиолддог. Өсвөр үеийнхний хөтөлбөрүүд чамд туслах хэдий ч, бэлтгэл чинь чамаас шалтгаалах болно; чи *өөрийнхөө* зохистой байдлыг болон *өөрийнхөө* гэрчлэлийг мөн *өөрийнхөө* хөрвөлтийг гүнзгийрүүлж байгаа юм. Аврагчийн Цагаатгал чамд хувийн арга замаар нөлөөлдөг.

Чи сүнслэг байдлынхаа түвшинг нэмэгдүүлснээр ариун сүмд бэлтгэж мөн орох хүсэлтэй болох болно. Тэнд та нар Тэнгэрлэг Эцэгтэйгээ ойртоход шаардлагатай алхмууд болох ёслолуудыг хүлээн авч, гэрээнүүдийг хийх болно. Ариун сүмийн ёслолууд бол “хүн төрөлхтөнд илчлэгдсэн хамгийн дээд өргөмжлөгдсөн ёслолууд юм.”²

Та нар ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах үедээ Эцэгтэйгээ ердөө ганцхан удаа өөрийнхөө төлөө ариун гэрээнүүдийг хийдэг бөгөөд дараа нь амьдралынхаа турш тэдгээрийг дагахаар хичээж чармайдаг. Та нар ариун сүмд орох бүрдээ Түүний Сүнснийг мэдэрч, бусдын төлөө шаардлагатай ёслолуудыг гүйцэтгэж байхдаа нэмэлт илчлэлт ойлголт хүлээн авах болно. Та нар мөнх оршихуйн баталгааг болон гэрээнүүдийнхээ төгсгөлгүй хүчийг ойлгож, хүлээн авах болно. Хэрэв бид мөнх биетэй байгаагүй бол ариун сүм шаардлагагүй байх байсан. Та нар үүрд оршиж мөн “хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд” Тэнгэрлэг Эцэг болон гэр бүлийнхэнтэйгээ хамт байхыг хүсдэг *учраас* ариун сүмд орж, гэрээнүүд хийдэг (Мозая 2:41). Энэ баталгаа та нарын бодгальд өсөж, Ариун Сүнсээр батлагддаг.

Зохистой байх нь

Ариун Сүнсний үүрэг бодитой юм. Тэрээр та нарт зааж, та нарыг цэвэршүүлж мөн Эцэгийн хайрыг



цутгадаг (Ром 5:5-ыг үзнэ үү). Амлаалтын Ариун Сүнс гэдэг нь бүх гэрээ мөнхийнх гэдгийг баталдаг Ариун Сүнсний баталгаажуулагч хүч юм.

Сүнсийг хүлээн авахын тулд та нар цэвэр, ариун болж, өршөөгдөөгүй гэм нүглээсээ ангижирснаар ариун сүмд орох ёстой. Хэрэв дайсан таныг ямар нэгэн байдлаар амжилттай ялан дийлж байгаа бол энэ нь таныг ариун сүмд оруулахгүй байхад, эсвэл ариун сүмд зохисгүй байдлаар ороход уруу татаж байж болох юм.

Ийм шалтгаанаар та бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчтэйгөө таны зохистой байдлын буюу ариун сүмд орох эрхийн бичиг хүлээн авахуйц зохистой байгаа эсэхийг тодорхойлох ганцаарчилсан ярилцлаганд орохоор уригдаж болно. Үнэнч байж, танд туслахыг хүсэж буй түүнд итгэ. Үнэн хэрэгтээ та Их Эзэний өмнө хэр зохистой байгаагаа тодорхойлж байгаа хэрэг юм (С ба Г 109:24-ийг үзнэ үү). Та эхлээд ариун сүмийн эрхийн бичгэн дээрээ гарын үсэг зурах болно. Та Их Эзэний өмнө зохистой байдлаа гэрчилж байна.³

Зохистой байна гэдэг нь та бүр төгс байна гэсэн үг биш. Энэ нь

таны зүрх сэтгэл зөв, та зарлигуудын дагуу амьдарч байгаа бөгөөд өдөр бүр илүү сайн байхыг хүсдэг гэсэн үг юм.

Бэлгэдлүүдээс суралцах нь

Сударууд дээр гардаг шиг, Их Эзэн ариун сүм дотор бэлгэдлүүдийг ашиглан заадаг. Та судруудаас хад, үр, жимс, амьдралын мод болон ариун ёслолын талх, ус гэх мэт олон бэлгэдлийг олж харж чадна (жишээ нь, 1 Нифай 11; Алма 32; Хиламан 5:12-ыг үзнэ үү). Усанд умбуулалтаар хийдэг баптисм нь шинэ амьдрал, дахин төрөлт, цэвэр ариуныг бэлгэддэг (Ром 6:3–5-ыг үзнэ үү). Бид ариун сүм дотор цэвэр, ариун, гэрэл, тэгш эрхийг бэлгэдэж цагаан хувцас өмсдөг.

Ариун сүмийн зарим бэлгэдэл нь бие махбод болон сүнслэг байдал аль алиныг бэлгэддэг. Жишээ нь, гармент өмсөх нь ариун сүмийн гэрээнүүдийн болон амлагдсан адислалуудын өдөр тутмын бодит сануулагч болж байдаг. Хэрэв гарментийг эрхэмлэн хүндэтгэх юм бол биднийг уруу татаалт, шударга бүс нөлөөнүүдээс хамгаалах болно.

Ариун сүмийн ёслол бүр бэлгэдлийн чанартай байдаг. “Хүнийг ариун жаягаар угааж бас тосолж болно,”⁴ энэ нь албан тушаалаа авахаар бэлтгэгдэж байсан эртний израильчуудын хаад, пристүүдийг санагуулдаг (1 Самуел 10:1; 16:13). Хишиг хүртэхэд ашиглагддаг заавар, гэрээнүүд нь Бурханаас ирэх хүч чадал, амлалтуудаар хувцаслах эсвэл эдгээрийг хүртэх гэсэн утгыг илэрхийлдэг (Лук 24:49-ийг үзнэ үү). Магадгүй хамгийн үзэсгэлэнтэй бэлгэ тэмдэг бол хосууд үүрд мөнхийн мөхөшгүй харилцаагаар холбогддог лацдан холбох ёслол байж болох юм.

Ариун сүмийн амлалтууд баялаг бөгөөд сүр жавхлантай билээ.



Бидний Эцэгийн зөвхөн танд зориулан хадгалсан “агуу халамж” хийгээд “агуу адислалууд” (3 Нифай 10:18) байгаа. Тиймээс ариун сүмийн талаар бодох үедээ инээмсэглэ.

Та хэдэн настайгаасаа үл хамааран Тэнгэр дэх Эцэгийнхээ танд санал болгож буй хамгийн агуу адислалуудыг хүлээн авахад бэлэн байхын тулд шаардлагатай зүйлсийг хий. Та хүүхэд байхдаа “Би ариун сүм харах дуртай. Нэгэн цагт би тэнд очно. . . . Бага байхдаа би өөрийгөө бэлтгэнэ. Энэ миний нандин үүрэг”⁵ хэмээн дуулахдаа мэдэрдэг байсан мэдрэмжиндээ итгэ. Энэ нь таны хувьд үнэн байж болно. ■

ЭШЛЭЛҮҮД

1. Жон А.Видцөү, “Temple Worship,” *Utah Genealogical and Historical Magazine*, 1921 оны 4-р сар, 91-92-ыг үзнэ үү.
2. *Ариун сүмд ороход бэлтгэх нь* (товхимол 2002), 1-ийг үзнэ үү.
3. Иошуа 24:22, 27: “Өөрт нь үйлчлэхээр Эзэнийг сонгосныхоо гэрч нар та нар өөрсдөө болов гэхэд тэд. Бид нар гэрч нар мөн гэлээ.” Дараа нь “Энэ чулуу [бидний хувийн ариун сүмийн эрхийн бичигтэй адил] бидэнд гэрч болох болно; Учир нь бүх үгсийг энэ чулуу сонссон” гэж хэлээд Иошуа нэгэн том чулуу аваад үүнийгээ царс модны дор байрлуулав,
4. *Ариун сүмд ороход бэлтгэх нь* (1).
5. “Би ариун сүм харах дуртай” *Children’s Songbook*, 95).

БИД ЯАГААД АРИУН СҮМҮҮДИЙГ БАРЬДАГ ВЭ?

“Бид ариун сүмүүдийг яагаад барьдаг болон биднээс яагаад ариун сүмийн ёслолуудыг шаарддаг талаар зарим ойлголтыг олж авах ёстой. Дараа нь бид сүнслэг ач холбогдолтой зүйлүүдийн талаар үргэлжлүүлэн заавар авч, энэ талаар ойлголттой болох болно. Бид гэрэл ба мэдлэгийн бүрэн байдлыг олж авах хүртэл энэ нь шат шатаар, дүрэм дүрмээр ирдэг; Энэ бидэнд—бидний хүн нэг бүрийн хувьд агуу хамгаалалт болдог. . . .

“... Сүнслэг байдлыг үүнээс илүү бэхжүүлдэг ажил гэж үгүй. Бидэнд үүнээс илүү хүч чадал өгдөг ажил гэж үгүй. Зөв шударга байдлын илүү өндөр жишгийг биднээс шаарддаг өөр ажил ч гэж үгүй юм.

“Ариун сүмд хийдэг ажил бидэнд хамгаалалт хуяг болно. . . .

“... Хэрэв бид эргэлзэх, харамсах зүйлгүйгээр гэрээнүүдэд орох юм бол Их Эзэн биднийг хамгаалах болно. Бид амьдралын бэрхшээлүүдийг давах хангалттай сүнслэг урмыг хүлээн авах болно. . . .

“Иймээс ариун сүмд ирцгээ, адислалуудаа авцгаа.”

Ариун сүмд ороход бэлтгэх нь (товхимол 2002), 37-г үзнэ үү.



УУЧЛАХ арга замаа олох нь

Бонни Браун

Хэн нэгэн биднийг гомдоох ямар нэгэн зүйл хийсэн үе бид бүгдэд байдаг. Заримдаа энэ шаналлаас ангижрах нь боломжгүй мэт санагддаг. Харин Аврагч гомдол цөхрөл асар их байгаа үед ч гэсэн бүх хүнийг өршөөхийг бидэнд заасан. Өршөөх нь хэцүү байж болох ч биднийг Христэд илүү их ойртуулдаг эдгээр зүйлийг хийснээр, бид өршөөлийг бий болгогч амар амгаланг олж чадна. Хоёр залуу эмэгтэй бусдыг уучилсан туршлагуудаа хуваалцсан юм.

Найзаа уучлах нь

Рэнээ* Бельги дэх шинэ сургуульд шилжиж очин, шинэ найзуудтай болохдоо баяртай байлаа. Гэтэл нэг найз нь асуудал үүсгэх зүйл хийжээ. Рэнээ тайлбарлахдаа:

“Нора гэдэг найз маань найз Кэйтигийнхээ нэрийг ашиглаж фэйсбүк хаяг нээсэн байв. Тэр профайлийг ашиглан, хүмүүсийг сүрдүүлж эхэлсэн бөгөөд хүн бүр энэ бүдүүлэг үйлдэлд Кэйтиг буруутгаж байлаа. Нора сургууль дээр хүртэл миний шашин, зан харьцааны талаар даажигнан, надаар тохуурхаж байв. Би

эдгээр халдлагаас зугтаахыг хичээсэн ч чадахгүй байлаа. Тиймээс би өөр хүүхдүүдтэй нийлж эхэлсэн юм.

“Нора хуурамч профайлийнхаа талаар илчлэх үед хүн бүр түүнд дургүйцэж байв. Нора уучлал гуйж, надад захиа өгсөн ч би түүнийг уучилж чадна гэж бодохгүй байв. Би маш их уурласан байсан юм.

“Би нэг өдөр судар уншиж байгаад, Сургаал ба Гэрээ 64:9–10-ыг тохиолдлоор уншив. ‘Иймийн тул, та нар бие биенээ уучлах ёстойг та нарт хэлнэ би; учир нь ах дүүгийнхээ зөрчлийг үл уучилдаг тэрээр

Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой. Их Эзэн, би-бээр өршөөх түүнийгээ би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана.'

“Би тэр даруй Норагийн тухай бодлоо. Миний хувьд ингэтлээ уурлах нь зөв биш гэдгийг би мэдэж авав. Би Тэнгэрлэг Эцэгтээ залбирч, түүнийг уучлахад надад туслахыг гуйсан юм. Энэ нь амаргүй байсан ч би хичээсээр байв. Би түүнээс өдөр ямархуу өнгөрч байгааг асуусан зурвас илгээх, заримдаа өдрийн хоолон дээр ярилцах зэргээр эхэлсэн юм. Би Норагийн аав дөрвөн жилийн өмнө нас барсныг олж мэдэв. Түүний амьдрал хэцүү байсан ба хүн бүр түүнд дургүй гэж тэр боддог байжээ. Би түүнд уурлахаа больсондоо баяртай байв. Намайг яаж Нораг уучилж чадсаныг Кэйти болон зарим хүн ойлгохгүй байсан ч миний хийсэн зүйл зөв гэдгийг би мэдэж байлаа. Би бас Тэнгэрлэг Эцэг надаар бахархаж байгааг мэдэж байв.”

Рэнээ Бурхан бүх хүнийг уучлахыг бидэнд зарлигласан гэдгийг мэдэж авсан юм. Энэ зарлигийг дагаснаар тэр Нораг өрөвдөн хайрлаж, түүнийг ойлгож эхэлсэн бөгөөд бүрэн дүүрэн уучлах боломжтой болсон.

Ахыгаа нас барах үед амар амгаланг олсон нь

Өсвөр насны согтуу жолооч ба хамт явсан зорчигчдынх нь гаргасан машины ослоор Жанетийн ах амь үрэгдсэн бөгөөд тэр энэ гашуун мэдрэмжээсээ ангижрах хэрэгтэйг мэдэж байсан ч, яаж гэдгээ мэдэхгүй байлаа.

“Намайг юу хамгийн их шааналгасныг хэлэхэд хэцүү байв. Эдгээр ухаангүй өсвөр үеийнхэнд

уурласнаас уу эсвэл ахыгаа буцааж авчрах гэсэн миний чин сэтгэлийн хүслээс үү? Миний амьдралд ийм том нөхөж баршгүй гарз тохиолдож байсныг би бодож ч чадахгүй байв. Би олон цагийн турш хичээнгүйлэн залбирч байснаа санаж байна. Миний хүсэж байсан бүх зүйл бол Нафаныг буцааж авчрах байсан юм.

“Би Нафаны үхэлд буруутай хөвгүүдийн хүлээх хариуцлаганд гашуудаж байв. Учир нь тэд маш их гэмшсэнийг би мэдэж байв. Гэхдээ уур, дургүйцэл их хүрч байв. Тэднийг буруутгах амархан байлаа. Би оюун ухаандаа эдгээр залуу эрэгтэйг уучилсан гэж хэлсэн боловч ослын талаар бодох үед миний уур хүрсээр л байв. ‘Би ер нь эдгээр залуу эрэгтэйг хэрхэн уучилж чадах вэ? Хэрэв уучилсан бол уучилснаа хэрхэн мэдэх вэ?’ хэмээн би үе үе өөрөөсөө асууж байв,

“Би олон зуун удаа залбирч, чин сэтгэлээсээ мацаг барьж, маш их судалж бас тунгаан бодсоны дараа л тэднийг үнэхээр уучилснаа мэдэрсэн юм. Би нэг өдөр тунгаан бодож байсан үеэ санаж байна. Би ‘тэднийг уучилсан гэж бодсон. Бид яахан уучилж чадахгүй байх билээ? Хүн бүр алдаа гаргадаг, тэднийг шүүх би хэн билээ? Би өс санаж, хорссоноороо хэзээ ч юуг ч шийдвэрлэж чадахгүй, тиймээс би уучилж байна.’ Энэ мэдрэмж гайхалтай байсан! Би тэр залуу эрэгтэйчүүдийг үнэхээр уучилсан эсэхээ мэдэхийг хүссээр л байв. Дараа нь тэр цаг ирсэн юм. Би Нафанд тохиолдсон зүйлийг өөрчилж чадахгүй ч, уурлахаасаа илүү өршөөл, хайраар үйлдэхийг сонгож чадна.

Жинхэнэ уучлал нь цаг хугацаа, хүч чармайлт шаарддаг гэдгийг Жанет олж мэдсэн. Аврагч “Надад ойр байгтун, мөн би та нарт ойр

байх болно” (С ба Г 88:63) гэжээ. Жанет мацаг барилт, залбирал, судар судлах болон бусад хичээл зүтгэлээр дамжуулан Их Эзэнд ойртсон юм. Бид үүнтэй адил үйлдсэнээр, бидний уур хилэн ба шарх амар амгалан, уучлалын мэдрэмжүүдээр солигдож чадна.

Хайраар дүүргэгдэв

Жанет, Рэнээ хоёрт тохиолдсон шиг уучлал нь нигүүлсэл, ойлголт, тэвчээрийг мэдрэхэд бидэнд тусалдаг. Бид бусдыг уучлах үед Их Эзэн биднийг Өөрийн цэвэр хайраар дүүргэж, мөн бид Түүнтэй илүү адил болох болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

**Нэрийг өөрчлөв.*



ЦЭВЭР ХАЙР

“Христийн цэвэр хайр бусдыг шүүмжлэхэд нөлөөлдөг үзэн ядалт, атаа хорслын мэдрэмжийг арилгаж, Тэнгэрлэг Эцэг биднийг хардгийн адилаар бусдыг харах боломжийг бидэнд өгдөг. Бид бүгд сул дорой, төгс бус хэдий ч өөрсдийнхөө төсөөлдгөөс ч илүү их чадвар, үнэ цэнэтэй. Бурхан бидэнд маш их хайртай учраас бид ч бас бие биеэ хайрлаж, уучлах ёстой.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна,” 2012 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 80

НАРНЫ ГЭРЛИЙГ ТҮГЭЭ

Инээмсэглэл сайхан дэлхийг
бүтээж чадна. Хэн нэгний
өдрийг гэрэлтүүл.

(Матай 5:14-16-г үзнэ үү.)

ДУУ ХӨГЖИМ

миний амьдралд

Би алдаа гаргахаасаа айсан учраас төгөлдөр хуур тоглохоо больсон юм. Одоо надаг айдсаа даван туулах боломж олгосон.

Сабрина дэ Соуса Тэйкшэра

Хүүхэд ахуй наснаасаа миний мөрөөддөг байсан зүйл бол төгөлдөр хуур тоглох байсан юм. Намайг 12 настай байхад нэгэн гайхалтай Сүмийн гишүүн надад төгөлдөр хуур тоглохыг зааж өгч билээ. Дараа нь би заваасаа даралтат хөгжим бэлгэнд авав. Гэвч ариун ёслолын цуглаан дээр тоглох гэж хичээхдээ сандардаг байсан болохоор тоглох хүсэл маань замхарч эхэлсэн юм. Би олон удаа алдаж, ичдэг байсан тул дахин тоглох хүсэлгүй болов. Би хангалттай их дадлага хийж, бараг төгс тоглодог болсныхоо дараа л дахин тоглоно гэж өөртөө хэлж билээ. Гэвч миний урам хугарч, даралтат хөгжмөө зарж, авьяасаа дарагдуулсан юм.

Олон жилийн дараа нэг ням гарагт төгөлдөр хуур тоглох хүн байсангүй. Манай тойргийн төгөлдөр хуур тоглодог байсан эгч шилжсэн байв. Би гишүүдийг төгөлдөр хуур эсвэл даралтат хөгжимгүйгээр дуулж байгааг хараад, Сүнс надад бишоптойгоо ярилцах хэрэгтэй гэж шивнэж байгааг мэдэрсэн юм. “Би тоглож болох уу?” гэж би асуулаа. Тэр зөвшөөрөв.

Төгөлдөр хуур тоглолгүй олон жил болсны эцэст би алдаа гаргахаасаа айх айдсаа даван туулсан

билээ. Би тоглохоо болиод удсан ч тоглож чадсан маань намайг гайхшируулав. Би зарим нот дээр алдаж байсан ч олон алдсангүй. Тэр туршлага нь ням гараг бүр төгөлдөр хуур тоглохыг бишопдоо амлах хүч чадлыг надад олгосон юм.

Би долоо хоног бүр давтаж, төгөлдөр хуурт дахин дурлахаар суралцаж байна. Би дадлага хийх бүрдээ гэр оронд маань Сүнс байгааг хүчтэй мэдэрдэг. Заримдаа намайг тоглох үед гэрийн ажил хийж байгаа гэр бүлийнхэн маань хамт дуулдаг. Бид дуулал дуулж, нэгдмэл болдог.

Тойргийн олон гишүүн миний өсөж буйг ажиглаад, баяр хүргэж байлаа. Би тойргийнхоо цуглааны сүнслэг байдалд хувь нэмрээ оруулж байгаадаа талархаж байна. Мөн орхичихсон байсан авьяасаа эргүүлэн олж авсандаа талархалтай байдаг.

Би төгөлдөр хуур хөгжимд талархаж сурсан бөгөөд үүний авчирдаг амар амгалан нь гайхалтай зүйл юм. Бид тэнгэрт ийм маягийн хөгжим сонсох байх гэж би найддаг. Мөн би селестиел найрал дуунд төгөлдөр хуур тоглож байх ч юм бил үү, хэн мэдэх билээ? ■

Зохиогч нь Бразилд амьдардаг.



Далын
ахлагч
Хуан А.Юсэда

Би **найзтайгаа** ярьж байгаа юм шиг л Бурхантай ярьдаг байв

“Залбир, Тэр амьд; ярь, Тэр сонсдог”
(Children’s Songbook, 12).

Би бага байхдаа маш ичимхий байсан бөгөөд найзтай болох нь миний хувьд хэцүү байдаг байв. Би айдас, ичимхий байдлаа даван туулах гэж Бурханд маш их залбирсан. Би найзтайгаа ярьж байгаа юм шиг л Түүнд хандан залбирдаг байв. Үүнийг хэрхэн хийхийг хэн ч надад заагаагүй. Би зүгээр л үнэхээр хэн нэгэнтэй ярилцах хэрэгтэй байсан юм. Надад найз нөхөд байгаагүй. Тиймээс би Түүнтэй ярилцсанаар нэг найзаа олсон юм.

Дараа нь би номлогчидтой уулзсан. Тэд надад Мормоны Ном өгсөн бөгөөд бид үүнийг уншиж эхлэв. Би 3 Нифай 17-г уншиж байгаад, Есүс бяцхан хүүхдүүдийг авч, тэдний төлөө залбирсанд үнэхээр их сэтгэл хөдөлж билээ. Энэ бол залбирах зөв арга зам байсныг би мэдэж байв.

Би Есүс Христийн залбирч байгаа бүхий л судруудыг уншихаар шийдсэн юм. Лук 3:21-д бичсэнээр, Иохан





Түүнд баптисм хүртээсний дараа Есүс Тэнгэрлэг Эцэгтээ залбирсан бөгөөд тэнгэр нээгдсэн юм. Би үүнийг уншаад, тэнгэрийг нээх тийм арга замаар залбирахыг хүсэж байгаагаа ойлгосон.

Заримдаа би ядарсан үедээ залбирмааргүй санагддаг. Харин дараа нь би Есүсийн яаж залбирсныг санадаг. Тэнгэр миний төлөө нээгдэж болохын тулд би залбиралдаа үнэнч, чин сэтгэлээсээ ханддаг.

Заримдаа би өөрийгөө илүү сайн илэрхийлж чадах үгсийг бодож олж чаддаггүй учраас миний залбирлууд богинохон болдог юм шиг санагддаг. Би дотроо маш их зүйл мэдэрдэг ба “Та миний юу хэлэхийг хүсэж байгааг мэднэ. Надад туслаач” гэж хэлдэг.

Заримдаа би хоолоо адислахаар залбирах үедээ ийм жижиг залбирлаар хүртэл тэнгэр нээгддэгийг

санадаг. Би дэлхийн талаар мартахыг хичээж, Тэнгэрлэг Эцэгтэйгээ холбогдохыг хичээдэг. Би маш даруухан арга замаар зүрх сэтгэлээсээ ундрган гардаг зүйлсийг хэлдэг.

Надад амар амгалан, тайтгарал мэдрэгдэх үед тэнгэр бас миний төлөө нээгддэгийг би мэднэ.

Номлогчид манай гэр бүлийнхэнд сайн мэдээний талаар заасны дараа ээж, эгч, бид гурав баптисм хүртсэн. Гэхдээ аав, ах болон бусад эгч маань Сүмд нэгдээгүй юм. Би аавыгаа Сүмийн гишүүн болоосой гэж үнэхээр их хүсэж байлаа. Би мацаг барьж, өдөр бүр аавыгаа сайн мэдээг хүлээн авч, баптисм хүртэхийн төлөө залбирч байв.

Би аавынхаа төлөө залбирах хэрэгтэй гэдгээ мэдэж байсан ч

бас Бурханы хариултыг хүлээх хэрэгтэйг мэдэж байлаа. Заримдаа Тэр “Үгүй, хараахан болоогүй” гэж хэлдэг. Эцэст нь аав маань сайн мэдээг сонсож, ойлгож, баптисм хүртсэн юм.

Хэрэв ээж чинь юм уу аав чинь Сүмийн гишүүн хараахан болж амжаагүй байгаа бол өөрийн найз—Тэнгэр дэх Эцэгтэйгээ ярилц. Аав эсвэл ээжийнхээ зүрх сэтгэлд хүрэхийг Түүнээс хүс. Түүнтэй даруухнаар мөн үнэнчээр, чин сэтгэлээсээ ярилц. Тэгээд тайвшир. Бүх зүйл Түүний гарт байдаг. Тэр аливаа зүйлсийг хэрхэн хийхээ мэддэг. Тэр танай аав, ээжийг та нараас илүү сайн мэддэг. Тэр тэнд хэрхэн хүрэхээ мэддэг.

Бүү санаа зов. Танд найз байгаа. Зүрх сэтгэлээсээ залбир. Тэнгэрлэг Эцэг та нарыг сонсох болно. Тэнгэр нээгдэнэ. Тэр та нарыг мэддэг бөгөөд та нарыг адислах болно. ■

ТА ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Танай гэр бүлийн хэн нэгэн Сүмийн гишүүн биш бол яах вэ? Эсвэл танай гэр бүл ариун сүмд лацдан холбогдоогүй бол яах вэ? Энд ахлагч Юсидагийн хийсэн, та нарын ч бас хийж чадах таван зүйлийг жагсаав:

1. Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч, ярь. Тэр бол та нарын найз.
2. Гэр бүлийнхээ төлөө залбир.

3. Тэнгэрлэг Эцэгтээ итгэ. Тэр та нарын гэр бүлийг мэддэг бөгөөд тэдэнд хэрхэн туслахаа мэддэг.
4. Тайвшир, бүү санаа зов. Бүх зүйл Тэнгэрлэг Эцэгийн гарт байдаг.
5. Тэнгэрлэг Эцэг та нарыг мэддэг бөгөөд та нарыг адислах болно гэдгийг ойлго.

Энэ түүх 1889 оны 5-р сард болсон юм.

Анна Матилда Андэрсэн ээж болон эгч Аида Анартайгаа хар шүхрэн дор нэг нэгэндээ наалдан зогсоно. Тэр нүднийхээ булангаар галт тэрэг ирж байгааг харж байв. Тэр дагжин чичирч байлаа. Энэ галт тэрэг түүний Шведээс Америк руу хийх аяллыг эхлүүлэх байв.

“Сайн байгаарай, ахлагч Карлсоны үгэнд ороорой” гэж Аннагийн ээж шведээр шивнэн хэлэв. Тэр охидоо чанга тэврэв. Ахлагч Карлсон бол Аннаг найман настай байхаас Шведэд 3 жилийн турш үйлчилсэн номлогч байв. Түүний гэр бүлийнхэн Нэгдсэн Улсын Айдаход байдаг бөгөөд гэр бүлийнхэн дээрээ очих цаг нь болсон байв.

Ээж нь Анна, Аида хоёрыг Шведэд үүссэн хавчлага дарамтаас холдуулан, Америк руу явуулахаар шийдвэр гаргах үед ахлагч Карлсон тэднийг харж хандаж явахаар санал болгосон байжээ. Тэр одоо галт тэрэгний хажууд зогсож байна. Тэр хоёр охиныг өөр дээрээ ирүүлэхээр дуудан, толгой дохиж байна. Аида ээжийгээ чанга тэврэн, урагш алхав. Гэвч Анна ард зогссоор л байлаа.

“Би танд хайртай.”
“Би таныг санах болно”
гэж Анна хэлэв.

“Би ч гэсэн чамайг санах болно. Одоо анхааралтай сонс. Хэрэв чи хүмүүсийн юу ярьж байгааг нь ойлгохгүй тийм газар очих юм бол Тэнгэр дэх Эцэгтээ залбирахаа битгий мартаарай. Учир нь Тэр чамайг ойлгож чадна.”

Ээжийнхээ хэлсэн үгийг бодсоор Анна галт тэргэндээ орж, Аида, ахлагч Карлсон хоёрын хажууд суув. Тэр анх удаа галт тэргэнд сууж байгаадаа баяртай байсан ч ээжийгээ сүүлийн удаа харахыг хүсэж байлаа. Хүмүүсийн царайг харахад галт тэрэг түүний хувьд хэтэрхий өндөр байсан ч цугларсан олны дээгүүр барьсан ээжийнхээ хар шүхрийг хараад, тэр инээмсэглэв. Энэ нь ээж нь түүнийг харж байгааг түүнд сануулсан юм.

Галт тэрэг утаа суунаглуулан хөдлөв. Галт тэрэг эхэндээ удаан явж байсан болохоор ээж нь галт тэргийг даган гүйж байлаа. Хар шүхэр Анна руу далласаар байв. Гэвч удалгүй хар шүхэрний бараа тасарлаа. Анна цонхны шилийг налан, ирээдүйнхээ талаар гайхан бодно.

Хэдэн долоо хоногийн дараа Анна өөр галт тэрэгний цонхны шилийг налан суужээ. Энэ галт тэрэг түүнийг Ютагийн Солт Лэйк хот руу хүргэж байв. “Америк Шведээс



Аннагийн аялал

Бодит түүхээс сэдэвлэв

Жэссика Ларсэн



өөр харагдаж байна шүү, *тийм ээ?*” гэж тэр Аидад хэлэв.

“*Тийм ээ*” гэж Аида шведээр хариуллаа. “Тэхдээ Америк одоо бидний гэр болсон шүү дээ. Бид хангалттай шаргуу ажиллаж чадвал ээжийгээ бас энд авчирч чадна.”

Ээжид нь өөртөө тасалбар худалдаж авах хангалттай мөнгө байгаагүй ажээ. Ютагийн Огденд амьдардаг нэгэн гэр бүл Аидагийн Америкт очих зардлыг төлсөн байв. Аида тэдний ферм дээр үлдэж, мөнгөө төлөхийн тулд ажиллах хэрэгтэй байсан юм. Харин Анна Солт Лэйкт байдаг нагац эгчтэйгээ хамт амьдрахаар болсон билээ. Аннагийн нагац эгч хэдэн жилийн өмнө Ютад ирчихсэн байсан бөгөөд Аннаг ирж байгааг ээж нь түүнд захиагаар хэлсэн байв.

Тэд галт тэрэгнээсээ буугаад, Дани хүрэх Хойд тэнгисийг гатлах усан онгоцонд суусан байлаа. Дараа нь тэд Атлантын далайг гаталж, Нью Йорк хотод буухаасаа өмнө Англи ба Ирланд руу завиар явав. Анна

аяллынхаа 15 өдрийн ихэнхэд далайн өвчнөөр өвджээ. Юта руу явах Нью Йоркийн галт тэргэнд суух үед түүний өвчин намдсан байв.

“Ютагийн Огден” гэж кондуктор зарлав. Анна англи хэл мэдэхгүй хэвээрээ л байв. Гэвч тэр хотын нэрийг хараад танив. Түүний дотор палхийгээд явчихав. Ахлагч Карлсон босож зогсоод, өөрийнхөө болон Аидагийн цүнхийг авах үед бүр хүнд санагдав.

“Чи явах ёстой юм уу?” тэр эгчээсээ асуув.

“Тийм ээ” гэж Аида намуухан хариулав. “Санаа зовох хэрэггүй дээ. Чамайг Солт Лэйкт очиход нагац эгч тэнд байх болно.”

Анна Аида, ахлагч Карлсон хоёрыг түүний гэр бүлийнхэнтэй галт тэрэгний буудал дээр уулзаж байгааг харав. Тэд Аидаг ферм дээрх шинэ гэр рүү нь хүргэх бүхээгтэй тэргэнд суулгаад, дараа нь өөрсдөө Айдоха руу явав. Анна үнэхээр ганцаардаж байв.

Галт тэрэг Солт Лэйкийн галт тэрэгний буудал дээр зогсох хүртлээ харанхуйд тачигнасаар алга болсон



юм. Бараг шөнө дунд болж байв. Анна цүнхээ барин, төмөр замын тавцан дээр хөл дээрээ дэвхцэн байлаа. Тэр ядарсан нүдээрээ нагац эгчийгээ хайна.

Гэвч тэнд түүнийг хүлээж байгаа хэн ч байхгүй байв.

Аннаг айдас нөмрөн авав. Тэрээр хараагүй өнгөрсөн байх вий хэмээн төмөр замын тавцанг дахин гүйлгэн харав. Тэр нүд салгахгүй харанхуйд харж байлаа. Тэр сүүмийсэн гэрэлд хүмүүсийн царайг таних гэж хичээж байв. Гэвч нагац эгч нь тэнд байсангүй.

Танихгүй хүмүүс түүн дээр очиж, түүнд асуултууд тавьж байлаа. Анна тэднийг туслахыг хүссэн байх гэж бодов. Гэвч тэр тэдний юу хэлж байгааг ойлгосонгүй.

Тэр амьдралдаа хэзээ ч ийм их айж байсангүй. Шведэд ангийнхан нь түүний шинэ итгэлийг дооглож, тохуурхаж байхад хүртэл ингэж айж байгаагүй юм. Нью Йорк орох завин дээр бөөлжиж байхдаа ч ингэж их айж байсангүй. Ээждээ баяртай гэж хэлж байхдаа ч ингэж их айж үзээгүй байв.

Анна нүдээ аниад, ээжийнхээ хэлсэн: “Тэнгэр дэх Эцэгтээ хандан залбирахаа битгий мартаарай. Учир нь *Тэр* чамайг ойлгож чадна” гэсэн үгсийг санах.

Анна төмөр замын тавцан дээр чемоданыхаа дэргэд өвдөг сөхрөн суугаад, амьдралдаа урьд өмнө залбирч байгаагүйгээр шаргуу залбирав. Тэр Тэнгэрлэг Эцэгтээ хандан, шведээр ярьдаг бас түүнийг ойлгож чадах хэн нэгнийг түүн рүү илгээхийг хүсэн, залбирч байлаа.

Тэр залбирч дуусаад, дээшээ харав. Хэн ч түүнийг хүлээгээгүй хэвээрээ байв. Харин тэр галт тэргэнд цуг явж байсан герман гэр бүлийг харсан байна. Тэдний ээж нь дагаад яваарай гэж толгойгоо дохив. Анна уйлсан хэвээрээ цүнхээ гартаа бариад, хөлөө чирэн, тэднийг дагажээ.

Тэр ариун сүмийн талбайн барилгын урд хаалга хүртэл тэднийг дагасан байна. Тэр үзэсгэлэнтэй сайхан ариун сүмийн баригдаж байгаа газрыг харав. Дараа нь Анна гэнэт ойр хавьд хурдан алхах хөлийн

чимээ сонсжээ. Ирж буй бүх цагаачдыг анхааралтай ажигласаар нэгэн эмэгтэй тэдний өөдөөс яаран ирж байв. Тэр эмэгтэйн харц герман гэр бүлдээр тусав. Тэгээд тэр Аннаг анхааралтай гэгч нь ажиглав. Аннаг дээшээ харахад эмэгтэй зогсоод, ширтэн харав. Анна дотроо итгэж найдан бас ширтэн зогслоо.

Анна түүнийг танилаа! Тэр ердөө нэг жилийн өмнө Юта руу явсан Ням гаргийн ангийн багш нь байв. Тэр түүнийг танилаа!

Багш нь түүнийг гартаа чанга гэгч нь тэврэв. Тэр Аннагийн нулимсыг арчиж, “Би дахин дахин сэрээд байсан” гэж шведээр шивнэн хэлжээ. Ирж байгаа цагаачдын дүр төрх миний оюун санаанаас гарахгүй байв. Би эргээд унтаж чадсангүй. Миний мэддэг хэн нэгэн энд байгаа эсэхийг мэдэхээр ариун сүмд ирж үзэх мэдрэмж надад төрсөн юм. Тэр Аннагийн гараас хөтлөөд, гудамж уруудан явав. “Одоо хоёулаа хамт явъя.”

Анна хожим нь түүний нагац эгч, ах хоёр Солт Лэйкээс нүүснийг, бас ээжийнх нь захиаг хүлээн аваагүй болохыг мэджээ. Түүний багш тэдэнд хэл хүргэж, тэд 4 өдрийн дараа Аннаг авахаар ирсэн байна. Эцэст нь Аида, Анна хоёр ээжийгээ бас Америк руу авчрах боломжтой болсон юм.

Харин одоо энэ нь хамаагүй. Анна багшийнхаа гэр рүү явж байхдаа “Тэнгэрлэг Эцэг миний гуйснаас хамаагүй *ихийг* өглөө гэж боджээ. Би ердөө л намайг ойлгож чадах хэн нэгнийг явуулаач гэж гуйсан, харин Тэр миний *таньдаг* хэн нэгнийг явуулсан. ■

Зохиогч нь АНУ-ын Аризонад амьдардаг.

ГЭР БҮЛИЙНХЭЭ БААТРУУДЫГ ОЛ

Эцэг эх эсвэл өвөө эмээгээсээ гэр бүлийнхээ түүхийг ярьж өгөхийг хүс. Чи гэр бүлийнхээ өнгөрсөн үеэс баатар олж болох юм.



Тэнгэрлэг Эцэг миний залбирлуудыг сонсож, хариулдаг



**Жорж Р., 9 настай,
АНУ-ын Нью Мехико**

Тэнгэрлэг Эцэг маш олон удаа миний залбирлуудыг сонсож мөн хариулсан билээ. Үүнтэй холбоотой хамгийн анхны дурсамж намайг дөрвөн настай байхад болсон юм. Би тоглохыг хүссэн өрдөг тоглоомуудаа алга болгочихсон байв. Тиймээс би өрөөндөө ороод, залбирахаар өвдөг сөгдлөө. Надад тоглоомуудаа олоход туслахыг Тэнгэрлэг Эцэгээс гуйв. Миний залбирал тэр дороо хариулагдаж, би хажуугийн өрөөнөөс өрдөг тоглоомуудаа олов.

Надад тохиолдсон хамгийн гайхалтай мөчүүдийн нэг нь гэр бүлийнхэнтэйгээ хамт залбирсан залбирал маань хариулагдсан явдал юм. Миний үеэл Крисчин номлолоо дуусгаад, хэдхэн сарын дараа уулын хавцлын зам дээр шөнийн цагаар машинтайгаа явж байжээ. Тэр өөр нэг машинтай

мөргөлдөв. Нөгөө жолооч зүгээр байсан ч манай үеэл нисдэг тэргээр эмнэлэгт хүргэгдсэн юм.

Крисчиний бүх бие хүнд гэмтсэн байлаа. Тэр ухаан алдсан байсан ба эмч нар түүний ухаан орох эсэхийг мэдэхгүй байв. Манай гэрийнхэн мацаг барихаар шийдэв. Эцэг эх, эгч нар, өвөө эмээ, нагац, авгууд болон бүх үеэл Крисчиний төлөө ээлжлэн мацаг барьж байлаа. Би хичээлтэй өдрөө мацаг барив. Би багшдаа болон ангийнхандаа яагаад тэр өдөр хоол идэхгүй байснаа тайлбарлах ёстой болов. Би үеэлийнхээ төлөө мацаг барьж байсан учраас нэг өдөр хоолгүй явах нь надад үнэхээр асуудал болоогүй юм.

Тэнгэрлэг Эцэг бидний залбирлуудад хариулж, Крисчин эцэст нь ухаан орсон юм. Түүний чадварууд өмнөх шигээ бүрэн дүүрэн сэргээгүй ч тэр зарим талаараа сайжрав. Крисчинд бүрэн эдгэрэхэд удаан хугацаа шаардлагатай гэдгийг би мэднэ. Бид түүний төлөө үргэлжлүүлэн залбирч байгаа. Тэнгэрлэг Эцэгийн тусламжаар бүх зүйл боломжтой. ■

ТАНД ЗОРИУЛСАН АСУУЛТУУД

Тусламж хэрэгтэй ямар зүйлс танд байна вэ? Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярилцах тухай санаарай.

Ирээд, Намайг дага

(Хялбаршуулсан)

Үг: Жон Николсон
Ая: Самуел МкБөрни

Даруухнаар ♩ = 69-76

С F C F C

1. “На - майг дага” гэж Ав - рагч хэл - сэн
2. “На - майг дага” гэх эн - гийн үг - сээс
3. Энэ хор - воо дээр Түү - нийг дага гэх
4. Энэ амьд - рал - даа Эзэ - ний ади - лаар

А7 Dm G C

На - рийн бө - гөөд шу - луун за - маар
Нар - ны ту - яа мэт ү - нэн гийнэ.
Эд - гээр үг - сийг ойл - гоод л зог - сох уу?
Эг - нэш - гүй хай - рыг дага - ваас бид

Cm Gm D7 G

Түү - нийг да - ган ал - хах а - ваас
Бодо - ход эн - гийн ч энэ ү - нэн үгс
Ү - гүй, энэ ну - лимст хор - воо дээр
Эр - гэх дэл - хий гээс ха - лих цагт

G7 C D7 G7 C

Бур - ханы хайрт Хүү - тэй хамт байх юм.
Бо - дол са - нааг гий - гүүлж чад - на.
Үү - нээс и - лүүг бид хийх ёс - той.
Эзэ - ний бэл - гийг өв - лөх бол - но.

© 2015 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.

Энэхүү дууг арилжааны бус зориулалтаар Сүмд болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан олшруулж болно.

Энэхүү мэдэгдлийг олшруулж буй хуудас бүрд оруулна уу.

Талантын тухай сургаалт зүйрлэл

Жийн Бингхам

Өөрт нь ажилладаг гурван хүнд хэдэн зоос зээлүүлсэн хүний тухай түүх буюу сургаалт зүйрлэлийг Есүс хуваалцсан юм. Дараа нь тэр хүн алс хол явжээ. Түүнийг явсны дараа хоёр нь шаргуу ажиллаж, зоосоо илүү олон болгож эзэндээ эргүүлэн өгөхийн тулд өөрсдийнхөө зоосыг ашигласан байна. Харин нэг нь зоосоо алдахаас айсан тул үүнийгээ зүгээр л газарт булжээ. Эзэн эргэж ирээд, зээлсэн зооснуудыг нь өсгөсөн тэдгээрийг шагнав. Харин тэрээр зоосоо өсгөхөөр хичээгээгүй түүнээс байгаа зоосыг нь ч авсан ажээ. (Матай 25:14-29-ийг үзнэ үү.)


Энэ сургаалт зүйрлэл дээрх шиг, Тэнгэрлэг Эцэг бидний хүн бүрд ямар нэгэн үнэ цэнэтэй зүйлийг—зооснууд биш ч гэсэн дуулах, хайраа үзүүлэх, гүйх эсвэл бусдад туслах гэх мэт онцгой чадварууд эсвэл авьяасуудыг өгсөн байдаг. Энэ сургаалт зүйрлэл дээрх хүмүүстэй адил та нар эдгээр авьяас чадвараа илүү хөгжүүлэхийн тулд шаргуу ажиллах ёстой!

Та нар авьяасуудаа ашиглаж, хөгжүүлснээр хэрхэн Есүсийн сургаалуудыг дагаж чадах вэ? Та нар үүнийг хийснээр илүү аз жаргалтай болж, бусдад туслах болно. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ИЛҮҮ ИХИЙГ СУРАЛЦ

Авьяас бол зураг зурах авьяас гэх мэт нэгэн онцгой чадвар юм. Харин Есүсийн цаг үед талант гэдэг үг нь маш их үнэ цэнэтэй мөнгөний хэмжээг заадаг байв. Талантын энэ хоёр төрөл юугаараа адилхан байна вэ?



ГЭР БҮЛИЙН АВЬЯАС ШОУ

Авьяасаа үзүүлэхийн тулд нэг шоу төлөвлө.

1. Гэр бүлийнхээ гишүүн бүрд сайн хийдэг зүйлсээ үзүүлэх боломж олго. Жишээ нь чанга унших, амттан жигнэх, хөгжмийн номер тоглох, хошигнох, уран нугаралт хийх эсвэл аз жаргалтай инээмсэглэлээ хуваалцах гэх мэт байж болно.
2. Хүн бүрийг авьяасаа үзүүлж дууссаны дараа гэр бүлийн бусад гишүүнээр тэр хүнээс олж ажигласан ямар нэгэн сайн зүйлсийг хэлүүл.
3. Хөнгөн зууш бэлтгэж, амттай жимсний салат хийхийн тулд хүн бүрийн дуртай жимснүүдийг холь!

ГЭР БҮЛИЙН ЯРИЛЦЛАГА

Гэр бүлийн гишүүн бүрдээ өөртөө байдаг хамгийн багадаа нэг авьяасаа нэрлэхэд тусал. Та нар авьяасаа хөгжүүлэхэд нэг нэгэндээ хэрхэн тусалж чадах вэ? Авьяасаа ашигласнаар хэрхэн бусдад тусалж, Тэнгэрлэг Эцэгтээ талархах талархлаа харуулдаг талаар ярилц. Гэр бүлийн гишүүддээ бие биенийхээ авьяасуудыг олж мэдэж, өдөр бүр чин сэтгэлийн магтаалаар урамшуулахад нь уриал.

Дуу: " 'Give,' Said the Little Stream " (*Children's Songbook*, 236)

Судар: Сургаал ба Гэрээ 46:11

Видео бичлэг: "The Parable of the Talents" -ийг үзэхдээ Biblevideos.org вэбсайт руу орно уу



Өөрийнхөө АВЬЯАСЫГ үзүүл!

Хаана: _____

Өдөр: _____

Цаг: _____

Хөнгөн зууш хийхэд
туслахын тулд ямар
нэгэн жимс авчир!

*Ta liahona.lds.org хаягаар орж, илүү
олон урилга хэвлэж авч болно.*

СУДРЫН ЗӨВЛӨГӨӨ

Судрын түүхийг жүжигчлэн тоглох нь үүний талаар илүү ихийг суралцаж болох хөгжилтэй арга зам байдаг.

1. Энэ түүхэн дэх хэсэг бүрийг жүжигчлэн тоглох хэн нэгнийг томил. Та халат, цаасан зоос гэх мэт энгийн хувцас, эд зүйлсийг ашиглаж болно.
2. Жүжигчдэд уншсан зүйлээ үзүүлэх боломж олгож, шүлэг бүрийн дараа түр завсарлага өгч, хэн нэгнээр түүхийг уншуул.
3. Нэг нэгээр нь ээлжлүүлэхийн тулд түүхийг дахин эхлүүл.

БИДНИЙ ХУУДАС



БИ ЮУ ХИЙХЭЭ МЭДЭХИЙН ТУЛД ЗАЛБИРСАН

Намайг гуравдугаар ангид байхад бид төгсөлтийн үдэшлэг зохиож байлаа. Хүн бүр ус цацаж, хашгиралдаж, муухай үг хэлж байв. Надад таагүй мэдрэмж төрж байсан учраас би залбирав. Ариун Сүнс надад илүү сайхан зүйлсийг мэдрэхэд бас юу хийхээ мэдэхэд тусалсан. Би тэднээс холдож, өөр өрөөнд орлоо. Би аюулгүй байдлыг мэдэрсэн бөгөөд дотроо амар амгаланг мэдэрч байв.

Кристина В., 11 настай, Уругвай



Мормоны Ном бол үнэн. Энэ бол Бурханы үг юм. Мормоны Номон дээр бошиглогчдын түүх, сургаалууд гардаг учраас би унших дуртай. 3.Пэй-чэн, 7 настай, Тайвань




Би Библи дээрх Ноагийн усан онгоцны түүхэнд дуртай бөгөөд бас үүнийг зурж, будаж, тоглох мөн гэр бүлийнхэнтэйгээ хамтдаа байх дуртай. Энэ бол миний зурсан Кертландын ариун сүмийн зураг. Леонардо Ж., 7 настай, Венесуэл



Жоакьюн В., 9 настай, АНУ, Калифорни


Ариун сүмийн карт

Энэ хуудсыг хайчлаад, үүнийг картан дээр нааж, картуудыг хайчил.
Картуудыг олон хувь хувилж авах болон бусад ариун сүмийн картыг үзэх
бол iahona.lds.org вэбсайт руу орно уу.




Украины Киев

2010 оны 8-р сарын 29-нд ерөнхийлөгч
Томас С.Монсон онцгойлон адисалсан



Эл Сальвадорийн Сан Сальвадор

2011 оны 8-р сарын 21-нд ерөнхийлөгч
Хэнри Б.Айринг онцгойлон адисалсан




Гватемалийн Кэтзалтэнанго

2011 оны 12-р сарын 11-нд ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф онцгойлон адисалсан




Миссуригийн Канзас хот

2012 оны 5-р сарын 6-нд ерөнхийлөгч
Томас С.Монсон онцгойлон адисалсан



Бразилийн Манаус

2012 оны 6-р сарын 10-нд ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф онцгойлон адисалсан



Ютагийн Бригам хот

2012 оны 9-р сарын 23-нд ерөнхийлөгч
Бойд К.Пакэр онцгойлон адисалсан




Албэртагийн Калгари

2012 оны 10-р сарын 28-нд ерөнхийлөгч
Томас С.Монсон онцгойлон адисалсан



Хондурасын Тэгусигалпа

2013 оны 3-р сарын 17-нд ерөнхийлөгч
Дийтр Ф.Угдорф онцгойлон адисалсан



Аризонагийн Гилберт

2014 оны 3-р сарын 2-нд ерөнхийлөгч
Томас С.Монсон онцгойлон адисалсан

Бид АРИУН СҮМД ЮУ ХИЙДЭГ ВЭ?

Кэролин Колтон

Ариун сүм бол Их Эзэний өргөө юм. Бид ариун сүмд орох үедээ Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй ойр байгаагаа мэдэрдэг. Бид Ариун Сүнсийг мэдэрч чаддаг. Бид ариун сүмд баптисм зэрэг ариун ёслолуудад оролцдог. Мөн онцгой амлалтууд өгч эсвэл Тэнгэрлэг Эцэгтэйгээ гэрээнүүд хийдэг. Бид нас барсан хүмүүст сайн мэдээг хүлээн авах боломжийг олгож чадна. Анх удаа ариун сүмд орох үед энэ нь маш онцгой өдөр байх болно! ■



БАПТИСМЫН УСАН САН

Та нар 12 нас хүрээд, баптисм хүртэлгүй нас барсан хүмүүсийн төлөө баптисм хүртэж чадна. Энэ усан сан нь Израилийн арванхоёр овгийг төлөөлдөг үхрэн дээр байрладаг.

СЕЛЕСТИЕЛ ӨРӨӨ

Селестиел өрөө бол гайхалтай! Энэ нь биднийг Тэнгэрлэг Эцэгтэй болон Есүс Христтэй хэзээ нэгэн өдөр хамт амьдрах үед хэрхэн амар амгалан, аз жаргалтай байхыг сануулдаг.

БАРУУН ТАЛЫН ГОЛЫН ГЭРЭЛ ЗҮРГИЙГ САМЬЭР
РЭМЭЛЛ ДЭРРИК, ЗҮРГИЙГ БРЭДЛИЙ КЛАК



Чи 12 нас хүрэхээрээ ариун сүмийн эрхийн бичиг авахаар бишоптойгоо уулзаж болно. Тэгээд ариун сүм рүү баптисмын ёслол хийхээр явж чадна.



ЛАЦДАН ХОЛБОЛТЫН ӨРӨӨ

Үүнтэй адил өрөөнүүдэд гэр бүлүүд мөнхөд хамтдаа лацдан холбогдож чадна. Энэ нь тэд зөвхөн энэ амьдралдаа төдийгүй үүрд гэр бүлээрээ хамтдаа амьдарч чадна гэсэн утгатай юм.



Учир нь ариун сүм
Бурханы Өргөө
Хайр ба үзэсгэлэн
төгс газар
Би бага байхдаа
л өөрийгөө бэлтгэнэ
Энэ миний нандин
үүрэг юм.

(“Би ариун сүм харах дуртай,” *Children’s Songbook*, 95)

Дэлхий даяарх ариун сүмүүдийн зургийг үзэх бол liahona.lds.org вэбсайт руу орж, “Gallery” хэсэг рүү орж үзнэ үү.

ЁСЛОЛЫН ӨРӨӨ

Бид үүнтэй адил өрөөнүүдэд Тэнгэрлэг Эцэгийн бидэнд зориулсан төлөвлөгөөний талаар суралцаж мөн Түүнтэй дахин хамт амьдрах боломжийг бидэнд олгодог гэрээнүүд хийдэг. Бид дэлхийн бүтээлт, Адам, Ева болон Есүс Христийн талаар суралцдаг. Хэрэв бид итгэлтэй хэвээр байвал дараагийн амьдралдаа хүлээн авах адислалуудынхаа талаар суралцах болно.

ЮТАГИЙН ОГДЕН АРИУН СҮМИЙН СЕЛЕСТИЕЛ ӨРӨӨ, БАПТИСМЫН УСАН САН,
ЁСЛОЛЫН БОЛОН ХОЛБОЛТЫН ӨРӨӨНИЙ ЗУРГУУД



Би ХЭЗЭЭ НЭГЭН ӨДӨР ТЭНД ОЧНО

Мэри Н., 12 настай, АНУ, Мэрилэнд


Би 12 нас хүрэхээсээ өмнөхөн Ариун сүм рүү явахаар догдолж байж билээ. Би гэр бүлийнхэнтэйгээ ариун сүм дотор ямар байдаг талаар ярилцдаг байсан ба ариун сүмийн дотор талын зургуудыг хардаг байв.

Намайг ариун сүмийн баптисмын ёслол хийхээс хэдэн долоо хоногийн өмнө гэр бүл маань нэгэн онцгой гэр бүлийн үдэш хийсэн юм. Бид зарим өвөг дээдсийнхээ агуу түүхүүдийг сонссон бөгөөд тэдний хаана амьдарч байсныг болон амьдрал нь ямархуу байсныг мэдэж авсан. Бид бүр элэнц өвөө маань аянганд цохиулж байсан ч амьд үлдэж байсныг хүртэл олж мэдсэн юм! Өвөг дээдсүүдийн маань зарим нь Англиас ирсэн байв, тиймээс би дүү нартайгаа хамт Английн тугны зургуудыг будав. Надад өвөг дээдстэйгээ бага ч гэсэн холбоо тогтоосон юм шиг санагдсан.

Ариун сүм гаднах шигээ дотроо ч бас их үзэсгэлэнтэй байлаа. Тэнд байсан хүн бүр сайхан зантай байсан бөгөөд тэнд дулаан, амар амгалангийн сүнс байв. Энэ нь миний өмнө мэдэрч байсан зүйлүүдээс өөр байв. Бүх зүйл төгс байсан. Авга ах маань хараахан баптисм хүртэж чадаагүй байсан зарим гэр бүлийн гишүүний нэрсийг авчирсан байв. Ээж, авга ах,

бид 3 хүлээж байхдаа, 300 жилийн тэртээ дэлхий дээр амьдарч байсан эдгээр эгч маань ямархуу байсан бол гэж төсөөлөн бодож байлаа. Аав минь тэдний өмнөөс надаар төлөөлүүлэн баптисм хүртээхэд онцгой сэтгэгдэл төрж байв.

Цагаан хувцастай хүн бүрийг харах нь надад тэнгэр элчүүдээр хүрээлүүлсэн мэт санагдаж байлаа. Ариун сүм бол дэлхий дээрх тэнгэртэй адилхан юм. ■



АРИУН СҮМД АНХ ОРОХОД БЭЛТГЭХ ТАВАН ЗӨВЛӨГӨӨ

Эцэг эх эсвэл багштайгаа юу хийх хэрэгтэй талаараа ярилц.

Ариун сүмийн доторх өрөөнүүдийн зургийг хар.

Ариун сүмийн эрхийн бичиг авахын тулд бишоптойгоо цаг тохир. Тэр чамтай чиний гэрчлэлийн талаар болон зарлигуудыг дагах тухай ярилцах болно.

Өвөг дээдсийнхээ талаар олж мэд.

Боломжтой бол өмнөөс нь баптисм хүртэж болох өвөг дээдсээ олж мэд! Илүү ихийг мэдэж авах бол FamilySearch.org вэбсайтаар зочилно уу.

Ариун Сүнстэй хамт байхын тулд залбир. Тэгээд анх удаа ариун сүмд очиж байгаадаа баяртай бай.



Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын

ахлагч

Нийл Л.Андэрсэн

Арванхоёр Төлөөлөгчийн
Чуулгын гишүүд
бол Есүс Христийн
онцгой гэрчүүд юм.

Намайг ариун сүм дотор ороход ямар байх бол?



Чи дэлхийн бүтээлтийн талаар суралцах болно.



Чи бидний
Аврагч, Есүс
Христийн тухай
мэдэж авна.



Аврагчийн
амар амгалан
чиний санаа
зовнил, айдсыг
тайвшруулна.



Чи ариун нандин
мэдрэмжийг
мэдрэх болно.



Энэ нь
амьдрал
хэцүү болох
үед чамайг
хүчтэй
байхад
тусална.



Тэргүүн Зөвлөлийн
хоёрдугаар зөвлөх
ерөнхийлөгч
Жэймс Э.Фауст
(1920–2007)

ХОНЬЧИД БА ХУРГАНУУД

Бяцхан найз маань шуурганаас айсан байсан бөгөөд түүний майлах нь сонсогдож байв.

Намайг бүр бага байхад аав маань цөлд ганцаараа явж байсан нэг хургыг олж ирэв. Хонин сүрэг цааш холдож, хурга эхээсээ салсан байсан бөгөөд хоньчин хурга алга болсныг ч мэдээгүй байсан байх. Хурга цөлд ганцаараа амьд гарч чадахааргүй байсан учраас аав хургыг гэртээ авчирсан байв. Хургыг тэнд үлдээсэн бол цөөвөр чононы хоол болох юм уу, өлсөж үхэх нь тодорхой байв. Учир нь хурга дэндүү бага байсан учраас сүүтээр угжих хэрэгтэй байсан юм. Зарим хоньчин эдгээр хургыг “төөрсөн хурга” гэж дууддаг. Аав маань надад энэ хургыг өгч, би хурганы хоньчин болсон юм.

Би хэдэн долоо хоногийн турш үхрийн сүү бүлээсгэж, хургыг угжиж байв. Бид хоёр дотны найзууд болсон. Би түүнд Най гэж нэр өгсөн ч яагаад тийм нэр өгснөө санадаггүй юм. Хурга бойжин өсөж эхлэв. Би хургатайгаа зүлгэн дээр тоглодог байлаа. Бид заримдаа зүлгэн дээр хамтдаа хэвтэж, би түүний зөөлөн ноосон дээр толгойгоо тавьж, хөх тэнгэрийг болон нүүж байгаа цагаан



үүлсийг хардаг байлаа. Би өдөр нь хургаа цоожилдоггүй байв. Хурга гадагшаа гарч, гүйдэггүй байсан юм. Хурга маань удалгүй өвс идэж сурлаа. Би хонь шиг майлж, *май* гэж дуудахад тэр хашааны хаана ч байсан хүрээд ирдэг байв. *Май*.

Нэгэн орой аймшигтай шуурга болов. Би хургаа саравчинд хийх хэрэгтэй байсан ч тэр шөнө мартсан байлаа. Би орондоо оров. Бяцхан найз маань шуурганаас айсан байсан бөгөөд түүний майлах нь сонсогдож байв. Би түүнд туслах хэрэгтэйгээ мэдэж байсан ч орон дотроо аюулгүй, дулаан, хуурай байхыг илүүд үзэв. Би босох хэрэгтэй байсан ч боссонгүй. Маргааш өглөө нь би үхсэн хургаа олохоор явав. Нохой хурганы

майлахыг сонсоод алчихсан байв. Миний сэтгэл маш их өвдөж билээ. Би аавынхаа надад хариуцуулсан зүйлд сайн хоньчин эсвэл үйлчлэгч байгаагүй юм. Аав минь надад “Хүү минь би чамд ганцхан хурга хариуцуулж болохгүй байсан юм гэж үү?” гэв. Аавын маань хэлсэн үг хургаа алдсанаас ч илүү намайг шархлуулж билээ. Бяцхан хүүгийн хувьд би тэр өдөр хэрэв надад дахин ийм боломж олдох юм бол хоньчны үүргээ дахин хэзээ ч үл тоомсорлохгүй гэж шийдсэн юм. . . .

Би жар гаруй жилийн дараа одоо ч гэсэн хариулах хэрэгтэй байсан боловч хариулаагүй, хүүхэд насанд минь байсан хурганыхаа майлж байгаа дууг оюун санаандаа сонссоор байдаг билээ. Аав минь надад “Хүү минь би чамд ганцхан хурга хариуцуулж болохгүй байсан юм гэж үү?” гэв. Хэрэв бид сайн хоньчид байж чадахгүй бол үүрд ямар мэдрэмжтэй байх бол гэж би боддог. ■

*Жэймс Э. Фаустын хэлсэн үгнээс авав,
“Responsibilities of Shepherds,” Ensign,
1995 оны 5-р сар, 46, 48.*

ОЙЛГОЛТ



Мадагаскарын Разологийн гэр бүл аллагдсан нутгийн анхдагчид юм.

Надад анхдагч өвөг дээдэс байгаагүй бол яах вэ?

“Би Сүмийн эртний анхдагчдын итгэл, зоригийг хайрлан, хүндэтгэж явдаг. Миний өөрийн өвөг дээдэс тэр үед далайн чанадад амьдарч байсан юм. Тэд Наувуд эсвэл Винтер Кворттерст тэдэнтэй хамт амьдраагүй. Хэн ч тал газрыг туулж аялаагүй билээ. Гэвч би Сүмийн гишүүний хувьд энэ анхдагчийн өвийг өөрийнхөө өвөг дээдсийн нэгэн адил талархаж мөн бахархан авч үздэг.

“Би орон бүрд амьдарч байгаа итгэл бишрэл, тэсвэр хатуужил, золиослолын түүхээрээ Бурханы хаант улсын хожмын үеийн түүхэнд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа өнөө үеийн Сүмийн анхдагчдыг бас нэгэн адил баярын дуугаар тунхаглаж байна.”

Энэ дугаарт

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

АМЬДРАЛ БА ЭРЧ ХҮЧЭЭР ДҮҮРГЭГДЭВ

Илүү сайн эрүүл мэнд, эрч хүч, сүнслэг удирдамж хүлээн авахын тулд таны хийж эхэлж болох нэг хэвшлийг энд оруулав.



42-р
хуудас

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

52-р
хуудас



МЕЛКИЗЕДЕК САНВААР ХҮЛЭЭН АВАХАД БЭЛЭН ҮҮ?

Сүмийн удирдагчдын заасан эдгээр сургаал нь санваарын тангараг ба гэрээ гэж юу болохыг илүү сайн ойлгоход тань туслах болно.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Аннагийн аялал

Анна Америкт гал тэрэгнээс буух үедээ гав ганцаараа байсан бөгөөд түүний хэлийг ойлгож чадах хэн ч байхгүй байв. Гэвч тэр дараа нь Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг үргэлж сонсож бас ойлгодог гэж хэлснийг санажээ.



66-р
хуудас

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ